

Саяэд Назагат болон КАС Медиа хөтөлбөрөөс гаргав
Монгол телевиз, Хэвлэлийн Хүрээлэнгийн хамт олон орчуулж, хянав.



ХЭРХЭН, ЯАЖ “ЯРИАНЫ ГОЛ СЭДЭВ” / БОЛОХ ВЭ?

Эрэн сурвалжлах сэтгүүлзүйн
гарын авлага



ЭРӨН



Konrad
Adenauer
Stiftung



INVESTIGATIVE
JOURNALISM
MANUAL

4-р бүлэг

44 ХАМГААЛ

Мэдээллийн аюулгүй байдлын
арга техникүүд

3-р бүлэг

26 ТӨЛӨВЛӨ

Төлөвлөгөө гаргах нь

2-р бүлэг

14 АЖИГЛА

Сэдвээ олоод эхэл!

1-р бүлэг

04 ТОДОРХОЙЛ

Эрэн сурвалжлах сэтгүүлч гэж хэн бэ?





АГУУЛГА

8-р бүлэг 102 БИЧ

Бүтээлээ бичих нь

7-р бүлэг 82 АСУУ

Оновчтой асуулт асуух нь

6-р бүлэг 70 УУЛЗАЛТ

Чшш... Ойлголтоос мэдлэг рүү

5-р бүлэг 58 СУДАЛГАА

Судалгаа, судалгаа, судалгаа



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ЭРЭН СУРВАЛЖЛАХ СЭТГҮҮЛЧ ГЭЖ ХЭН БЭ?

Энэ бүлэгт эрэн сурвалжлах сэтгүүл зүйн практик, түүний зорилго, зорилтуудыг тодорхойлж, эрэн сурвалжлах болон уламжлалт сэтгүүл зүйн ялгааг тайлбарлана. Түүнчлэн эрэн сурвалжлах сэтгүүлчдийн ур чадвар, хувийн зан төлөв болон эрэн сурвалжлахад тохиромжтой сэдэв, арга барилыг авч үзсэн болно.

Эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хэрхэн тодорхойлох вэ?

Эрэн сурвалжлах сэтгүүл зүй гэж авлигыг илчлэх, засгийн газар, корпорацийн бодлогыг хянан шалгах, эсвэл нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын чиг хандлагад олон нийтийн анхаарлыг татахуйц аливаа нэгэн сэдвийг сурвалжлагч гүнзгийрүүлэн судалдаг сэтгүүл зүйн өвөрмөц төрлийг хэлнэ. Эрэн сурвалжлах сэтгүүлч, сэтгүүлчдийн баг нэг сэдвийг судлахад хэдэн сар, жилийг зарцуулж болно. Сурвалжлагч засгийн газар, ТББ, бусад агентлагаас тараасан мэдээлэлд найддаг уламжлалт сурвалжилгаас ялгаатай нь эрэн сурвалжлагч хувийн санаачилгаар цуглуулсан мэдээлэлд тулгуурладаг. Санаатай, санаандгүй аль нь боловч нуун дарагдуулсан олон нийтэд хамаатай асуудлыг илрүүлэх нь эрэн сурвалжилгын гол зорилго юм.

Эрэн сурвалжлах сэтгүүл зүйд сурвалжлагч олон нийтийн эрх ашгийг хөндсөн асуудал буюу сэдвийг гүн гүнзгий судлах шаардлагатай болдог. “Олон нийтийн эрх ашиг” гэдэгт тухайн мэдээллийг мэдээгүйгээс бүлэг хүмүүс хохирох эсвэл мэдсэнээр ашиг тус хүртэх (биет болон зөв шийдвэр гаргахад туслах зэрэг) нөхцөлийг ойлгоно. Тухайлбал, ойд оршин суугчид модны зах зээлийн бодит үнэ ханшийг мэдсэнээр мод бэлтгэгч компанийн татуу үнийг өсгөж чадна. Модны үнэ өсөх учраас мэдээж мод бэлтгэлийн салбарынхан энэ мэдээллийг ил болгохыг хүсэхгүй. Энэ мэдээ улсын хэмжээнд нөлөө үзүүлэхгүй бөгөөд чухамдаа “олон нийтийн эрх ашиг” нь “үндэсний эрх ашиг”-аас ихэнх тохиолдолд ялгаатай байдаг. Энэ ойлголтыг зарим үед засгийн газар хууль бус, аюултай, ёс зүйгүй үйлдлийг зөвтгөх буюу чухал асуудлыг сурвалжилж байгаа сэтгүүлчдийг мохоохдоо ашиглах нь бий.

Эрэн сурвалжлах сэтгүүл зүй гэдэг нь эгшин зуурын хэрэг биш. Төлөвлөх, судлах, сурвалжлах гэсэн тодорхой үе шатаар дамжиж, хүчин төгөлдөр стандартын дагуу хөдөлшгүй үнэн, баталгаат байдлыг хангах шаардлагатай байдаг. Эрэн сурвалжлах сэдэв нь сэтгүүлчийн, хэрэв эх сурвалж зөвшөөрвөл, түүний багийн идэвх санаачилгад суурилдаг. Сэтгүүлчид сэдвийн үзүүрээс бариад авбал таамаглал дэвшүүлж, нэмэлт судалгаа төлөвлөн, холбогдох асуултууд сонгон тэдгээрийн дагуу эрэн сурвалжилж эхэлнэ. Ингэж сэдвийн эхний сэжгийг нягталж шалгах ба хариултад өөрсдөө дүн шинжилгээ хийж, батлах замаар нотолгоо бүрдүүлэх ёстой. Эцсийн бүтээлээр цоо шинэ мэдээлэл дэлгэх, эсвэл өмнөх хуучин мэдээллийг цуглуулж, ач холбогдолтой шинэ өнцгөөс нь үзүүлнэ. Нэг эх сурвалж хүртэл нуугдаж дарагдсан мэдлэг, мэдээллийг задалж, ямар ч сонирхолтой баримтыг ил гаргаж болно. Гэхдээ ийм эх сурвалжийн мэдээг туршилт, баримт бичиг болон хүний оролцоотойгоор бусад эх сурвалжаас давхар шалгаж, утга учрыг нь олж илрүүлэх хүртэл эрэн сурвалжилгад тооцохгүй.

Эрэн сурвалжилга нь уламжлалт сурвалжилгатай харьцуулахад илүү их нөөц, багийн ажиллагаа, цаг хугацаа шаарддаг. Ийм төрлийн олон бүтээл амжилттай багийн ажиллагааны үр дүнд гарсан байдаг. Гэхдээ хязгаарлагдмал цаг, хөрөнгө мөнгө, ажилтан буюу мэргэшсэн ур чадвар бүхий бүс нутгийн, жижиг, хэсэг бүлэг хүмүүст зориулсан хэвлэл мэдээллийнхэнд эрэн сурвалжилга хийх нь хүндрэлтэй. Ийм бэрхшээлтэй тулгарсан сэтгүүлч эрэн сурвалжлах ажилд дэмжлэг болохуйц мөнгөн тэтгэмж хайх, гадны мэргэжилтний ур чадварыг дайчлах хэрэгтэй байж болох юм.

Конго улсын сэтгүүлч Сэйж Фидель Гаяла багийн ажиллагааны эерэг сөрөг нотолгоог дэвшүүлж байна:

“Гишүүн бүр нь хэрэгцээтэй чиглэлээр мэргэшсэн, өөрийн байгуулсан жижиг багт ажиллах нь бүтээмжтэй байж болно. Нэг сэтгүүлч газар дээрээс нь эрэн сурвалжилж, нөгөө нь судалгаа хийж, баримт бичиг бүрдүүлэхдээ мэргэшсэн бол гурав дахь нь мэдээ бичдэг байж болох юм. Багаараа хурдтай ажиллаж, мэдээг цаг тухайд нь шуурхай хүргэх боломжтой. Гэхдээ бид ажиллаж байгаа улсад маань маш олон бохир мэдээний редакц ажиллаж байгааг ойлгох ёстой. Мэдээний редакцын тоглогчид

салбарынхныгаа болоод бизнес эрхлэгчид, шийдвэр гаргагчдын олон төрлийн урхинд унаж, аюулд өртөх, эсвэл худалдагдах магадлалтай. Манайд хэвлэл мэдээллийн олон байгууллага эх үүсвэр нь тодорхойгүй эсвэл аль нэг сонирхлын бүлгийн төлөөллөөс гарааны хөрөнгөө авч ажиллаж байна. Редакторууд бол тэргүүн зэргийн “бай”, зарим тохиолдолд гол буруутан нь болдог. Ийм нөхцөлд ажиллаж байгаа залуу сэтгүүлч эрэн сурвалжилгын төслөө хэрэгжүүлэхэд хүндрэл учирдаг.”

Эрэн сурвалжлах сэтгүүлч мөрдөгч мөн үү?

Хэрэв ур чадвар талаас ярьж байгаа бол хариулт нь “тийм”, сэтгүүлч бол мөрдөгч мөн. Эрэн сурвалжлах мэдээ болгон асуултаас эхэлдэг. Сэтгүүлч сэдвийн өнцөг болон нийгмийн ач холбогдлын талаарх таамаглал боловсруулахын тулд асуултаа судалдаг. Тэгээд баримт бичгүүдийг шалгах, заримдаа байцаалт ч гэмээр ярилцлагууд хийх, мэргэжлийн үг хэллэг бүхий их хэмжээний дэлгэрэнгүй нотолгоог нэгтгэх зэргээр нэмэлт судалгаанууд хийж эхэлнэ.

Сэтгүүлчид аль зэрэг бодитой баримт, шийдвэрлэх нотолгоо болж чадах эсэхийг харгалзаж (шүүх хурал дээр ашиглагддаг) хүчин төгөлдөр стандартыг ашигладаг. Бусдыг гүтгэх нь хуулиар зохицуулагддаг учир сэтгүүлчийн эрэн сурвалжлах ажиллагааны стандарт, баримт нягталж шалгах үйл явц нь мөрдөгч хэргийн баримт цуглуулдгаас хэтрэхгүй байвал зохино.

Зарим үед “Эрэн сурвалжлах сэтгүүлчид микрофон, камераа далдалж, нууц ажиллагаа явуулах зэргээр мөрдөгч нар шиг ажиллаж болох уу” гэсэн асуулт гарч ирдэг. Хариулт нь маш түвэгтэй. Эрэн сурвалжлах сэтгүүлч нар, тэдний дотор зарим шилдгүүд нь ч ийм аргыг ашигладаг. Гэхдээ мөрдөгч нарын нууц ажиллагааны хүрээ хязгаар болон цагдаагийн газраас эрэн сурвалжилж байгаа иргэний эрхийг ихэнх тохиолдолд хуулийн хэм хэмжээнд зохицуулсан байдгийг санах хэрэгтэй. Сэтгүүлчид ёс зүйн хэм хэмжээндээ найддаг боловч энэ нь хувь хүний нууцын тухай хуулиас чөлөөлөхгүй. Иймд ёс зүйтэй сэтгүүл зүйг баримталж, ял шийтгэлд унахаас болгоомжлохын тулд эрэн сурвалжлах сэтгүүлчид нууцаар ажиллахын өмнө нөхцөл байдлыг сайтар үнэлэх хэрэгтэй. Нууц камер, дуу хураагуурын материал нь зөвхөн түүхий баримт болж хадгалагдах ба цугларсан материалд дүн шинжилгээ хийх, шалгах, нөхцөл байдалтай нь уялдуулж ашиглахад шууд ашиглах боломжгүй. Хэрэв та хаанаас хайх болон хэрхэн нэгтгэхээ мэддэг бол маш олон баримт материал нийтэд нээлттэй байдаг.

Эрэн сурвалжлах сэтгүүлчид болон мөрдөгчид олон талаар ижил боловч бас хэд хэдэн зүйлээр ялгаатай. Зарим тохиолдолд сэтгүүл зүйн эрэн сурвалжлах ажиллагааны зорилго нь гэм бурууг нотлох бус, зүгээр л гэрчлэх явдал байдаг. Мөрдөгчид гэм буруутныг нотолмогц зогсдог бол эрэн сурвалжлагч хариултыг олсон ч цааш үргэлжилсээр байдаг. Эхлээд зөв баримт цуглуулж, дараа нь баримтыг зөв илэрхийлнэ. Мэдээний утга учрыг гаргаж, үйл явдал, үйл ажиллагаа эсвэл баримт нотолгоог замчилж үзүүлдэг. Эрэн сурвалжилгын бүтээл буруутныг шууд чичлэхээс илүүтэй үйл явдлын өрнөсөн зам, асуудлын нарийн учир шалтгааныг тайлбарладаг. Эрэн сурвалжлах сэтгүүлч ажлаа гүнзгийрүүлэн судлах тусам нотолгоо нь төдий чинээ эргэлзээгүй болдог.

Угаас “уур бухимдлын сэтгүүл зүй” гэгддэг эрэн сурвалжилгад мэдээний хоёр талыг зохиомлоор тэнцвэржүүлдэггүй. Харин түүний оронд үзүүлэх мэдээ нь гарцаагүй зөв эсэхийг нягталдаг. Энд “Бидний буруу ч байж болно”, “Бид ташаа ойлгосон байх магадлалтай” гэх мэт бүрхэгдүүлсэн тайлбар байдаггүй. Хэрэв ийм эргэлзээ байсаар байвал хангалттай нарийн судлаагүй, бүтээлийг хэвлэн нийтлэхэд бэлэн биш гэсэн үг. Мэдээ нь хоёрхон талд хуваагдана гэж хэзээ ч үгүй. Харин олон талыг тайлбарлаж, дан ганц юу болсныг бус яагаад болсныг дамжуулан хүргэх замаар эрэн

сурвалжлах бүтээлийн тэнцвэртэй байдлыг хангадаг. Мөрдөгч нөхцөл байдлыг зөөллөх тайлбарыг өмгөөлөгчид үлдээдэг бол эрэн сурвалжлах сэтгүүлч нөхцөл байдлыг бүхэлд нь тайлбарладаг.

Нөгөө талаар эрэн сурвалжлах сэтгүүлчид эрдэмтэн судлаачид шиг ажилладаг. Мэдээний санааг нь дэмжих хангалттай баримт нотолгоо цуглуулах хүртэл сэтгүүлчид бүх талаар нээлттэй сэтгэх шаардлагатай. Энэ нь эсрэг нотолгоог орхигдуулахгүй байж, эсрэг чиглэлд үйлчилж байвал дүгнэлт өөрчлөхүйц уян хатан байхыг хэлж байгаа юм. Энэ бүх талаараа сэтгүүлчийн ажил нь таамаглал дэвшүүлж, зөв эсэхийг нь шалгадаг эрдэм шинжилгээний үйл явцтай төстэй.

Эрэн сурвалжлах сэтгүүлчид мөн менежерүүд байдаг. Нарийн судалгаа шаардлагатай урт хугацааны, томоохон төслүүд дээр эрэн сурвалжлах сэтгүүлчид багийн бусад гишүүн болон мэргэжилтнүүдтэй ажиллаж, сэдвийн төлөвлөгөөг чанд сахих шаардлагатай болдог. Иймд сэтгүүлчид товч тодорхой харилцах, багаар ажиллах чадваруудыг эзэмших хэрэгтэй юм.

Эрэн сурвалжилгын тухай төөрөгдлүүд

Төөрөгдөл 1 Сэтгэл татам ажил бөгөөд од болох гарааг ч эхлүүлж магадгүй.

“Ерөнхийлөгчийн бүх эрчүүд” киноны зурган дээр яагаад Вотргэйтийн сэтгүүлчид биш, тэдний дүрд тоглосон жүжигчид (Роберт Рэдфорд, Дастин Хофмэн) байдаг вэ? Тийм ээ, сэрж үз. Эрэн сурвалжлах сэтгүүл зүй хэцүү, уйтгартай, заримдаа аюултай ажил гэдгийг бодит байдал харуулж байна.

Төөрөгдөл 2 Сэтгүүлчид нь сурвалжилсан мэдээнээсээ чухал.

Эрэн сурвалжлах сэтгүүл зүй нь биеэ өргөмжлөх бус олон нийтэд үйлчлэх зорилготой ба эрэн сурвалжлах сэтгүүлч байснаар мэргэжлийн ёс зүйн стандартыг уландаа гишгэх давуу эрх эдлэхгүй.

Төөрөгдөл 3 Эрэн сурвалжлах сэтгүүлч бол “гол дүрийн баатар” л гэсэн үг.

Кино бүтээгчийн нүдээр бол аливаа үйл явдал нэг этгээдийг тойрон өрнөдөг учраас зохиолын гол дүрийн баатартай байх нь энгийн үзэгдэл. Харин бодит байдал дээр эрэн сурвалжлах сэтгүүл зүй нь багийн ажиллагаа л байхгүй бол оршин тогтнох үндэс үгүй.

Төөрөгдөл 4 **Эрэн сурвалжлах сэтгүүл зүйг гол төлөв хувийн хэвшлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл явуулдаг.**

Зарим талаар үнэн. Гэхдээ төрийн өмчит хэвлэл мэдээллийн хэрэгсэл засгийн газрын эсрэг эрэн сурвалжилгыг эхлүүлэн явуулж байсан алдартай жишээнүүд ч байдаг.

Төөрөгдөл 5 **Эрэн сурвалжлах сэтгүүл зүй зөвхөн хар бараан мэдээг сурвалжилдаг.**

Нийгмийн бүлэг хүмүүс болоод тэдгээрт үйлчилдэг хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь буруу зүйлийг олж илрүүлэх, засахыг чухалчилдаг. Харин эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хувьд эерэг мэдээг илчлэх бас үүрэгтэй. Тухайлбал, хүмүүс эсвэл нийгмийн бүлгийн тэнцвэргүй, сөрөг дүр зургийг үнэн зөв мэдээллээр буцааж эерэгжүүлэх нь эрэн сурвалжилгын жинхэнэ, сайн мэдээний үндэс болох боломжтой. Түүнээс гадна “хүний нэр төрийг цэвэрлэх” гэгддэг ийм төрлийн эрэн сурвалжлах сэтгүүл зүй олон нийтийг тэтгэлээ баярлуулдаггүй. Энгийн дуулиан шуугиан тараах гол зорилго нь хүмүүсийн сонирхлыг бусдын хувийн амьдралд хандуулахаас хэтэрдэггүй. Харин хувийн зүй бус авираас хэтэрч олон нийтийн эрх ашигт нөлөөлөхүйц асуудал гарсан үед дуулиан шуугиан нь эрэн сурвалжлахуйц үнэ цэнэтэй болдог.

Төөрөгдөл 6 **Эрэн сурвалжилга ер нь л сайн сурвалжилга болдог.**

Уг тодорхойлолт сэтгүүлчдийг “хоточ нохой” шиг үзэж, буруу зүйлийг шиншилж, хуруугаар чичлэн буруутгаж, өөрчлөлт авчрахын тулд сурвалжилдаг хэмээх уламжлалт ойлголтоос үүдэлтэй. Энэ мэдээж үүргийнх нь нэг хэсэг. Авлигачдыг зогсоох нь чухал. Гэвч эрэн сурвалжилгаар гэмт этгээдийн ийм байдлыг өөгшүүлж буй алдаатай тогтолцоог олж харахгүй юм бол шинэ луйварчдад яг ижил зүйлийг хийх хөрсийг нь цэвэрлэж өгч байгаа үйл хэрэг юм (яаж илүү сайн гүйцэтгэхийг нь зааж ч магадгүй). Эрэн сурвалжлах мэдээгээр цаад асуудлыг тодорхойлж, нэгэнт ил гарсан аргыг нь таслан зогсоохыг эрх бүхий хүмүүст сэрэмжлүүлэх хэрэгтэй. Хэрэв тэрхүү эрх мэдэлтнүүд арга хэмжээ авахгүй бол учир шалтгааныг нь тодруулах нэмэлт эрэн сурвалжилга шаардлагатай гэсэн үг. Иймд эрэн сурвалжлах сэтгүүлчид ажиглалт, танадалт судалгаа хийх, хариултаа олж авахын тулд тууштай мөрдөх зэрэг ур чадвартай байх ёстой. Гэхдээ дан ганц эдгээр шалгуураар эрэн сурвалжлах сэтгүүлчдийн ажлыг тодорхойлж болохгүй, бусад мөргөжлээс ч ангид салгаж болохгүй юм.

Яагаад эрэн сурвалжилга хийх ёстой вэ?

Эрэн сурвалжлах нь цаг хугацаа, өндөр үнэ өртөг шаарддаг төдийгүй эрсдэлтэй үйл ажиллагаа юм. Эрэн сурвалжлах сэтгүүлчид ихэвчлэн өдрөөс өдөрт болж буй үйл явдлууд нь эцсийн дүндээ сонины гайхалтай сайн нийтлэл болно гэж эрхлэгчээ ятгах шаардлагатай болдог. Ийм байтал, яагаад эрэн сурвалжилгыг үнэ цэнэтэй гэж үзэж, үүнийг хийх гол зорилго нь юунд оршино вэ?

Шилжилтийн үедээ байгаа улс орнуудын жишгээс харахад сонины эрхлэгчид эрэн сурвалжилга бол “барууны” соёл бөгөөд, тус үйл ажиллагаа нь хөгжиж буй орнуудад тохиромжгүй гэж үздэг. Гэхдээ эрэн сурвалжилга үргэлж их хэмжээний цаг хугацаа, санхүүгийн эх сурвалж шаардаад байдаггүй. Сэтгүүлчид шийдэмгий зоригтой байж, ажил амлалтынхаа үеэр ч “хоточ нохойн” үүрэг бүхий мэдээ бэлтгэх замаар эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хөгжүүлсэн олон жишээ байдаг.

Их Британийн Эрэн Сурвалжлах Сэтгүүл Зүйн Төвийн Ерөнхийлөгч Гавин МакФаден маргахын аргагүй тодорхойлолт өгсөн байдаг:

Ач холбогдол бүхий сурвалжилга хиймэгц хүмүүсийн анхаарал татагдаж ярилцаж эхэлдэг. Хүмүүсийн ихэнх мэдлэг мэдээлэл амаас ам дамжин түгдэг. Хувьцаа өсч, индексийн үзүүлэлт нэмэгдэж, төсөл хөтөлбөрүүд найдвартай хэрэгжиж байна гэхэд тэд итгэсээр л байдаг нь чухал. Хэрвээ мэдээ мэдээлэл хүмүүст үнэхээр итгэл төрүүлэхүйц хэмжээнд байвал тэд анхаарч, үргэлжлүүлэн мэдээлэл

авсаар байх болно. Энэ бол ихэнх орноос харж болох жишээ. Эдгээр нь мөн л мэдээллийн хэрэгслийн соёлд нөлөө үзүүлдэг. Эрхлэгч, продюсерууд мэдээллийг улам л гуйвуулах дадал зуршилд дурлан үгүйсгэсэн шинжтэй болж, хэвлэл мэдээллийн хуулийг гадны нөлөөг зогсооход ашиглахаас илүүтэйгээр улам буруугаар ашиглахад хүргэж, улмаар үзэгч, уншигчдаа түрэмгий ширүүн нийтлэлээр татаж байна.

Түүнчлэн эрэн сурвалжлах сэтгүүл зүй ардчиллыг бий болгодог. Албан ёсны хэвлэлийн мэдээ мэдээллийг эрэн сурвалжилдаггүй орхигдуулах байдал нь тухайн мэдээллийг үнэн зөв гэж ойлгуулж хүлээн зөвшөөрснөөр тэднийг улам хүчирхэгжүүлдэг. Иймэрхүү албан ёсны хэвлэлийн мэдээ мэдээлэл дээрээс доошоо чиглэсэн байдалтай бичигддэг. Ардчилсан зарчмын хувьд, засгийн эрх баригчид, хүчтэй, нэр хүндтэй бүлгээс хариуцлага болон ил тод байдлыг сэтгүүлчид шаардах ёстой бөгөөд мэдээлсэн, дүгнэсэн хүндхэн асуулт асуухгүй бол алдаж байгаа нь тэр юм. Ардчилал, шударга ёсны төлөөх эрэн сурвалжилга бол хамгийн зөв зүйтэй үйл ажиллагаа юм.

Хэрхэн сайн эрэн сурвалжлах сэтгүүлч болох вэ?

Хүсэл тэмүүлэл

Эрэн сурвалжлах сэтгүүлчийн хувьд хүсэл тэмүүлэл хамгийн чухал үнэт зүйл болохыг Эвелин Гроенинк онцолжээ:

Эрэн сурвалжлах сэтгүүл зүй бол ихэнхдээ талархал хүлээдэггүй хүчин чармайлт юм. Цаг хугацаа, хүч хөдөлмөр зарцуулж байгаа зүйл чинь редакторыг чинь хүлээцгүй хандахад хүргэж, хүч чадалтай, эрх мэдэлтэй хүмүүсийг залхаана. Хэрэв чи тогтмол цалинтай, байнгын ахиц дэвшилтэй ажиллахыг хүсдэг бол, хэрэв чиний туйлын хүсэл хийсэнтэйгээ дүйцэхүйц шан харамжтай ажиллаж, VIP зэрэглэлийн хүмүүстэй хамт оройн зоог барьж, үдэшлэгт уригдах юм бол чамд эрэн сурвалжлах сэтгүүл зүй хэзээ ч тохирохгүй. Гэхдээ чи хэчнээн их цаг хугацаа, хэчнээн их хичээл зүтгэл гаргаад ч хамаагүй саад бэрхшээлтэй нүүр тулж чаддаг, шударга, эрх тэгш байдлын төлөө хүсэл тэмүүлэлтэй байж, уншигч үзэгчдэдээ хүссэн сэдвээр нь үнэнийг өгч, хэдий хүч чадалтай хүмүүс чамд таагүй хандлагатай болсон ч хамаагүй гэвэл үүнийг хий!

Сониуч зан

Асуулт асуух нь эрэн сурвалжлах сэтгүүл зүйн эхлэл. Асуултууд өдөр тутмын амьдралд чинь гарч ирдэг үйл явдал, эсвэл харж сонсож буй юу ч байж болно.

Санаачилга

Ихэнх мэдээний алба хязгаарлагдмал эх сурвалжтайгаар давчуу цаг хугацаанд ажилладаг. Тиймээс редакцийн хурал дээр эрэн сурвалжлах сэдэв дэвшүүлэхэд тэр бүр дэмжигддэггүй. Ялангуяа шинэ, тодорхой бус сэдэв бол бүр ч унах магадлалтай. Эрэн сурвалжлах сэтгүүлчид санаачилгатай байх ёстой. Хувьдаа урьдчилсан судалгаа хийж, санаагаа бат бөх төлөвлөгөөнд оруулах шаардлагатай. Хэрвээ үүний дараа ч редакц дэмжихгүй хэвээр байвал цааш тодорхой дэмжлэг /эрэн сурвалжлах тэтгэлэг/ эрэх хэрэгтэй болно.

Логик, зохион байгуулалт болон хувийн эмх журам

Эрэн сурвалжлах нь хуулийн хүчин зүйл, нарийн үе шаттай тодруулга зэргээс шалтгаалж цаг их шаарддаг. Тиймээс цагаа хэрхэн зөв хуваарилахыг төлөвлөдөг, баримтуудыг шалгаж бас дахин шалгаж, хоорондын уялдаа холбоог нягталдаг “донтой” бай.

■ Уян хатан чанар

Эрэн сурвалжлах явцад юмс яаж ч өөрчлөгдөж болно. Зарим үед эхний асуулт төгсгөл ч болж мэднэ, эсвэл бүр сонирхолтой зүйлийн хаалгыг нээж ч магадгүй. Эрэн сурвалжлах сэтгүүлч судалгааг хэзээд шинэчилж, дахин төлөвлөхөд бэлэн байх ёстой бөгөөд анхны санаатайгаа салахгүй зууралдаж болохгүй.

■ Багийн сэтгэлгээ, харилцааны ур чадвар

Кинонд эрэн сурвалжлах сэтгүүлчдийг ганцаардсан чоно гэж дүрслэх нь элбэг. Заримдаа, нууцлал чухал үед мэдээ мэдээллийг бусадтай хуваалцах боломжгүй байдаг. Гэхдээ ихэвчлэн сайн бүтээл олон төрлийн ур чадвар бүхий хамтын ажиллагаанаас /редакциас гадуур ч байж болно/ бий болдог. Жишээлбэл, католик лам нарын хүүхэд хүчирхийлдэг хэргийг эрэн сурвалжилдаг “Гэрэлтүүлэг” киноны амжилтад хүрсэн багийг бодох хэрэгтэй. Эрэн сурвалжилга нь шинжлэх ухаан, эрүүл мэндээс эхлээд эдийн засаг, социологийн мэдлэгийг шаарддаг бөгөөд заавал сэтгүүлч ч байх албагүй. Сайн танилын хүрээ, холбоо харилцаа бол багийн ажиллагааны нэг хэсэг. Багийн хамт олон сэдвийнхээ зорилго, стандартыг /нарийвчлалтайгаар, шударгаар, итгэлтэйгээр/ маш сайн мэддэг байж, хүн тус бүр үүнд хувь нэмэр оруулдаг байх нь чухал.

■ Мэдээлэх арга барилаа хөгжүүлэх

Үүний тулд заавал сэтгүүл зүйн цол зэрэгтэй байх шаардлагагүй, Гэхдээ эх сурвалжаа тодорхойлох, судалгаагаа төлөвлөх, сайн ярилцлага хийх /худал хариулт хэлэхэд шууд мэддэг мэдрэмжтэй байх/, ойлгомжтой тодорхой мэдээлэх хангалттай дадал хэвшил, туршлагатай байх ёстой. Түүнчлэн, сэтгүүлчид эрч сулрах үеэ мэдэрч, бусдаас тусламж хүсэх даруу чанарыг эзэмшвэл зохино. Хэрэв та туршлагагүй бол сайн баг хамт олон шаардлагатай ур чадвар эзэмшихэд чинь туслах болно.

■ Ерөнхий мэдлэгээ тэлж сайн судалгаа хийх

Эрэн сурвалжилгынхаа агуулгыг ойлгож чадвал холбоотой гэсэн баримт, асуултуудыг тодорхойлж, үхмэл төгсгөлөөс зайлсхийж чадна. Гэхдээ сурвалжилга хамааралгүй сэдэв рүү хөтөлвөл тэр сэдвийг мэргэжлийн хэллэг, суурь мэдээлэл, гол тоглогч нараар дамжуулан ямар нэгэн уялдаа холбоог шуурхай бий болгох хэрэгтэй. Мэргэжилтнүүдтэй чухал ярилцлага хийх ур чадварыг өөртөө төлөвшүүлэхдээ судалгааны арга барилыг ашиглаж, хэрэгцээт номыг гүйлгэж унших нь үр дүнтэй байдаг. Дүгнэхэд цаг, боломж л гарвал бүхнийг унших хэрэгтэй. Багахан мэдээлэл ч эрэн сурвалжилгад тус дэмтэй байдаг.

■ Шударга байдал, ёс зүйг чандлах

Эрэн сурвалжлах үйл ажиллагаа хувь хүний аюулгүй байдал, ажил, амьдралыг эрсдэлд оруулдаг. Мөн хуумгай, болгоомжгүй байдлаас шалтгаалан эрэн сурвалжилж буй “зүйлээ” ч эрсдэлд оруулдаг. Тиймээс эрэн сурвалжлах сэтгүүлчид хүчтэй, буурь суурьтай, хувийн ёс зүйтэй байж сэдвээ болон эх сурвалжаа аль болох хүндэлж, аюул заналхийллээс хамгаалж байх шаардлагатай. Түүнчлэн эрэн сурвалжилгыг дэмжиж байгаа редакцийн хамт олон ёс зүйн хэм, хэмжээг чандлан баримталж, ёс зүйн зөрчил гарвал даруй хэлэлцэж шийдвэрлэдэг байх нь зүйтэй. Заримдаа олон нийтийн итгэл таны хамгийн сайн хамгаалагч болдог бөгөөд та ёс зүйгүй авирлавал тэдний итгэл алдрах болно.

■ Хянамгай байдал

Хов жив хэзээ ч эрэн сурвалжлах мэдээ болж чадахгүй. Дэл сул яриа эрэн сурвалжилгыг болоод түүнд хамрагдаж буй бүхий л хүмүүсийг эрсдэлд оруулна. Мөн эсрэг талынханд сэдэл бүхий мэдээлэл өгч сэдвийг чинь баллаж, хүмүүст анхааруулга өгснөөр ярилцлага бүтэлгүйтэх аюултай. Хэтэрхий их ярих нь сурвалжилгыг унагах болно.

■ Иргэний эрх үүрэг

Эрэн сурвалжлах сэтгүүлчдийг эх оронч бус гэж дайрцгаах тохиолдол их бий. Гэсэн хэдий ч сэтгүүлч олон нийтийн санаа бодол, эрх ашгийн төлөө өөрсдийгөө хурцалж, нийгмийн сайн сайхны төлөө зүтгэсээр байх нь чухал юм.

Энэхүү бүлэгт эрэн сурвалжлах сэтгүүл зүйг олон нийтийн санаа бодолд тулгуурлан тодорхойллоо. Мөн эрэн сурвалжлах сэтгүүлч нарт өөрсдийн санаачилсан сэдвээ редактораараа дэмжүүлэхэд тийм ч амаргүйг онцлон дурдав. Ихэвчлэн эрэн сурвалжилж буй сэдэв хэр ирээдүйтэй, өгөөжтэй вэ гэдэг нь чухал байдаг. Дараагийн бүлэгт хэрхэн мэдээ мэдээлэл олж авах, хуурамч мэдээлэл, сэжүүрийн хойноос яваагүй эсэхийг бататгах талаар дурдсан болно.



ХОЁРДУГААР БҮЛЭГ

СЭДВЭЭ ОЛООД ЭХЭЛ!

Бүхий л сэдэв санаанаас эхэлдэг. Энэхүү бүлэг та бүхэнд тэдгээр санаа хаанаас бий болдгийг тайлбарлана. Сонин унших, эх сурвалжуудтай ярилцах, нөлөө бүхий хүмүүстэй уулзах, шинэ дэвшил хөгжлийг цаг алдалгүй ажиглах зэргээр санаа олж болно. Мөн энэ бүлэгт нийгмийн сүлжээ, тэр дундаа Фэйсбүүк, Твиттерийн мэдээ мэдээллийг түгээхэд гүйцэтгэх гол үүргүүдийг онцолсон. Эрэн сурвалжлах сэтгүүл зүй бол өөрийгөө тав тухтай, амар хялбар арга барилаас чөлөөлж, мэдэхгүйгээ судалж, эрсдэлээ тооцоолон ажиллахын нэр юм. Нэгтгэн дүгнэвэл, сэтгүүлч унших, бас дахин унших, нүдээ нээж чихээ онгойлгох шаардлагатай!

ТОДОРХОЙЛ

ЭРЖ ОЛ

ТӨЛӨВЛӨ

ХАМГААЛ

Хэрхэн сэдэв олох вэ?

Ихэнх сэдэв сэтгүүлчийн өмнөх сэдвүүдээс урган гардаг. Заримдаа цаг үеийн сэдэв зэрэг хувийн сонирхлоос гарах нь ч бий. Тохиромжтой сайн сэдэв олно гэдэг тийм амархан биш болохыг санаарай. Магадгүй энэ нь сэтгүүлчийн ажлын хамгийн хэцүү хэсэг нь байж мэднэ.

Нэгдүгээрт, дөнгөж цэцэглэж буй эрэн сурвалжлах сэтгүүлчийн ажлын замналыг төсөөлвөл бичиг баримтаа тэвэрчихсэн харанхуй хонгилоор алхаж яваа мэт юм. Агуулгаа ил болгосны дараагаар үр дүн бүхий багц мэдээгээ эхний хуудаснаа тавьж, эдгээр нь хангалттай сайн байж чадвал зоригтойхон томоор хэвлээд нэрээ дээр нь биччихэд л гүйцээ. Магтаал, нэр хүнд, шагнал араас чинь дагах болно. Заримдаа ингэж л ажил явагддаг. “Вотргэйт”-ын хэргийг сөхвөл, үл мэдэгдэх мэдээллийн сэжим яваандаа Ерөнхийлөгч Ричард Никсоныг огцроход хүргэсэн. Гэхдээ ерөнхийдөө улс төрийн авлигатай холбоотой хэнээс гэдэг нь мэдэгдэхгүй утасны дуудлага, нууцлалын чанартай бичиг баримт тэр бүр тохиохгүй бөгөөд маш сайн нягтлах л чухал юм. Вотргэитыг эш татдаг нь алдартай хэрэг явдал байсан төдийгүй сэтгүүлчдийн хөлс хөдөлмөр шингэсэн, бусад сэтгүүлчийг урамшуулах хэмжээний үйл явдал байсан тул өнөөдрийг хүртэл яригдсаар байгаа юм. Мөн энэ бол дээд цэгтээ тулсан улс төрийн худал хуурмагийг илчилсэн явдал билээ.

Хоёрдугаарт, сэтгүүлчдийн ажил хэзээ ч тарахгүй. Тэд ажилдаа явахдаа ч, паспортоо сунгуулахаар бүртгэлийн газар урт дараалалд зогсож байхдаа ч, эмнэлэгт ааш муутай сувилагчид үзүүлж байхдаа ч чихээ дэлдийлгэж, нүдээ нээсэн хэвээр ажиглаж, ажиллаж л байх ёстой. Магадгүй эхний ганц ажиглалтаар ч судлах, сурвалжлах шаардлагатай сэдэв олж болох юм. Дэвтрийнхээ нэг өнцөгт санаагаа жагсаан бичиж, ажигласан бүхнээ сараачин буулгаж бай. Утсан дээрээ дуу хураагуураар тэмдэглэн авах нь илүү дээр.

Гуравдугаарт, сэтгүүлчид үйл явдал, сэдвийн газар очиж, хүмүүстэй ярилцаж, мэдээлэл цуглуулсан боловч “Надад баримт нотолгоо дутаж байна” гэж гомдоллодог. Гэхдээ тэдгээр нь баримт нотолгоо болдгийг ойлгодоггүй. Хэн нэгэнд тохиолдсон зүйл гэхээсээ илүү өөрт тань тохиолдсон зүйл бол үнэнээс нэг их зөрөхгүй баримт нотолгоо бөгөөд үүнээс л бүхнийг эхлэх хэрэгтэй. Үүнийг үнэхээр бодит амьдралд болсныг та мэдэж байгаа тул энэ бол баримт юм. Сэтгүүлчид бол өөрсдийнхөө хувьд хамгийн шилдэг нотолгоо. Энэ давуу талаа ашиглан ажиглалтаас сэдэв босгож, тухайн үед тэмдэглэсэн зүйлсээр нотолгоо хийх хэрэгтэй. Хэзээ ч дурсамжиндаа бүү найд. Сайн камертай гар утас бол маш том давуу тал. Баримт, үйл явдалтай учирдаг л юм бол зураг дар, баримтжуул!

ХАЙ

УУЛЗ

АСУУ

БИЧ

Хувийн нөхцөл байдал

Эрэн сурвалжлах сэдэв боловсруулахад дараах хоёр бэрхшээл тулгарах аюултай. Нэгдүгээрт, тэнцвэртэй сурвалжилга бэлтгэхэд хувь хүний сэтгэл хөдлөл саад учруулна. Магадгүй та хүмүүст хүргэх гэж буй сэдвээ боловсруулж, баримт нотолгоо дэлгэхийн оронд төрийн албан хаагчдын байгаа байдалд уурлаж бухимдаж, тэднийг буруутгасан, доромжилсон өнгө аясыг илэрхийлж болно. Энэ үед л сэтгүүлч өөрийн мэдрэмж, сэтгэл хөдлөлийн эсрэг зогсож, агуулгадаа сэтгэл хөдлөлөө илэрхийлсэн эсэхээ нягтлах шаардлагатай.

Хоёрдугаарт, хувь хүнд тохиолдсон үйл явдал олон нийтийн эрх ашгийг төлөөлж чадахгүй байж мэднэ. Ганц тохиолдолд байлаа гэхэд үүнтэй адилхан хэдэн хүний эрх ашиг хөндөгдсөнийг ойлгож мэдэх нь чухал. Тодорхой нэг үйл явдалд өртсөн нь сэтгүүлч учраас тэр үү, эрэгтэй учраас тэр үү, эсвэл эмэгтэй учраас тэр үү гэдэг учир шалтгааныг олж тодорхойлох хэрэгтэй. Бусад хүнд ийм зүйл тохиолдож байгаа болов уу гэж асуу. Энэхүү хандлага өдөр бүр тохиолдож байгаа болов уу, эсвэл зөвхөн өнөөдөр л ийм зүйл болов уу? гэдгийг ч тодорхойлохыг хичээгээрэй. Энэ бэрхшээлийг давж гарахын тулд тухайн асуудлыг нэг тохиолдлын хүрээнд бус өргөнөөр харж мэдээлэх нь чухал юм. Хувийн туршлагаа бичих нь санаа төдий зүйл болохоос эрэн сурвалжлах биш юм. Тохиромжтой сурвалжилга, мэдээлэл бэлтгэхийн тулд учир шалтгаан хайж, агуулгаа ойлгож, янз бүрийн хүмүүстэй ярилцах шаардлагатай. Ингэснээр та зөвхөн өөрийн гомдол дургүйцлийг илэрхийлж байгаа хэрэг бус, түүнээс ч илүү олон нийтийг төлөөлж чадна.

Ижил төрлийн давуу болон сул талууд тантай мөр зэрэгцэн ажиллаж байгаа бусад хүнд ч бас тохиолдоно. Тэдний туршлага үнэн байж болох ч түмнийг төлөөлж чадах эсэх нь эргэлзээтэй юм. Ойлгомжтой тодорхой мэдээллийг найз чинь танд хэлж болох ч өөрийн биеэр туулаагүй зүйл байж болно. Тухайлбал, “Надад онгоцны буудал дээр хээл хахууль өгөх гэж оролдсон эмэгтэйг таньдаг үеэл байгаа” гэж хэллээ гэхэд тухайн эмэгтэйн нэр, хаяг тодорхойгүй, ярилцлага аваагүй бол зүгээр л нэг хов жив юм. Тиймээс биеэр туулсан тохиолдол, туршлага гэдэг бол сайн сурвалжилгын эхлэл юм. Зөвхөн эхлэл!

Эрэн Сурвалжлах Сэтгүүлчдийн Төвөөс гаргасан дараах зөвлөмжийг уншаарай:

‘Таны таньдаг зарим хүн мэдээлэл задруулах эрхгүй цагдаа, мөрдөн байцаагч зэрэг албан тушаалд ажилладаг байж болно. Тиймээс танил тал, найз нөхдөөсөө мэдээлэл авахдаа болгоомжил. Тэд туслахаас татгалзахгүй байлаа ч мэдээлэл өгснөөр амьдралд нь аюул, эрсдэл учирч болзошгүй. Хэн нэгний хувийн мэдээллийг ашиглахдаа ч зөвшөөрөл авч байгаарай.’

Хов жив, цуу яриа

‘Авто радио’, гудамжны худалдаачин, таксины жолооч, зорчигчид, гольфийн талбайн туслагч, түүнчлэн улс төрч, цагдаа нарын ойрын хүмүүс, газрын наймаачид, бар, кафены байнгын үйлчлүүлэгчдээс илүү хов жив, цуу яриаг салхи мэт хурдан тараах мэдээллийн хэрэгсэл гэж байхгүй.

Гэвч энэ хов жив, үнэн худал нь мэдэгдэхгүй “болсон явдлууд” бидэнд нийгмийн өөрчлөгдөж буй чиг хандлага, бодит өөрчлөлтийг давхар мэдээлж байдаг. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл ихэвчлэн хөндөж байгаа асуудал, эсвэл үзэгч уншигчдад юу сонирхох хэрэгтэйг нь чиглүүлснээр бурууддаг. Хов жив, цуу ярианд ч гэсэн хэвлэл мэдээлэлтэй адил өөрийн “хөндсөн асуудал” байдаг.

Сэтгүүлчид эдгээр болсон явдал, хов живийн нарийн учиг, сэжүүрийг үргэлж сонирхон анхаарч, хүмүүсийн ярьж байгаа зүйлсэд нүд, чих тавьж явах хэрэгтэй. Охид алга болсон нь үнэхээр хүний наймааны гэмт хэрэг мөн үү? Хүмүүс гэрийн нөхцөлд үйлдвэрлэсэн шинэ согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэж байгаа юу? Амжилттай бизнесмэн үнэхээр үйл ажиллагаагаа царцаагаад эхэлсэн үү? Эсвэл цагдаагийн томчууд эрүүгийн гэмт хэрэгтнүүдтэй “зузаарсан” нь үнэн үү? гэх мэтчилэн. Авто радио танд энэ бүхнийг хэрхэн болж өрнөж байгаа талаар, мөн олон ийм түүх үнэн байдаг талаар ярина. Харин сэтгүүлчид өөрсдөөсөө асуух хэрэгтэй. Хүмүүс яагаад ийм зүйлд итгэж байна вэ? Энэ явдал нь манай цаг үе, улс орны талаар юу илэрхийлж байна вэ? Хүмүүс фэйсбүүкд ямар асуудлаар шуугицгааж байгаа вэ? гэх мэтчилэн.

Эхний алхам бол уг цуу яриаг үнэн эсэхийг баталгаажуулах юм. Үүнд болсон явдлын талаар мэдэж байх гарцаагүй эх сурвалжаас тодруулах хэрэгтэй. Цагдаа нараас алга болсон охидын талаар асууж лавлах, эмч нараас хүмүүс архи хэтрүүлэн хэрэглэж байгаа эсэхийг асуух. Бизнесмэн эрийн ажилчдаас компанийн үйл ажиллагаа ямар байгааг, санхүүгийн шинжээчдээс зах зээлийн чиг хандлагыг асууж тодруулах хэрэгтэй. Хүмүүс сүүлийн үед өмч хөрөнгөө зарж эхэлсэн эсэхийг нягтла. Цагдаагийн үйл ажиллагааг сайтар ажигла. Эндээс тухайн цуу ярианы мөн чанар илэрч байгаа бол тухайн үйл явдлын сурвалжилгыг эхлүүлж болно.

Нууц мэдээллийг үнэлэх

Олон үйл явдал ямар хууль зөрчигдөж байгаа талаар нууц мэдээллийн эх сурвалжаас эхтэй байдаг. Жишээ нь цагдаагийн албаны эх сурвалж танд автомашины рекетүүдийн гэмт хэрэгт цагдаагийн дарга оролцсон, салсан эхнэр, нөхөртөө хонзогносноос хуучин эхнэр эсвэл нөхрийнхөө татвараас

зайлсхийдэг байсан мэдээллийг тогтмол уншдаг сонинд нь өгөх, улс төрч харилцаа сайтай байдаг редакцидаа засгийн газрын тендерт өрсөлдөж байгаа харилцаа таарамжгүй байгаа компани эсвэл тендерийн хорооны гишүүний тухай мэдээлэл өгөх гэх мэтчилэн. Гэвч энэ мэдээлэл нь бүхэлдээ үнэн байх албагүй юм. Тодорхой хэсэг нь хэн нэгнийг хохироох зорилготой худал мэдээлэл байж ч болно. Үүнд зөвхөн асуудал хөндөн гаргахад зориулагдсан тодорхой хэсэг нь ч үнэн байж болно. Үнэн ч бай, худал ч бай та энэ асуудлыг нягталж шалгах хэрэгтэй. Сурвалжлах ажлаа эхлүүлэхээс өмнө дараах асуултыг өөртөө тавина уу.

- ▶ Энэ мэдээлэл байгаагүй бол би энэ сэдвээр бичих байсан уу?
- ▶ Энэ сэдэв үнэхээр миний дэлгэхийг хүсдэг тэр асуудал мөн үү?
- ▶ Ил болсон энэ үнэн олон нийтийн эрх ашигт хамааралтай юу?

Хэрэв мэдээлэл тань өөр баримтаар давхар нотлогдож байгаа бол дээр дурдсан цагдаагийн дарга автомашины рекетүүдийн гэмт хэрэгт оролцсон явдалд эрэн сурвалжилга хийх эргэлзээнд таны өгөх хариулт тийм, тийм, бас дахин тийм байх болно.

Авлига, хээл хахууль - Зоосны хоёр тал

Тендерийн хорооны гишүүн эсвэл татвараас зайлсхийсэн мэдээллийг өгөгч эхнэр, нөхрийн нөхцөл байдалд та ямар арга хэмжээ авах вэ? Хуучин эхнэр эсвэл нөхөр нь хууль зөрчсөн байж болзошгүй ч нийгмийн хэв журам, олон нийтийн эрх ашигт төдийлөн нөлөөлөхгүй хэн нэг хувь хүний тухай мэдээлэл өгсөн байна. Энэ асуудал авлига хээл хахууль, татвараас зайлсхийх гэмт хэргийг төрийн бүтцийн түвшинд эмхлэн цэгцэлж чадсан улс орнууд эсвэл зарим нэг нийгмийн бүлгийн зан төлөвт нутагшсан газруудад дийлэнхдээ тохиолддог.

Сэтгүүлчид хэн нэгний хууль зөрчсөн үйлдлийг илрүүлэн дэлгэснээр бусдад сургамж болж, үүний үр дүнд авлига хээл хахуультай хийх тэмцэл шат ахин сайжирдаг гэж үздэг. Мэдээж хэрэг энэ бол үнэн. Илчлэгдэх айдас нь луйвар хийхээр санаархаж байгаа хэн нэгэн албан тушаалтныг зогсоож бага хэмжээгээр ч гэсэн ард түмний мөнгийг хэмнэнэ. Энэ нь татвар төлөгчдийн мөнгө учраас олон нийтэд энэ талаар “мэдэх эрх” нь байгаа. Гэвч хэвлэлээр тоо томшгүй олон хууль зөрчигч албан тушаалтнуудын талаар мэдээлэх нь авлига хээл хахуулийг бууруулахад нэг их нөлөө үзүүлж байгаагүй юм. Учир нь авлига хээл хахууль бүх ажил бизнес, байгууллагын бүтцийн түвшинд архагшсан байдаг. Зарим тохиолдолд бүр энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагын бүтцийн түвшинд ч бүрэлдэж бий болсон байдаг.

Сэтгүүлчдийн хувьд хувь хүн, албан тушаалтантай хөөцөлдөх бус харин авлига хээл хахуулийн жинхэнэ голомт болж, цэцэглэн хөгжүүлж байгаа системийг нь илрүүлэн, бүхэлд нь дэлгэснээр энэ асуудлыг шийдвэрлэх бодит хүчин зүйл болдог. Эрэн сурвалжлах сэтгүүлч та 'татвараас зайлсхийх гэмт хэрэг нэмэгдсэн нь төрийн үйлчилгээний эмнэлгийн хангамж дутагдаж байгаатай шууд холбоотой' гэдгийг нотолж чадах бол үүний талаар гомдоллосон мэдээ хийхээс илүүтэйгээр олон нийтэд баримтаар хүргэн тайлбарлах үүрэгтэй. Хэрэв авлигад орооцолдсон албан тушаалтан, фракц бүлэглэлүүд авлигатай тэмцэх байгууллага, албан тушаалтныг ашиглан таны гэрэл тусгасан асуудлыг өөрсдөөсөө холдуулж, гэмт хэргийн мөрөө баллаж чадсан бол та иргэдэд улс төрийн нууц үйл ажиллагаатай холбоотой гэмт хэргийн мэдээллийг хүргэсэн гэсэн үг.

Баримт мэдээлэл дэх бусад санаа

Өргөн хүрээнд унших нь тухайн баримтуудын талаар шинэ санааг олж авч, мэргэжлийн ур чадвар, бичих техникээ сайжруулан нэмэгдүүлэхэд их чухал байдаг. Сурвалжилж байгаа зүйлдээ итгэл үнэмшилтэй хандаж, сэдвийн талаар гарсан бүхнийг нягтлан уншиж байгаа нь таны ажил мэргэжилдээ хүлээсэн үүрэг, эрэн сурвалжлах сэтгүүл зүйн салбар дахь үйл ажиллагааны үндэс суурь байдгийг ойлгох хэрэгтэй. Сэтгүүлчид уншилгүйгээр аливаа тогтолцоо хэрхэн ажилладгийг ойлгож чадахгүй. Улмаар тогтолцооны хаана алдаатай зүйлс байгааг илрүүлж чадахгүй. Та бэлэн олдсон мэдээллийг боловсруулахад цагаа бүү үр! Харин мэдлэгийн чинь хүрээг тэлэх шинэ мэдээ мэдээллийг тасралтгүй эрж хайдаг байх хэрэгтэй.

Эрэн сурвалжлах сэтгүүлч, эрхлэгчдийн холбооны (IRE) гүйцэтгэх захирал асан Брант Хьюстон тус холбооноос гаргасан гарын авлагад орон нутгийн сонин эрэн сурвалжлах баримтуудыг маш ихээр агуулж байдаг тухай сэтгүүлчдэд сануулсан байдаг. Хууль ёсны дагуу хийгдэж байгаа бүх төрлийн төлбөртэй зарын цаана хууль бус гэрээ хэлцэл, дуудлага худалдаа, тендер, барьцааны хөрөнгийн луйвар, нэрээ нууцалсан эрхмүүд байдаг. Түүнчлэн, орон нутгийн сонинууд засгийн газрын шинэ төсөл, бүтээн байгуулалт болон орон нутгийн шүүхийн шийдвэрүүд зэрэг сонирхолтой мэдээ баримтуудыг хүргэж байдаг. Та эдгээр сониноос согтуугаар жолоо барьсан сургуулийн автобусны жолооч эсвэл дэлгүүрээс хулгай хийсэн санхүүгийн ажилтны нэртэй ч таарч болох юм.

Сэтгүүлчдийн анхаарлыг баримттай хэвлэгдсэн зүйлс маш бага татдаг. Уг нь уншигчдын судалгаа тэд ямар сэдвийг илүү сонирхож байгааг тогтмол

үзүүлж байдаг. Уншигчид энэ үйл явдлын дараа юу болох, яагаад энэ зүйл болсон, энэхүү өдөр тутамд дурдагддаг мэдээллийн цаана бодитоор юу болж байгааг мэдэхийг хүсдэг. Та ‘яагаад’ гэдэгт хариулдаггүй, эсвэл зөвхөн асуудлын нэг өнцгийг барьдаг телевизийн мэдээллийг онцгойлон анхаар. Дэлхий дахины эсвэл орон нутгийн хэмжээний тэмдэглэлт өдрүүд, арга хэмжээ гэх зэрэг ойлгомжтой, анхаарал үл татах мэдээллийн цаана халхавчлагдсан бусад зүйлийг эрж хайх хэрэгтэй.

Албаны хүмүүс, төрийн бус байгууллагуудын тайлан мэдээ ихэвчлэн нэг хэвийн, улиг болсон бичлэгтэй байдаг. Олон сэтгүүлч энэ тайлан мэдээг сонирхолтой баримтын эх сурвалж гэж харахаас илүү ердийн ажлын хэрэгсэл болгон авч үздэг. Гэвч эдгээр тайланг анхааралтай ажиглаж чадвал та эрэн сурвалжлах хэмжээний шинэлэг, чадварыг тань сорьсон мэдээллийг олж авч болно.

Нөөц боломжийн дутагдал байх, эсвэл газарзүйн бэрхшээлтэй холбоотойгоор та гадаад хэвлэл, вебсайтууд руу тэр бүр орох бололцоогүй байж болох ч эрэн сурвалжлах сэтгүүлчид өөрсдийгөө мэдээллээр хангаж болох бүх сувгийг ашигладаг байх хэрэгтэй. Элчин сайдын яам, төрийн бус байгууллагуудын олон төрлийн мэдээллийн сүлжээ нь ихэвчлэн үнэ төлбөргүй уншлагын танхим, номын сан, интернет кафетай байдаг. Хэрэв үүнээс өөр арга замгүй бол сэтгүүлчид энэ газруудад аль болох их очиж мэдээлэл авах дадлыг хэвшүүлэх хэрэгтэй юм.

Хэрэв Та интернеттэй бол иргэдийн үзэл бодол, асуудал дэвшүүлсэн байр суурьтай танилцахын тулд мэдээний сайтууд, твиттер, фэйсбүүк гэх мэт нийгмийн сүлжээнд тогтмол ханддаг байх хэрэгтэй. Твиттер нийгэмд өрнөж байгаа асуудлын талаар хамгийн сүүлийн үеийн, хангалттай хэмжээний анхан шатны мэдээллийг өгдөг. Энд төрийн үйлчилгээний талаарх мэдээлэл огцом өөрчлөгдөн хувирч байдаг эрүүл мэнд, шинжлэх ухааны салбаруудын чухал мэдээллүүд бий. Хөгжил муутай улс орны сэтгүүлчид ретровирусын эсрэг эм туршигдаж, Америк, Европт амжилттай нэвтэрснээс хойш хэдэн жил өнгөрчихөөд байхад ч ДОХ өвчинд үр дүнтэй эмчилгээ байхгүй талаар мэдээ бичсээр суудаг. Сэтгүүлчид мэдээлэл авах хэрэгсэлгүй буюу интернет ашиглах боломжгүй учраас л ийм нөхцөл байдалд орсон байдаг. Тиймээс тэд энэхүү чухал эрүүл мэндийн мэдээг иргэдэд хүргэхэд илүү их цаг хугацаа зарцуулдаг. Энэ эмийг авч хэрэглэх иргэдийн эрх тэр хүртэл хаалттай хэвээр байдаг.

Далд санаа, цуу яриа, баримтуудыг хэрхэн баталгаажуулах вэ?

Сэтгүүлчид баримт үйл явдлыг бүх талаас нь судалсан байх ёстой. Үүнд асуудалд оролцсон талууд, сөргөлдөөн, буруутгагч болон буруудагч байгаагийнх нь нөхцөл байдал зэрэг бүх тал орно. Гэвч тэдгээрийн талаарх эх сурвалжийн нууц мэдээлэл, цуу яриа, хувийн туршлага болон бусад судалгааны хэлбэрүүдээ хэрхэн баталгаажуулах вэ?

Та цахим хуудаст тулгуурласан судалгааны үеэр мэдээлэл цуглуулахдаа хоёр төрлийн чухал асуултыг авч үзэж байх хэрэгтэй. Эхнийх нь: Хэн үүнийг бичсэн бэ? Тэд хэр найдвартай хүмүүс вэ? Тэд энэ мэдээллийг яагаад бичсэн бэ? Одоо цагт жинхэнэ мэргэжилтнүүдээс эхлээд ухаантан болохыг мөрөөдөгчид, арилжааны сонирхлоор мөнгө авсан, улс төр болон хувийн ашиг сонирхолдоо хөтлөгдсөн хэн ч лобби хийх үүднээс ямар ч сэдвээр цахим хуудас, твиттер, фэйсбүүкд биччихдэг болсон цаг. Ийм л учраас цахим хуудсаас авсан мэдээллийн найдвартай байдлыг шалгах ёстой юм.

Хоёр дахь чухал асуулт бол энэ мэдээллийг гаргасан хувь хүний талаар төрийн үйлчилгээний ямар мэдээллийг авах боломжтой вэ? Эрэн сурвалжлах сэтгүүлчид тэдний амьдрал, боловсрол, эрхэлж хашдаг албан тушаал зэргийн талаар мэдээллийг олж авахыг хичээх хэрэгтэй. Тэдний фэйсбүүк болон жиргээг нь шалга. Шинэ аж ахуйн нэгжийн талаар мэдээлэл гарч ирвэл үүсгэн байгуулагчдыг нь эрэн сурвалжил. Түүнчлэн тэдний ажлын хамт олон, өрсөлдөгч болон төрийн алба хашиж байгаа холбоо сүлбээг нь давхар шалгана. Хөдөө аж ахуйн шинэ сайд томоохон үр тариа үйлдвэрлэгч компанийн ТУЗ-д сууж байгаа бол хууль зөрчсөн үү? Хуулиар зөвшөөрөгдсөн байсан ч ашиг сонирхлын зөрчил байгаа нь тодорхой хэрэг юм. Энэ төрлийн холбоо хамаарлыг илрүүлэх нь нэлээд том зүйлийг гаргаж тавихад хэрэгтэй хөшүүрэг болдог.

Түлш, газар, тэтгэлэг гэх мэт ховор нөөцийн талаарх мэдээ мэдээлэл нь тухайн нөөцийн хуваарилалттай холбоотой авлига хээл хахуулийн асуудлыг агуулж байдаг. Эдгээр нөөцийг хуваарилагч нар нь хэн, хуваарилах шат дамжлага нь ямар аргачлалаар явагдах ёстой байдаг талаар асуултууд нь авлига хээл хахуулийн гэмт хэргийг илрүүлэх, энэхүү ховор нөөц нь хэрхэн хэн нэгний хувийн ашиг болж хувирсан талаар мэдэхэд тусалдаг. Хэрэв та байгууллагын цахим хуудсуудыг анхааралтай ажиглавал албан тушаалтнууд ямар хэмжээний мэдээллийг ил тавьсан байгаагаас хэр хэмжээний зүйлсийг нууж байгаа нь илт харагддаг.

Төрийн өндөр албан тушаал хашиж байгаа албан тушаалтан эсвэл улс төрчид хуурамч мэдээллийн араас чулуу хөөлгөн, өөрийгөө хамгаалах

зорилгоор хуурамч нотолгоо баримт үүсгэх нь маш амархан байдаг. Албан бичгийн толгойг л авч чадвал компьютер, принтертэй хэн ч хуурамч баримт бичгийг үйлдэж чадна. Тэр бүү хэл эдгээр баримтууд нь жинхэнэ байсан ч гэсэн мэдээллийг хэсэгчлэн, далд утга санаа агуулсан, чухал мэдээллийг санаатайгаар орхигдуулсан байж болно. Зарим үед баримтууд нэр томъёо гэх мэт хэт их мэргэжлийн мэдээлэл агуулснаас ердийн сэтгүүлчид ойлгох боломжгүй байдаг. Энэ тохиолдолд бусад мэргэжлийн хүнээс тусламж авах шаардлагатай. Энэ төрлийн баримтуудад нягтлан бодогч, хуульч, эмч гэх мэт хөндлөнгийн мэргэжилтнүүдийн туслалцаа хэрэгтэй. Гэвч маш энгийн санагдах баримт бичгүүдэд ч өөрөөр тайлбарлан ашиглах зорилготой мэдээллийг агуулсан байж болдог. Заримдаа энэхүү ашиг сонирхол нь нотлогдоход тэдний мэргэжлийн ёс зүй зөрчсөн хэргийг харьцангуй бага тоон авч хэлэлцдэг. Авлига хээл хахуулийн талаарх мэдээлэл нь шумуул лугаа тархан нисдэг учир сэтгүүлчид өрсөлдөгчийнхөө хүчийг сулруулах, саад бэрхшээлээс ангижрах, зорилгодоо хүрэх үүднээс танд мэдээлэл өгсөн мэдээлэгчдийг ил гарган, хохирогч болгочихгүйн тулд анхаарал болгоомжтой ажиллах хэрэгтэй.

Ердийн эрэн сурвалжлах сэтгүүл зүйн өөр нэгэн арга хэлбэр бол олон салбарын төлөөлөлтэй тогтмол харилцаатай байх юм. Сайн харилцаа холбоо тогтооно гэдэг бусад сэтгүүлчийг мэдэхээс өмнө та үр ашигтай, шинэ мэдээ мэдээллийг бэлдэх боломжтой болно гэсэн үг. Гэвч ингэхийн тулд та эдгээр хүмүүстэй онцгой зорилгогүйгээр тогтмол харилцаатай байх хэрэгтэй. Та хэрэв зөвхөн хэрэгтэй үедээ л эх сурвалжуудтай уулздаг бол тэдэнд ашиглагдаад байгаа мэт сэтгэгдэл төрнө. Үүнийг ‘Эх сурвалжтайгаа ажиллах’ гэж нэрлэдэг. Мөн эх сурвалжаас авсан мэдээлэл чинь таны хайж байгаа сэдэвт яг таг таарч, тань руу чиглэсэн байх албагүй. Та өөрөө бүтээлч байж, сайн баримт санаа олж авахдаа сониуч, гярхай байх хэрэгтэй.

INSEAD-ийн эрэн сурвалжлах сэтгүүлч, профессор Марк Ли Хантер, түүний хамтран зүтгэгч Лук Сэнгерс нар дараах зөвлөгөөг өгч байна:

Бид мэдээлэл цуглуулах гэж ажилладаггүй, харин мэдээллийг баримт нотолгоо олж авахын тулд цуглуулдаг. Та хүмүүсийн сэтгэлийг хөдөлгөдөг байх ёстой. Та хүмүүсээр өөрчлөлт шинэчлэл хийлгүүлэхийн тулд тэднийг уурлуулж бас уйлуулах хэмжээнд байх ёстой.

Үүнээс өөрөөр та яах гэж амь нас, нөхөрлөл, харилцаагаа золин байж тэр их цаг хугацааг баримт нотолгоо олоход зарцуулсан гэж? Хүмүүс бол таны эрэн сурвалжлах бүтээлийн эшлэл баримт биш, харин жинхэнэ дүрүүд юм.

Бодит түүхийг хэрхэн бүтээх вэ?

‘Авлига’ гэх мэт нэр томъёонд маш олон төрлийн гэмт хэрэг орж болно. Тиймээс сэтгүүлчид эрэн сурвалжилга нь залилан хийсэн, хууль зөрчсөн, эрх мэдлээ хэтрүүлсэн (найз нөхөд, гэр бүлийн гишүүддээ давуу тал олгон ажил олгох, гэрээ байгуулах), хахууль өгсөн, албан үүргээ үл хайхарсан, дутуу хяналт тавьсан эсвэл санаатайгаар үйлдсэн гэмт хэргийн аль нь болохыг тодорхойлсон байх ёстой.

Сайн таамаглал нь бодит баримтуудыг ашиглан мөрдөн шинжлэх явцад тухайн асуудал бүрэн нотлогдохуйц (эсвэл үгүйсгэгдэхүйц) байх ёстой. Хоосон, тодорхой бус санааг батлаж нотлох, үгүйсгэх боломжгүй. Тиймээс эрэн сурвалжлах сэдвийн санааг гаргахдаа бодитой, тодорхой зүйлийг барьж авах нь чухал байдаг. Уурхайчдын тэтгэврийн сангаас өөрийн тансаг амьдралаа хангахын тулд хэдэн арван саяыг хулгайлсан бизнесмэн эр, албан өрөөндөө ганц кофены машин нийлүүлэх гэрээ байгуулах эрхийг эгчдээ олгож орхисон нарийн бичгийн дарга хоёрын хооронд том ялгаа бий. Та эрэн сурвалжлах асуудал сөхөж байгаа бол түүнд ашиглах эрэн сурвалжлах аргаа тодорхойлсон байх ёстой. Хэдий та дөнгөж эхлэж байсан ч энэ талаар заавал авч үзсэн байх хэрэгтэй. Ингэснээр танд хууль эрх зүй, мэргэжлийн ёс зүйн асуудлуудыг шийдвэрлэхэд дөхөм юм. Жишээ нь та өөрийгөө нууцлан ажиллах хэрэгтэй ч байж болно.

Гарчиг маш чухал



Эрэн сурвалжлах сэдвийн талаарх анхан шатны тойм судалгаа чинь ерөнхийдөө таны таамаглалыг баталгаажуулах эсвэл таньд өөр сэдэв барьж авах ёстойг чинь хэлээд өгнө. Таны дэвшүүлж байсан таамаглал чинь эсрэгээ эргэж ч болох юм. Гэвч та, таны редактор биш, таны эх сурвалж ч биш, зөвхөн та энэхүү өөрийн сэдвээ товчоор нэгтгэж хүчтэй, анхаарал татахуйц гарчиг өгөх хэрэгтэй. Гарчиг чинь таны сэдэв юуны талаар биш харин хүмүүсийн анхаарлыг үйл явдлын өрнөл рүү хандуулан барьж байхуйц байх ёстой. Гарчиг танд сайн сурвалжилгыг бүтээхэд, тэр бүү хэл хэвлэл мэдээллийн байгууллага энэ үйл явдлыг хэрхэн хүргэх талаар ч бүтээлчээр сэтгэхэд тань туслахуйц байх хэрэгтэй. Мэдээж та сурвалжилгын явцад илүү их мэдээлэл авах бүртгээ гарчиггаа өөрчлөөд явж болно. Та л өдий хүртэл явсан шүү дээ!

‘Эмч нар нялхсыг зэрэмдэглэж байна’ VS “Аврагдсан нялхас гудамжинд өвчтэй орхигдлоо”

Сэтгүүл зүйн профессор Марк Ли Хантер нэг удаа Америкийн эмнэлгүүдэд эмч нар дутуу төрсөн хүүхдүүдийг хэрхэн зэрэмдэглэж байгааг сурвалжлах даалгавар авсан тухайгаа ярьсан байна. Гэвч энэ мэдээлэл огт худал байсныг тэр олж мэджээ. Америкийн консерватив шашны үүсгэн байгуулагчдын лобби АНУ-д нэгэн шинэ хууль гаргасан байна. Хуулиар хугацаанаасаа эрт, дутуу төрсөн, амьдрах чадваргүй нярайг эмнэлгүүдэд зовиур шаналгаа ихтэй анагаахын шинжлэх ухааны аргыг ашиглан “хүчээр” амьдруулах ёстой болов. Энэ хууль батлагдахаас өмнө дутуу төрсөн, амьдрах чадваргүй нялхас ч хагалгаанд орж, элдэв гуурс тавиулах, судсаар хооллох гэх мэт олон төрлийн зовиур ихтэй хагалгаанд оров. Харин ч эмч нар энэ үед түүхэнд байгаагүй олон тооны нялхсыг амьд авч үлдэж байв. Харамсалтай нь аварч үлдсэн нялхас төрөлхийн архаг хууч өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд болон өсөв. Үүний зэрэгцээ, консервативууд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн халамжийн тэтгэмжийг хасч орхив. Ингээд ядуу, орлого багатай иргэдийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд төрөөс ямар ч дэмжлэггүй болсон байна. Эмч нарын аварсан өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй өч төчнөөн хүүхэд гудамжинд гарах болжээ. Ингээд Хантер энэхүү сурвалжилгандаа анхныхаас бага зэрэг зөөлөн ч яг эсрэг утгатай гарчиг өгсөн байна.

Редакцид санаа солилцох




Судалж байгаа сэдэвтээ дэмий цаг үрэхээс зайлсхийж сэдвийг тодорхой болгоход шаардагдах хамгийн их бөгөөд бага хугацааг тооцож үзэх нь чухал байдаг. Ингэсний дараа сэдэв баталгаажвал эрэн сурвалжлах ажилд оролцож болох редакцийн бусад гишүүдтэй энэ талаар санал солилцох хэрэгтэй. Энэ бол багаар ажиллаж, төслийг нягт уялдаа холбоотойгоор удирдан явуулахад маш чухал үе юм. Итгэл даах хамтран зүтгэгч, шийдвэр гаргагчидтай сурвалжилгын сэдвийг тодорхой болмогц хандан харилцаж эхэлснээр хүчирхэг багийн ажиллагааны үндэс суурь, хэвлэлийн нүүр дээрх таны төслийн боловсруулалт аль хэдийнэ бий болж эхэлсэн байдаг.

Ерөнхий зарчмыг баримтлах:

- ▶ Хүмүүстэй болгоомжтой харьцах хэрэгтэй, болох гэж байгаа үйл явдлын талаар редакцын нэгдсэн хурал дээр ярьж, гайхуулан бардамнахгүй байх. Заримдаа редакц дотор ч нууцлалыг хадгалах шаардлагатай байдаг!
- ▶ Багийн гишүүдийг нарийн гярхай сонго. Таны итгэж болох хүмүүс өөр хоорондоо ч маш хянуур, нягт байж чаддаг хүмүүс байх.
- ▶ Өөрийн ажлыг нарийн тоочихгүй байх. Энэ бол зөвхөн таамаглал төдий, нягталж шалгах зүйл олон байгаа сэдэв. Тиймээс хоорондоо хуваалцаж болох мэдээлэл, нууцлалтай харилцах мэдээллийг тодорхой ялгаж, салгаж өг.

Та далд агуулга, цуу яриа, нууц мэдээллийн учрыг олсны дараа аль болох хурдан эрэн сурвалжлах ажлаа эхлэхийг хүсэх байх. Гэвч судалгааг эхлэхээс өмнө та үүнийг хэрхэн эхлүүлэхээ төлөвлөсөн байх хэрэгтэй. Эхний шатанд хийх зүйлс, эрэн сурвалжлах судалгаа хийхээс өмнө болон дундуур нь анхаарах зүйлс гэх мэтчилэн. Дараагийн бүлэгт бид эдгээр асуултыг тодорхой болгоно.



ГУРАВДУГААР БҮЛЭГ

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАХ НЬ

Энэхүү бүлэг эрэн сурвалжилга хийхэд шаардлагатай төлөвлөгөө гаргах хэд хэдэн үе шатыг зааварчлах болно. Өөрөөсөө асуулт асуухаас эхлээд эх сурвалжаа судлах, төсвөө тооцох гээд энэхүү бүлэгт дурдсан жишээнүүд эрэн сурвалжилгад төлөвлөгөө ямар чухал болохыг батлан харуулна. Мөн найдвартай эх сурвалжийг хэрхэн таньж мэдэх, нарийвчилсан мэдээллийг ашиглаж хэрхэн сонирхолтой өгүүлэл бичингээ баримтад тулгуурласан мэдээлэл хүргэх талаар танилцуулах болно.

Эрэн Сурвалжилгыг Хэрхэн Төлөвлөх Вэ?

Та санаагаа оллоо гээд шууд эрэн сурвалжилга хийж болохгүй. Санаа гэдэг нь эхлэх цэг юм. Учир нь эрэн сурвалжилга гэдэг нь нийгмийн өмнө хүндхэн хариуцлага үүрэхээс гадна эрх зүйн олон эрсдлийг дагуулж байдаг тул таны сурвалжилга цэгцтэй, бүрэн төгс байх ёстой. Мөн эрэн сурвалжлах нь хамтын ажиллагаа бөгөөд бүх түвшний эх сурвалж шаардлагатай байдаг учир хамтран ажиллагсадтайгаа найрсаг харилцаатай байж, өөрт хэрэгтэй мэдээллээ цуглуулах боломжоо бүрдүүлэхийг зөвлөө. Энэ мэт шалтгаанаас хамаараад сурвалжилгаа маш сайн төлөвлөх шаардлага тулгарна.

Сэдвийн санаагаа хаанаас олсноос хамаарч төлөвлөгөөний ерөнхий хар зураг гарч ирнэ. Хэрвээ сэдвийн санаагаа өөрийн ажиглалт, эсвэл хэн нэгний богино ярианаас авсан бол тухайн эх сурвалж чинь бодит түүх дээр үндэслэсэн эсэхийг нягталж, дараа нь энэ сэдэв өргөн цар хүрээг хамарч байгаа эсэхэд анхаарал хандуулаарай. Хэрвээ таны санаа ямар нэгэн зөвлөгөөнөөс урган гарч ирсэн бол эхний алхмаа хийхээсээ өмнө тухайн зөвлөгөө мэдээллийнхээ үнэн бодит, найдвартай байдлыг зайлшгүй шалгах шаардлагатай. Хэрвээ өө сэвгүй, хөдлөшгүй баримтан дээр тулгуурлан гаргасан бол тухайн санаагаа батлах юм уу, үгүйсгэх юм уу, эсвэл хариулах юм уу гэх зэргээр өнцгөө нарийвчлан тодорхойлох нь эхний алхам болох юм. Гэхдээ энэхүү алхам нь хөдлөшгүй байх албагүй, яаж ч өөрчлөгдөж хувьсаж, шинэ санаа, шинэ аргачлалаар баяжуулах боломжтой, уян хатан байх хэрэгтэй.

Ихэвчлэн, сонгосон сэдэв өргөн хүрээг хамарч сурвалжилгыг нүсэр (заримдаа бүр удирдаж боломгүй) хэмжээтэй болгох нь байдаг. Америкийн “Атланта-Журнал Конститушн” сонины эрхлэгчээр ажиллаж байсан эрэн сурвалжлах сэтгүүлч Томас Оливер тэмдэглэхдээ “Сэдвийнхээ хүрээнд нэг л асуудлыг хөндөхийн оронд бүхнийг хамарсан, бүгдийг харуулах гээд байдаг хандлага бий. Энэ бол сул тал болохоос чадвар биш юм” гэжээ. Сэдвээ хөгжүүлж, сайжруулах шалгарсан арга бол санаагаа хэрхэн гаргах арга замаа тодорхойлох юм. Сурвалжилгынхаа дүгнэлтийг бичих гэж оролд. Энэ нь сурвалжилгын төгсгөл ямар байгаасай гэж хүсч байгааг нэг цогц болгон бичнэ гэсэн үг. Энэ бол редакцийн тархийг задалж, боломжит арга замуудын ерөнхий дүр зургийг гаргаж ирэх арга юм. Мөн асуудлыг дотоодын өнцгөөс сайн тусгах уу, бүс нутгийн эсвэл олон улсын өнцгөөс сайн тусгах уу гэдгээ тодорхойлоход ч хялбар болгоно. Үүний тулд дараах асуултуудыг ашиглаарай::

- ▶ Юу болж өнгөрөв? Яагаад үүнийг уншигчид анхаарах ёстой вэ?
- ▶ Энэхүү асуудлыг хэн үүсгэв? Хэрхэн өрнөв? Үр дагавар нь юу вэ?

ХАЙ

УУЛЗ

АСУУ

БИЧ

- Энэ асуудлын юу нь буруу вэ? Яагаад буруу гэж? Үр дагавар нь юу вэ?
- Мэдээ нь юу вэ? Үйл явдал нь юу вэ? Энэхүү сэдэвтэй холбогдож байгаа түлхүүр үгс нь юу вэ?
- Шалтгаан нь юу вэ? Энэхүү сурвалжилгыг бэлтгэснээр хэнд ашигтай болон хэн үгүйсгэгдэн шүүмжлэгдэх вэ? Нийгмийн дунд байгаа маргааныг шийдвэрлэхэд нийтлэл чинь нөлөөлөх үү? Нийтлэл чинь буруутай үйл ажиллагаа, тогтолцооны гажуудлыг ил тод болгож чадах уу?

Эдгээр бүх асуулт сурвалжилгын чиг баримжааг тодорхойлохоос гадна бусдад хүргэхэд юу хэрэгтэй болохыг тодорхойлоход тусална.

Жишээлбэл, ус түгээх үйлчилгээг хувьчлах үед суулгалт өвчний дэгдэлт гарлаа гэж бодъё. Тэгвэл хувийн компаниас ус худалдаж авч чадахаа больсон хүмүүс хаанаас ус авах боломжтойг /түлхүүр үг: хүртэх боломж/, эсвэл усны байгууламж дээр очиж усны аюулгүй байдлыг хангаж байгаа нь иргэдэд хүртээмжтэй байгаа эсэхийг /түлхүүр үг: амарчлаа/ сурвалжилж болно. Дээрх асуултуудыг анхааралтайгаар уншиж, хариулснаар сурвалжилгыг үнэ цэнэтэй, утга учиртай болгож байгаа зүйлсийг тодорхойлж байгаатай адил юм. Мөн олон нийтийн сонирхол зэрэг тухайн сэдэвт чухал зүйлсийг тодорхойлж, ашгийн төлөөх сурвалжилгыг ч илрүүлж таслан зогсооход хүргэнэ. Агуулгаа тодорхойлохдоо дэл сул нэр томъёо хэрэглэхээс зайлсхийгээрэй! Өөрт шаардлагатай бүх баримтаа цуглуулчихаад эдгээр асуултуудыг эргэн нэг харж бичих арга барилдаа ашиглаарай.

Санаанаас таамаглал руу

Сэдвийнхээ санааг дахин нэг эргэцүүлчихээд, тэдгээр анхдагч санаагаа тодорхой нэг таамаглал болго. Эсвэл сурвалжилгаараа дамжуулан ямар асуултын хариу өгөх гэж байгааг бодоорой. Энэхүү таамаглал эсвэл асуулт нь богино, урт, ганц хоёр өгүүлбэр ч бай, цуглуулсан баримттай хамааралтай байж, таамаглалыг хангалттай нотлох эсэх нь тодорхой болох юм.

Нэмж тодруулбал:

- ! Таамаглал нь сурвалжилгын зааг хязгаар болон хүрэх үр дүнг тодорхойлсноор зохион байгуулалт хийхэд хялбар болгоно.

- ! Таамаглал нь бусадтай харилцах, зорьсон санаагаа бусдад түгээж, “борлуулахад” тусална.
- ! Таамаглал нь эх сурвалж болон үйл ажиллагаанд зарцуулах цагийг маш нарийн тодорхойлно.
- ! Таамаглал нь баримт нотолгоо цуглуулах, түүний харилцан хамаарлыг тодорхойлоход тусална.
- ! Таамаглал нь эрэн сурвалжилгын эцсийн бүтээлийн дэс дараалал, уялдаа холбоог тодорхойлох гол суурь болно.

Сэдэв бүр олон таамаглалтай эсвэл олон чиглэлтэй байж болно. Жишээлбэл, ядуурал, хувьчлал, уснаас үүдэлтэй халдвар тархалттай холбоотой хоёр таамаг байж болно.

- (A) Хувьчлалаас улбаалж, ядуу айл өрхүүд өндөр үнэтэй ус худалдан авах чадваргүй болж, үнэ төлбөргүй, сайжруулаагүй задгай ус ундандаа хэрэглэснээр халдвар аваад байна.
- (B) Хувийн компаниуд амар хялбар аргаар ашиг олох зорилго тавьж, ундны усны эрүүл ахуй, аюулгүй байдлын стандартыг зөрчиж, зардлаа хэмнэснээр халдвар тараагаад байна

Гэхдээ эдгээр таамаглалыг бодитоор шүүн тунгаах нь зүйтэй. Тэдгээр компаниуд яагаад сэтгэл зовинохгүй байгаа нөхцөл байдлыг тооцоолохоос гадна үнэхээр тэднийг буруутгах бодит үнэн нөхцөл байдал байгаа гэдэгт хэр итгэлтэй байгааг өөрөөсөө асууж үзээрэй. Дээрх хоёр таамаглал нь туршигдаж үзээгүй санаан дээр тулгуурлаж байгаа. А нь баталгаагүй, албан бус усны эх үүсвэрээс хэрэглэснээс үүдсэн алдаа, В нь усны байгууламжийн стандартыг мөрдөөгүй нь алдаа гэсэн байр суурьтай байгааг анхаарна уу. Эдгээр таамаглалын аль алиных нь бодитой байж болох бүхий л боломжийг судалж, илрүүлэхээс гадна “Яг хаанаас энэхүү халдвар эхэлсэн бэ?” гэдэг ул суурьтай асуулт ямагт дагалдана.

Илүү сайн таамаглал дараах байдлаар гарч ирж болно:

- (C) Х газар нутагт гарсан уснаас үүдэлтэй халдварын тархалт нь ямар ч байсан хувьчлагдсан ус түгээгүүрийн сан, эсвэл баталгаагүй, албан бусаар ус түгээж байгаа газрын аль нэгээс эхэлсэн нь тодорхой.

Энэхүү боловсронгуй таамаглал нь сэдвийн чинь үндсэн зарчмыг тодорхойлж, сурвалжилгын хамрах хүрээ, явах замыг илүү тэнцвэртэй, тодорхой болгож өгнө:

(D) Х газар нутагт усан хангамжийн хувьчлалын дараа олон хүнийг хамарсан, ундны усны эрүүл ахуйтай шууд холбоотой гоц халдварт суулгалт өвчин гарсан. Энэхүү халдварт өвчин ямар шалтгаанаар гарсныг тодруулах нь сурвалжилгын зорилго юм. Хувьчлагдсанаар үнэ нь нэмэгдсэн ус авч чадахгүйн улмаас иргэд ил задгай худаг эсвэл гол, горхины түүхий ус хэрэглэснээс болсон уу? Эсвэл ус түгээлтийн компани хувьчлагдаж, усны байгууламжийн зардлаа бууруулж, ашиг олохын тулд ус цэвэршүүлэх стандартыг дордуулж, шаардлагад нийцсэн цэвэр ус түгээхээ больсон юм уу? Халдварт өвчний талаар эрдэмтэн, судлаачидтай ярилцаж юунаас үүдэлтэйг асуух хэрэгтэй. Дараа нь амьжиргааны түвшин доогуур ард иргэдтэй уулзаж, тэднийг өдөр тутам ус хаанаас авч байгааг тодруулж, мөн усны байгууламжид мэргэжлийн хүмүүстэй хамт очиж, ус цэвэршүүлэх үйл ажиллагаа стандартыг хангаж байгаа эсэхийг шалгаж үзнэ. Улмаар халдвар юунаас эхэлснийг олж мэдсэний дараа халдварт өвчин дахин дэгдэхээс хэрхэн урьдчилан сэргийлэх ёстойг судалж үзнэ.

Таамаглал хэрхэн дэвшүүлэхийг тодорхой болгосны дараа судалгааны төлөвлөгөө гаргах шаардлагатай. Үүнд эх сурвалж олох, нотлох баримтын шалгуурыг тодорхойлох, аргачлал боловсруулах, цаг хугацааны хэлхээс дэс дарааллыг урьдчилж гаргах, төсөв тооцоолох зэрэг багтана. Дараагийн хэсэгт эдгээр бүх алхмын ерөнхий тоймыг тусгасан. Харин удаах бүлэгт эдгээр алхмыг хэрхэн, яаж хэрэгжүүлэхийг нарийвчлан зааварчилсан болно.

Эх сурвалж

Бодит санаагаа тодорхойлж, таамаглал дэвшүүлсний дараа эх сурвалж олох нь эрэн сурвалжилга хийх бас нэгэн алхам болно. Тухайн сонгосон сэдвийн гол дүрүүд хэн болох, тэдний үйлдлийг нотлох баримт хэнд байгааг тодорхойлно. Олон нийтийн мэдээлж байгаагаас ажиглахад ихэнхдээ засгийн газар, эмнэлгийн ажилчид, тодорхой албан байгууллагууд, гэмт хэргийн бүлэглэл, эсвэл авлигад идэгдсэн улс төрчид рүү чиглэсэн байдаг. Олон төрлийн эх сурвалжууд дэвшүүлсэн таамаглалыг чинь нэг бол баталж, үгүй бол няцаах болно. Ямар ч үед хоёр төрлийн эх сурвалжийн зарчмыг баримтлаарай. Өөрөөр хэлбэл нэг төрлийн ижил мэдээллийг хоёр эх сурвалжаар баталгаажуулна гэсэн үг юм. Эдгээр эх сурвалжууд таны ар талыг даах, хамгаалах мэргэжилтнүүд шиг байх болно /холбогдох хаягийг нь дэвтэртээ тэмдэглэж авсан эсэхээ шалгаарай/. Эх сурвалжууд чинь анхдагч эсвэл хоёрдогч байж болно.

1

Анхдагч эх сурвалж

Ийм эх сурвалж нь ямар нэгэн дамжлагагүй анхдагч нотлох баримт болдог ба сэдвийн гол үйл явдалтай шууд холбогдсон байдаг. Жишээлбэл, өвчтөн сувилагчаас эмнэлгийн арын хаалгаар эм худалдаж авсан бол өвчтөн өөрийн биеэр тэрхүү үйл явдлын гэрч болсноор өөрт байгаа мэдээллээ чамд өгч болно. Гэхдээ мөн чанартаа сувилагч нар ерөнхийдөө юу хийдгийг шууд нотлох баримт болж чадахгүй. Усны байгууламжийн ажилтанд удирдлагаас нь усны цэвэршүүлэлтийг долоо хоногт нэг удаа биш сард нэг удаа шалгах үүрэг өгсөн байж болно. Засгийн газрын гишүүний банкны тодорхойлолт дээр түүнийг олон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг зэвсэг нийлүүлэгч компаниас мөнгө авсан баримт нь гарч ирж болно. Анхдагч эх сурвалжийг “анхдагч” гэдгийг нь нотолж, үнэн зөв мэдээлэл өгч байгаа эсэхийг нь тогтоож чадвал энэ нь хамгийн үнэ цэнэтэй эх сурвалж болох учиртай. Яагаад гэвэл ямар нэгэн шат дамжлагагүй шууд баталгаа нь өөрсдөө болдог юм. Ихэвчлэн, тэднийг олоход хэцүү байдаг. Иймэрхүү үйл явдлын гэрч болсон хүн мэдээлэл өгөх дургуй байдаг нь хожим дарамт шахалтад орохоос айдагтай холбоотой. Мөн банк, эмнэлэг зэрэг газруудтай холбоотой баримт бичиг, мэдээлэл хувийн нууцлалтай холбоотой тул хуулийн дагуу хязгаарлагдмал байдаг.

2

Хоёрдогч эх сурвалж

Энэхүү эх сурвалжид хэвлэгдсэн нийтлэл, материал, байгууллагаас гаргасан албан ёсны судалгаа, тайлан төдийгүй “Манай нэг найзын хэлснээр...” гэж эш татсан дам мэдээллүүд бүгд багтана. Хоёрдогч эх сурвалж чухал үүрэгтэй. Агуулгаа тодорхойлж, суурийг нь цутгахад ач холбогдол өндөртэй байдаг. Мөн асуудлыг тайлбарлахад дөхөм болох бөгөөд бусад эх сурвалжуудтай холбоо тогтоох гарцыг нээж өгнө. Гэхдээ хоёрдогч эх сурвалж болж буй бүхий л баримтыг /хүн ч бай/ сайтар нягтлах ёстой.

Нэмж дурдахад, аман эх сурвалж, бичиг баримт, дижитал (веб) гэсэн гурван төрлийн эх сурвалжаас сонгох боломжтой.

(а) Аман эх сурвалж

Энэ ойлголтод олон эх сурвалж багтана: гол тоглогч /оролцогч/, нүдээр харсан гэрч, мэргэжилтнүүд, сонирхлын бүлэг, идэвхтэн болон эсэргүүцэгчид. Эх сурвалж болж буй хүмүүсийнхээ албан ёсны бичиг

баримтыг сайтар шалгаж, байр суурь, зорилго зэргийг нь ойлгох хэрэгтэй. Хэрвээ ус хувьчлах асуудлаар сурвалжилга бэлтгэж байгаа бол, хувьчлалын эсрэг байгаа байгууллагууд чамд чухал мэдээллийг өгөхөд бэлэн байх болно. Гэхдээ энэхүү мэдээлэл нь зөвхөн нэг талыг баримталсан байхаас гадна олон бүлэг хүмүүсийг төлөөлдөг гэдгийг анхаараарай. Тухайн байгууллага хэсэг бүлэг хүмүүсийн үзэл бодлыг нэгтгэхдээ зарим чухал хэсгийг нь хасах, орхигдуулах эсвэл өөрчилж магадгүй. Заримдаа санамсаргүй тийм тохиолдол гардаг. Ийм учраас янз бүрийн санал сэтгэгдлийг өргөн цар хүрээтэйгээр авч үзээрэй. Тухайлбал хүнтэй уулзаж ярилцаж байгаа бол тэдгээр хүмүүсийг бүх нийтийн төлөөлөл болж чадаж байхаа эсэхийг эргэн нэг харах – эмэгтэй, эрэгтэй, залуу үе, ахмад настан, мөн янз бүрийн цалин орлоготой, өөр өөр сонирхлын бүлгийн төлөөлөл болох гэх зэргээр анхаарах хэрэгтэй. Хэн нэгний саналыг асуух нь сурвалжилгыг илүү амьд, бодитой болгох болно. Хэзээ ч бичиг баримт эсвэл цахим эх сурвалжийг дангаар нь ашиглаж болохгүй.

(б) Бичиг баримт буюу хэвлэмэл эх сурвалж

Үүнд ном, сонин, сэтгүүл, албан бичиг, банкны хуулга, гэрээ зэрэг бизнесийн баримтууд бүгд багтана. Мөн “саарал” материал буюу хэвлэгдээгүй ч эргэлтэд орсон бичиг баримтууд орно. Тухайлбал эрдмийн ажил, хувийн байгууллагын хийсэн судалгаа зэрэг орох бөгөөд эдгээр нь найдвартайд тооцогддог. Ихэвчлэн иймэрхүү хэвлэмэл эх сурвалжид хайж байгаа баримт нотолгоо агуулагдаж байдаг. Бид үүнийг “цаас дагах” гэж нэрлэдэг.

Гэхдээ эрэн сурвалжлах сэтгүүлчид ийнхүү хэвлэмэл эх сурвалжийг ашиглахад дараах бэрхшээл тулгардаг: Магадгүй тухайн эх сурвалжид дурдагдсан баримтыг бодит эсэхийг сэтгүүлч олж мэдэж чадахгүй байх, эсвэл эмх замбараагүйн улмаас хайлт хийхэд хүндрэлтэй байх, эсвэл мэдээллийн нээлттэй байдлын хууль байхгүйн улмаас хэвлэмэл бичиг баримт ашиглах эрх хязгаарлагдмал байх зэргийг дурдаж болох юм. Энэ хүрээнд заавал анхаарвал зохих нэг зүйл бол хэн нэгэн албан тушаалтан өөрийнхөө эсвэл төр засгийн бульхайг илчлэхгүйн тулд мэдээлэл хайх үйл ажиллагааг чинь зогсоож болзошгүй. Эрэн сурвалжилга хийхдээ анхдагч эх сурвалжаа хайх нь хамгийн гол ажил бөгөөд ямар төрлийн бичиг баримт байх вэ гэдгээс эхлэн хаана, хэрхэн хадгалагдаж байгаа, яаж олж авах вэ гэсэн асуудлууд гарч ирдэг. Хэрвээ албан ёсны зөвшөөрөл хүсч байж олж авах бичиг баримтууд бол эртнээс хийж эхлэх нь зүйтэй. Учир нь иймэрхүү албаны хүсэлт хэдэн долоо хоногоос сар гаран ч болох тохиолдол бий. Мэдээжийн буюу хэтэрхий ойлгомжтой материал бол эх сурвалж биш юм. Тухайлбал, лавлах, утасны жагсаалт гэх мэт.

Америкийн эрэн сурвалжлагч ахмад сэтгүүлчдийн нэг Билл Гэйнсийг амжилтад хүргэсэн бичиг баримт судлах арга нь:

“Би бусад хүмүүсийн орхигдуулсан сурвалжилгыг хийдгийн учир гэвэл үргэлж бичиг баримт олж болох газар луу явдаг байсантай холбоотой” гэж тэрбээр хэлж байсан. Гэйнс ихэвчлэн нууц бичиг баримт ухаж, нэгжилгүй олонд нээлттэй байдаг материалыг

л хянаж шалгадаг байсан юм. Тэрбээр нэг удаа үл хөдлөх хөрөнгийн тайлан ухаж байгаад нэг компанийн бизнес бүртгэл дээрх баримт дээр тулгуурлаж тухайн компанийг авлига авсныг илрүүлж байсан билээ

(с) Дижитал эх сурвалж

Энэ нь интернетэд байгаа эсвэл дижитал байдлаар хадгалагдсан бүхий л мэдээллийг хамруулдаг. Дижитал эх сурвалжийг хайж олох, баримт материал цуглуулахад янз бүрийн ур чадвар шаардлагагүй. Интернетэд байгаа мэдээлэл хэдийгээр нүд эрээлжилмээр их ч гэлээ хаанаас хүссэн мэдээллээ олж авч болохыг мэддэг байхад л хангалттай. Өөрөөр хэлбэл тухайн хайж буй мэдээллийнхээ үндэс нь хаана байгааг мэддэг байх шаардлагатай юм. Мөн албан тушаалтнууд өөрсдийнхөө талаар юу гэж бичиж, ярьж байгааг судлахын зэрэгцээ эргэн тойрных нь хүмүүс тэдний талаар юу гэж байгааг давхар судлах хэрэгтэй. Гэхдээ байнга санаж байх нэг зүйл бол интернет, цахим хуудас гэдэг нь зарим талаар удирдах, хянах боломжгүй орчин гэдгийг анхаараарай. Тухайлбал, хүн бүхэн хүссэн зүйлээ интернетэд оруулах эрхтэй бөгөөд үүний дотор ор тас худал зохиомол зүйлс ч багтаж байдаг. Мөн цахим мэдээлэл урт хугацаанд хадгалагддаг бөгөөд зарим ашиглаж болохуйц материалын он, сар, өдөр нь хэт хуучирсан байдаг. Хамгийн сүүлийн үеийн, шинэ мэдээллийг хайж байх нь зүйтэй. Европын Сэтгүүл зүйн Төвийн гаргасан “Нягтлан шалгах гарын авлага”-ыг үнэгүй татаж аваарай. Үүнд дижитал материалтай хэрхэн ажиллах арга зүй, техникийг зааварчилсан байгаа.

(d) Бүлэг эх сурвалж

Энэ нь аман болон дижитал эх сурвалжийг хослуулах шинэ арга юм. Энэ нь хэвлэл мэдээллийн хүлээн авагчдыг эрэн сурвалжилгын нийтлэлийн мөрөөр нэмэлт мэдээлэл өгч, хувь нэмрээ оруулахыг уриалдаг.

Эх сурвалж Юунд хэрэгтэй вэ?

Давуу тал

Боломжит эрсдэл

А
М
А
Н

_Эрэн сурвалжилгыг “амь оруулж” бодитой, итгэл үнэмшилтэй болгоно

_Ярилцлага хийхэд өндөр түвшний технологи шаардлагагүй

_Анхдагч эх сурвалж ярилцлага өгч гар бие оролцож сэтгүүлч сурвалжилгын итгэл үнэмшлийг нэмэгдүүлнэ

_Өрөөсгөл, гажуудалтай, зөрчилтэй, худал мэдээлэл өгөх магадлалтай

_Хэтэрхий товч мэдээлэл өгөх, хангалттай баримт дэлгэхгүй байх магадлалтай бөгөөд эх сурвалж нь зөв зохистой төлөөлөл болж чадах эсэхийг нягтлах шаардлагатай

_Хэвлэлд ярилцлага өгснөөр хохирогч болох эрсдэлтэй. (Эх сурвалжийг хэрхэн хамгаалахыг заавал бод)

Х
Э
В
Л
Э
М
Э
Л

_Хөдлөшгүй баримт нотолгоо болно

_Сэдвийг тойрсон үйл явдлын өрнөл, түүх болон орчин нөхцлийг тусгана

_Хоёрдогч эх сурвалж нь сурвалжилгын суурь судалгааг өргөжүүлж, асуудлын мөн чанарыг тодорхойлоход хамгийн тохиромжтой

_Анхдагч эх сурвалж болох боломжтой (банкны хуулга гэх мэт) нь найдаж болохуйц албан ёсны баримт болдог

_Хувь хүний нууцыг хадгалах, мэдээлэлд хяналт тавих гэх мэт зарим хуулийн зохицуулалтаар мэдээлэл олж авах боломж хязгаарлагдах эрсдэлтэй (ажлыг түвэгтэй бас удаашралтай болгох талтай)

_Зарим тохиолдолд эх сурвалжийн өгсөн мэдээллийн агуулгыг сайтар ойлгохын тулд мэргэжлийн хүний тайлбар зайлшгүй хэрэгтэй болно

_Хэт албаны, эрдэм шинжилгээний, мэргэжлийн агуулга нь сурвалжилгыг “үхмэл” болгох аюултай / бодит дуу хоолой, хүүрнэл үгүй мэт болгоно

Д
И
Ж
И
Т
А
Л

_Юуг дахин сэргээж болох вэ гэдгээс хамаарч дээрх бүх агуулгыг багтаана

_Компьютер ашиглан “бүхнийг” олох боломжтой. (дуу, дүрс хүртэл багтана)

_Дотоодын болон гадаадын, олон улсын өргөн цар хүрээг хамрах бөгөөд сүүлийн үеийн мэдээллийг багтаасан байна

_Сэдвийг “үхмэл” болгох эрсдэлтэй

_Аюулгүй байдлын үүднээс интернетийн зарим эх сурвалж хамгаалагдсан байна

_Интернет дэх их хэмжээний мэдээлэл дотроос цуурхал, худал, үнэнийг ялгаж салгахад хүндрэлтэй

Хэрэв зарим мэдээллийг олж авах боломж хязгаарлагдмал байвал тухайн улс орныхоо хуулийн гол зохицуулалтыг ашиглахыг хичээгээрэй. Жишээлбэл, Энэтхэг улсад “Мэдээлэл олж авах эрхийн тухай”, Өмнөд Африкт “Мэдээлэл олж авах эрхийг дэмжих тухай”, Сербийн бүгд найрамдах улсад “Нийтийн эрх ашгийн төлөө мэдээлэл олж авах нээлттэй байдлын тухай” зэрэг хууль хэрэгждэг. Улс орон бүрт мэдээлэл олж авах эрхтэй холбоотой хуулиуд байдаг боловч гарчиггаас нь эхлээд доторх агуулга нь ч ялгаатай байдаг тул олон улсын хэмжээнд хууль эрх зүйн талаас нь нийтлэг зөвлөмж гаргахад хэцүү юм. Тиймээс эрэн сурвалжилга эхлэхээс өмнө тухайн улсынхаа мэдээлэл олж авах эрх, үүнтэй холбоотой хууль зүйн зохицуулалтыг судлах нь үр дүнтэйг санаарай.



Эх сурвалжийн сүлжээ бий болгох

Эрэн сурвалжлах судалгааны үр дүнд тухайн үйл явдал өрнөлтэй холбоотой “цогц” эсвэл “зөрчилдөөнтэй” мэдээллийг агуулсан хамгийн тохиромжтой эх сурвалжийг тодорхойлсон байх ёстой. Үүний тулд зөв эх сурвалжийг олох хүртэл “харилцаа холбооны мод” зурах эсвэл “оюун санааны зураглал” хийх аргыг ашиглах шаардлагатай. Суурь мэдээлэл, баримт нотолгоо аль алинд нь шаардлагатай эх сурвалжийн мэдээллийг жагсаах нь төлөвлөгөөний нэг хэсэг болох учиртай юм.

“Оюун санааны зураглал” хийхдээ эх сурвалж бүрийг сумаар холбохоос гадна эх сурвалжтай холбоотой дүгнэлт мэдээллийг хавсаргана. Түүнчлэн эдгээр нэмэлт мэдээллийг хоорондоо зөрчилдөж байгаа, эсвэл нийцэж байгааг нь тодорхойлж “хөрөө” хэлбэртэй шугамаар холбох боломжтой. Зөрчилдөж байгаа мэдээлэл нь илүү анхаарах шаардлагатай буюу “үр өгөөжтэй” мэдээлэл байх магадлалтай гэж үзэж болно. Тиймээс “Яагаад?” зөрчилдөж байгааг байнга өөрөөсөө асуугаарай. Ингэж чадвал сэдэвт чинь “хөл ургаад” зогсохгүй “далавчтай” болж байна гэсэн үг юм. Хэдийгээр эрэн сурвалжилгад гэнэтийн саатал гарч, ихээхэн цаг хугацаа, тэсвэр тэвчээр шаарддаг ч ямагт гол өнцөгтөө анхаарал хандуулж, сэтгүүл зүйн зарчмыг баримталж байгаарай. Өөрөөр хэлбэл, сэтгүүл зүйн амин сүнс болох “хоточ нохой”-н үүргээ сахиж, нийгмийн “чимээгүй” хэсгийг төлөөлж, дуугарч байх ёстойгоо санагтун.

Марк Ли Хантер болон Люк Сенгерс нар мэдээллийг “Оюун санааны зураглал” хэлбэрт оруулж, эмх цэгцтэй болгоход шаардлагатай дараах зөвлөмжийг хүргэж байна:

- ▶ Үйл явдлын **он, цаг тооллын дарааллыг** гаргах (хэзээ, хаана, хэн, юу гэж ярьсан, юу хийгдсэн гэх мэт); эдгээрийг дараалалд оруулснаар хэрэгтэй баримтыг, хүссэн үедээ ялгаж харахад тус дэм болно
- ▶ **Эх сурвалжын жагсаалт** гаргах (холбогдох утас, хаягийг нь жагсааж, нууц байлгах, сайтар хадгалаарай)
- ▶ Бусад хүмүүстэй хамтран **хэрэгжүүлэх зүйлсийн жагсаалт** гаргах (хийж буй ажлыг чинь хэн сайн ойлгож, чамд туслах вэ?)
- ▶ Хүмүүс хоорондын **харилцаа хамаарлын диаграм** зурах
- ▶ Амин **чухал шаардлагатай баримт, материалын жагсаалт** гаргах (байгаа, байхгүй гэдгийг нь ард нь тэмдэглэх)
- ▶ Баримт, материалаа **бичгийн хэлбэрт буулгах**, компьютер ашиглаж байгаа бол тус мэдээллийг олж болох холбоос хаягийг жагсааж хадгалах
- ▶ Баттай болсон баримт, мэдээллийг **тодруулах** (ялгах тэмдэг тавих)
- ▶ Бусад баримт материалыг ямар хэмжээнд бүрдсэн байгаа **явцыг тэмдэглэх**
- ▶ Шинэ санаа болгоныг тэмдэглэх **дэвтэртэй** явах





Баримтын хүрэлцээтэй байдал

Эх сурвалжыг жагсаасны дараа, таамаглал шалгахад шаардлагатай баримт нотолгоонд юуг хамааруулах, эсвэл асуултад чинь бүрэн дүүрэн хариулт болох баримт байгаа эсэхийг тодорхойлно. Усан сан өмнөхөөсөө чанарын шалгалт цөөн удаа явуулдаг болсон гэдгийг энэ баримт хангалттай батлах уу? Эсвэл чанарын шалгалт хийх давтамжийг цөөлснөөр ямар үр дагавар гарсан бэ гэдэгт нэмэлт материал хэрэгтэй юу? Чадварлаг эрэн сурвалжлагч нар зөвхөн таамаглалыг батлахад шаардлагатай материал цуглуулах бус няцаах баримтыг ч хамт цуглуулдаг. Жишээлбэл, Засгийн газрын ажилтан аль хэдийнэ баяжсан тул 10 мянган ам.долларын авлига авч үйлчилгээ үзүүлэхийг нэг их хүсэхгүй. Няцаах баримтыг эрэн сурвалжлах гэдэг нь “хүсэл төдий бодолд” гэдэг урхинд автахаас сэргийлдэг (хүсэл төдий бодол – гэдэг нь яавал илүү амар хялбар байх бол гэж шийдвэр гаргах, түүндээ итгэх). Эрэн сурвалжилгын бүхий л үе шатанд өөрөөсөө найдвартай, бүрэн төгс нотлох баримтыг асуусаар байх шаардлагатай, эх сурвалжийн төрлүүд, эх сурвалжийн тоо, баримт, гэрчийг чинь юу үгүйсгэж болзошгүй гэдгийг хүртэл бодоорой. Цуглуулсан нотлох баримтуудаас аль нь илүү анхаарал болгоомжил, олон удаагийн нягтлал шаардлагатай байна вэ? Эдгээрийг эрэн сурвалжилгын үедээ тогтмол асууж, хянаж чадах уу?

“Нотолгоо” гэдэг ухагдахууныг юу гэж тодорхойлж байгааг сайн анхаарна уу. Ямар нэгэн зүйлийн талаар хөдлөшгүй баримт олно гэдэг тун ховор – үүнийг “дарь нь үнэртсэн буу” гэж нэрлэдэг. Таны таамаглал зөв гэдгийг батлах хангалттай баримт цуглуулж болно. Энэ нь эрүүгийн гэмт хэрэгт ял онооход туйлын тодорхой байдлыг, иргэний хэрэгт тодорхойгүй “магадлал”-ыг харгалзаж хариуцлага тооцдогтой адилхан юм. Сурвалжилгын эцсийн ноорог бэлэн болмогц баримтууд чинь үнэхээр баталгаатай юу, тодорхойгүй магадлал уу гэдэг нь харагдах бөгөөд ус нэвтэрдэггүй баримт нотолгоо байхгүй байсан ч сурвалжилга чинь бэлэн болсонд тооцож болно. Харин хэрхэн бичих вэ гэдэг нь маш чухал бөгөөд туйлын анхааралтай байдлыг шаардана.

Арга зүй

Шаардлагатай баримт материал, эх сурвалжийг шууд хайгаад л олчих боломжгүй. Тэдгээрийг олохын тулд бүтээлчээр эрж хайж арга зүйг ашиглах хэрэгтэй. Ихэнхдээ эрдэм шинжилгээ, судалгааны ажилд л иймэрхүү арга зүйг ашигладаг гэж боддог ч тийм биш бөгөөд энэ нь судалгааг чанартай хийхийн тулд тодорхой аргачлал ашиглах тухай ойлголт юм. Баримт материал хайх, судлах, биечлэн ярилцлага хийх, цахим хуудсуудаар зочилж, ажиглалт хийх зэрэг маш олон төрлийн арга зүйг ашиглах боломжтой

бөгөөд хамгийн найдвартай аргыг сонгох хэрэгтэй. Аль эх сурвалжийг ашиглах, тэр болгонд хэр их хугацаа зарцуулах, хийснээ тэмдэглэх арга замыг сонгох эсэх, ажлаа дуустал эдгээрийг хэрхэн үргэлжлүүлэх зэргийг нарийвчлан төлөвлөнө.

Таамаглалыг баталгаажуулах хангалттай баримт цуглуулахыг хичээ. Сэдвийн агуулга, суурь мэдээлэл, үйл явдлын өрнөл түүх зэрэг ерөнхий зураглалыг бий болгох нь шууд бус байдлаар арга замыг тодорхойлж байгаа нэг хэлбэр юм. Гэхдээ эдгээрийг анхдагч эх сурвалжаар дамжуулж цуглуулах нь илүү үр дүнтэй.

Мөн арга зүйг тодорхойлох гэдэг нь тулгарч болзошгүй саад бэрхшээлийг тооцоход чухал ач холбогдолтой. Хэрэв ямар нэг тодорхой баримтыг олж авах гарц хаалттай, эсвэл хэн нэг нь яриа өгөхөөс татгалзвал бэрхшээл тулгарна. Тэр үед “Б” төлөвлөгөө бий юу? Хаалттай баримт материал, эсвэл татгалзсан эх сурвалжаас өөр, ижил төстэй баримт материал, эх сурвалж хайж олох, анхны төсөөлөлтэй тэнцэхүйц “нотолгоо”, эсвэл “няцаалт” болж чадах уу?

Арга зүй тодорхойлсны дараа сурвалжилгынхаа цагийн хуваарийг гаргаж, төсвийг тооцох шаардлагатай. Цагийн хуваарь гэдэг нь сурвалжилгыг нийтдээ хэр урт хугацаанд хийхийг хэлэх бөгөөд архивын баримттай танилцах, ярилцлага хийх, цахим хуудсаар хайгуул хийх, найруулан бичих зэрэг ажилд хэдэн цаг зарцуулахаа нарийн тооцоолсон байх ёстой.

Янз бүрийн ажилд зарцуулах цагийг тодорхойлсны дараа нийт төслийн эцсийн хугацаа болон дуусгах наад захын хугацааг товлон. Сурвалжилгаа ийнхүү цагалбарт оруулсан бол эхнээс нь хийх ажлын хуваарийг гаргаарай. Тухайлбал, хэзээ, хэнтэй ярилцлага хийх, эсвэл судалгааг хэзээ хийх гэх мэт. Мөн судалгааг дуусгаж, сэдвээ багцалсны дараа бичих, редакторлах шаардлага гарах бөгөөд энэ хугацааг оруулан эцсийн хугацааг тодорхой болгох хэрэгтэй. Мөн түүнчлэн зөвшилцөх нь энэ бүх ажиллагааны нэг хэсэг бөгөөд цагийн хуваарийг мөрдөхдөө харилцаж, зөвшилцөх ёстой гэсэн үг юм.

Хэрвээ таны сэдэв олны анхаарлыг татсан “ноцтой сэдэв” бол бусад хэвлэл мэдээллийнхэн хамт уралдаж байгааг битгий мартаарай. Тиймээс тэднээс түрүүлж өөрийн сурвалжилгыг олонд хүргэхийг хүсвэл яаравчлах шаардлагатай. Гэхдээ эрэн сурвалжилгыг шуурхай хийж, хасаж танах ёсгүй, учир нь энэ нь хууль эрх зүйн хүрээнд олон үр дагаврыг дагуулдаг хариуцлагатай ажил юм. Хэдийгээр эрэн сурвалжилгыг бүрмөсөн дуусгаагүй байсан ч цагийн хуваарийг нягталж, уялдаа холбоо, үнэн бодит байдлын хувьд аль хэсгийг нь түрүүлж нийтэлж болохоор байгааг хэсэгчлэн сонгож болно.

Төсөв

Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн төлөвлөгөөний нэг чухал хэсэг бол төсөв батлах ажил юм. Эрэн сурвалжилгад мөнгөний боломж болон эх үүсвэрээс нь хамаарч хэр их санхүүжилт зарцуулах вэ? Төсвөө батлахад аяллын зардал, байр сууц, хоол (эх сурвалжаа дайлах зочлох зардал байх хэрэгтэй), мэргэжлийн зөвлөх, орчуулагч, хөрвүүлэгч, үйлчилгээ үзүүлж байгаа хүмүүст өгөх мөнгө, архив ухах, судалгаа хийх, хайх, баримт бичгийг нотариатаар баталгаажуулах зардал, харилцаа холбоонд зарцуулах төсөв (утас, интернет), зураг авах, угаах мөнгийг тооцоорой. Хэрвээ багаар ажиллаж байгаа бол удирдлагууд (менежерүүд), ажлын хэсэгт олгох санхүүжилт болон эрдэм шинжилгээний томилолтын зардлыг ч мөн багтаах хэрэгтэй.

Хөгжиж буй орнуудын хэвлэл мэдээллийн байгууллагын төсөв хязгаарлагдмал, санхүүжилт бага байдаг. Харин Америкийн эрэн сурвалжлах сэтгүүл зүйд оруулж байгаа нэг удаагийн хөрөнгө оруулалт л гэхэд нэг сонины бүтэн жилийн үйл ажиллагааг хангах хэмжээний зардал ч байж болзошгүй. Ийм нөхцөлд санхүүжилт, дэмжлэг авч болох өөр боломжийг хайх хэрэгтэй. Хамгийн оновчтой хувилбар бол олон улсын байгууллагууд юм. Зарим тохиолдолд ийм байгууллага нь сэтгүүлчидтэй ижил санаа зорилготой байх боломжтой. Гэхдээ тэдний дарамт шахалт, үзэл бодол сурвалжилгад чинь шингэх вий гэдэгт болгоомжтой хандаарай. Хэрвээ тэд чамтай ижил санаа зорилгогүй бол хамтарч ажиллаж цагаа битгий үрээрэй. Дараагийн нэг арга бол олон нийтийн дэмжлэг, хандив юм. Сэтгүүл зүйн ерөнхий сэдвийн хүрээнд төсөл хэрэгжүүлж, хэвлэн нийтлэх нь эрэн сурвалжлах сэтгүүл зүйн үүднээс чамайг алдартай болгох ч илүү хүнд хэцүү байх болно.

Олон нийтээс хандив, хөрөнгө босгосон амжилттай төслүүдийн талаарх сайн туршлага болон тэтгэлэг олгодог зарим боломжит хөтөлбөрүүдийн талаар дараах холбоосоос мэдээлэл авч болно.

- @ gijn.org/resources/grants-and-fellowships
- @ fij.org/grant-application
- @ gijn.org/resources/crowdfunding-for-journalists-2

Ихэнх сэтгүүлч эх сурвалжид мөнгө төлөхийн эсрэг байр суурьтай байдаг. Мөнгө төлөх нь эх сурвалжийг худлаа хэлэх, эсвэл асуудлыг хэтэрхий дэвэргэх өгөөш болдог. Түүнээс ч илүү сөрөг тал нь сурвалжилга нийтлэгдсэний дараа баримт нотолгоонд чинь итгэх итгэлийг унагаж, үгүйсгэлийг араасаа дагуулдаг. Өөрөөр хэлбэл мөнгө төлсөн болохоор

л ингэж хэлсэн байх гэсэн хардлага төрүүлдэг байна. Мөн өөрийн сурвалжилгыг бүтээхийн тулд хэн нэгэнд мөнгө төлнө гэдэг нь сэтгүүлчийн ур чадварыг дордуулах ба сэтгүүлчийн ёс зүйд нийцэхгүй юм. Гэхдээ зарим онцгой тохиолдолд, эх сурвалж чамд ярилцлага өгч байгаа, эсвэл хол замыг туулж чамтай уулзах зэргээр ажил, амьдралын цаг заваа алдаж байгаа тохиолдолд эх сурвалжийг эдийн засгийн хохиролгүй үлдээх нь зүйтэй. Харин ийм тохиолдолд талууд тухайн мөнгийг ямар шалтгааны улмаас, юуны төлөө олгож байгааг маш тодорхой харилцан ойлголцсон байх шаардлагатай. Ингэснээр тохирох үнийн дүнгээр төлбөр хийх учиртай юм. Эх сурвалждаа тэд ганцхан хувь хүнд эсвэл хувь хүний ашиг сонирхлын төлөө мэдээлэл өгөөгүй гэдгийг ойлгуулах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, эх сурвалж нийтийн ашиг сонирхлыг хамгаалж, нийгмийн сайн сайхан, шударга үнэний төлөө дуу хоолой болж байгааг ойлгох шаардлагатай.

Албаны эх сурвалжид мөнгө төлж мэдээлэл авах нь байж боломгүй зүйл билээ. Гэхдээ зарим орон нутагт, албаны хүмүүс бяцхан дайллага, бэлэг сэлт (хоолонд урих, уух зүйлээр дайлуулах) авах зэрэг соёл аль хэдийнэ төлөвшүүлчихсэн байдаг. Бяцхан бэлэгний хариуд ажлын цагаа арай эрт эхлүүлэх зэргээр эргээд тус болох тохиолдол ч бий. Ийм уламжлалтай газар албан тушаалтныг бага ч гэсэн дайлахгүйгээр ажил бүтээнэ гэж үгүй. Гэхдээ өчүүхэн төлбөрөөс болж бүтэн сурвалжилгыг эрсдэлд оруулахгүй байхыг хичээ. Өөрөөр хэлбэл, энэ нь хэдий жижиг асуудал мэт боловч хэрэв эх сурвалж дараа нь ямар нэгэн байдлаар өөрийн удирдлагад эсвэл өрсөлдөгч хэвлэл мэдээллийн байгууллагад төлбөр төлсөн, дайлсан гэдгийг мэдэгдчихвэл энэ нь авлигад тооцогдох болно. Тиймээс иймэрхүү төрлийн шан харамж нэхсэн шаардлагыг хэрхэн зөв зохицуулах тал дээр сайтар бодох хэрэгтэй. Тухайлбал, дараа нь асуудал үүсвэл өөрийн байр суурь, баримт нотолгоог баталж чадах уу? (ялангуяа, уншигч үзэгчдэд) гэдгийг ямагт бодолцож байх ёстой юм. Хамтран ажиллаж байгаа хүнтэйгээ чин сэтгэлээсээ ойлголцож, хэчнээн чухал ач холбогдолтой бүтээл хийж байгааг тайлбарлах, эргэн санах нь үргэлж үр дүнтэй байдаг.

Сурвалжилгаа босгох

Хэрвээ танай байгууллага, хэвлэлийн газар танд эрэн сурвалжилга хийх даалгавар өглөө гэж бодоход бүхий л гаргасан төлөвлөгөө эрэн сурвалжлах эхний үе шат л гэсэн үг. Гэхдээ хэрвээ та чөлөөт сэтгүүлч бол гаргасан төлөвлөгөөнд тань редактороо ятгахуйц бүхий л мэдээлэл багтаж байх нь зүйтэй. Сурвалжилгаа “босгох” гэдэг нь сэдэв нь юу вэ? гол санаа нь юу вэ? гэдгээс эхлээд яагаад энэ сэдвийг заавал хөндөх ёстой вэ? гэсэн редакторын наад захын асуултад бүрэн хариулж чадахуйц байх ёстой. Үүнд дараах бүрэлдэхүүн хэсгийг багтаана:

- ▶ Сэдвийн гол агуулгыг хянаж засварласан товч тайлбар
- ▶ Яагаад энэ сэдэв нийтлэгдэх, уншигдах ёстой вэ?
- ▶ Хэрхэн хийх вэ гэсэн арга зүйн товч төлөвлөгөө
- ▶ Цаг хугацааг тооцсон хуваарь
- ▶ Төсөв санхүү

Зарим хэвлэл мэдээллийн байгууллагууд сэдвийг график, дүрс, зургийг ашиглан ямар бүтэцтэйгээр хүмүүст хүргэх санал, арга барилыг шаардаж болно. Зарим газарт ийм төрлийн ажлыг редактор болон дизайнерууд хийхээр томилогдсон байдаг. Гэхдээ ямар ч тохиолдолд, хэвлэлийн газарт чиний сурвалжилга “хангалтгүй байж болзошгүй” гэдэг өнцгөөс нь бодож бай. Тэгснээр хамгийн чухал гэсэн мэдээллийг түүж, сурвалжилга хийх явцдаа олсон илүүц материалаа хаяж чадах болно.

Төлөвлөгөө Гаргах Явцдаа Цагаа Хэрхэн Зөв Хуваарилах Вэ?

Сурвалжилгыг хэрхэн төлөвлөх, тохиромжтой санаа олох, тэр дундаа эх сурвалжийг тодорхойлчихвол сурвалжилгаа эхлэх эхний шугаман дээр зогсож байна гэсэн үг. Гэхдээ үйл ажиллагааны туршид бодвол зохих хэд хэдэн зүйл бий.

Эрэмбэлэх

Сурвалжилга хийх эхний үед аль болох ихийг унших, мэдэх хэрэгтэй гэдгийг ойлгох болно. Гэхдээ энэ нь үргэлж шилдэг стратеги болж чаддаггүй. Унших нь урт удаан хугацаа шаарддаг. Хэрвээ интернетээр судалгаа хийж байгаа бол тэр нь цөөн хэдэн бус, бүр хэдэн зуугаар тоологдох холбоос мэдээллийн илэрцийг гаргаж өгөх болно. Тиймээс суурь болох мэдээллийг гүйлгэж уншвал зохино. Интернет мэдээллийн хайлт нь хэтэрхий өргөн хүрээтэй агуулгатай байх ёсгүй (түлхүүр үг ашиглан эшлэл үүсгэж хайх нь илүү үр дүнтэй). Чиний сонирхлыг татсан, шаардлагатай байж магадгүй гэсэн холбоосыг сануул (bookmark). Ингэснээр тухайн холбоосыг дахин хайж, цаг үрэх шаардлагагүй болно.

Мөн хамгийн шилдэг гэсэн ганцхан мэргэжилтнийг хайж цагаа бүү үр. Аль болох утасны жагсаалтаас харж байгаад боломжит гэсэн бүхий л хүмүүстэйгээ холбоо тогтоо. Сэдвээ дэлгэрүүлж байхдаа өмнө нь уулзаж


ярилцсан эх сурвалжтай дахин холбогдож шаардлагатай мэдээллийг лавлаж асуухаас санаа зовохгүй ажиллах хэрэгтэй. Ийм тохиолдолд гүнзгийрүүлэн судлахад гол нь биш өргөн хүрээг хамарч эрэл хайгуул хийх нь чухал байдаг.

Жижиг хэмжээний цагийн хуваарь гарга, судалгааны яг аль хэсэг нь хамгийн чухал вэ гэдгээс эхэлж эрэмбэл. Тэгээд тус бүрт нь хэчнээн цаг зарцуулах боломжтойг тооцон бич. Олж уулзахад бэрх нэг хүн, эсвэл нэг баримтын хойноос хэтэрхий удаан явж, цаг үрэх ямар ч шаардлагагүй, өөр аргаар, хэрэгтэй мэдээлэл олж авах аргыг эрэлхийл.

Дүн шинжилгээ хийх, дахин боловсруулах

Та хэд хэдэн суурь судалгаа хийчихсэн, утсаар маш сонирхолтой ярианууд авчихсан. Мөн үйл явдлын гол өрнөл цэг болсон газарт очиж байдлыг ажигласан. Гэтэл, харамсалтай нь таамаглал чинь төсөөлснөөс тэс өөр байж болно. Шинэ тутам гарч ирсэн мэдээллийн мөрөөр таамаглал чинь үгүйсгэгдсэн ч гэлээ сэдвийг шинэчилж, дахин боловсруулахаас битгий айгаарай. Сайн эрэн сурвалжилгад уян хатан чанар хамгаас чухал байдаг. Анхдагч санаанаас няцахгүй, шинэ санаа, мэдээллийг хүчээр нэмээд, оруулаад байж болохгүй, шаардлагатай бол бүрмөсөн шинэчлэх хэрэгтэй.

Ингээд сууриа шинээр цутгасан бол судалгааг улам гүнзгийрүүлж, холбоо хамааралгүй мэдээллийг хасах хэрэгтэй. Мэдээж өөрийн хийсэн ажлыг үгүйсгэж, устгана гэдэг хүнд хэцүү зүйл. Гэхдээ ингэх л учиртай. Хуучин тэмдэглэлээ хадгалж, ирээдүйн сурвалжилгад ашиглаж магадгүй гэдгийг бодолц. Утга учир бүхий албан ёсны эх сурвалжийн санаа бодлыг хайж, илүү сонирхолтой мэдээлэл, холбоосын хойноос хөөж явсан замаараа буцаад үзэх хэрэгтэй. Барьцгүй таамаг төсөөллийг хөдлөшгүй, тодорхой




баримт нотолгоо болгож чадах багтай мэдээллийг хайж эхэл. Ингэж чадвал сэдвийг гүнд нь хүртэл ойлгох болно. Баталгаагүй мэдээллээс болж хууль шүүхийн хаалгыг татмааргүй байгаа биз дээ? Тиймээс нотлох, шалгах боломжгүй зүйлсийг зүгээр л мартаад үргэлжлүүл. Тэмдэглэл дээрх зөрчилтэй боловч эвлүүлж, нийлүүлж болмоор мэдээлэлд анхаарал хандуулж эрэл хайгуул хийх. Ийм мэдээлэлд таны эх сурвалжууд яаж хандахыг, юу гэхийг нь сонсоорой. Бүгдийнх нь хариулт, санал, сэтгэгдлийг бичиж аваад, зөвлөх, дарах, зурах зэргээр тэмдэглэгээ хийх байдлаар ажиллана уу.

Ажлынхаа явц, өрнөл зэргийг редактортоо байнга танилцуул. Шинэ төлөвлөгөөг чинь хүлээж авч орон зай бий болгох, эсвэл шинэ хуудсан дээр нийтлэх боломжийг олохын тулд ийнхүү тогтмол мэдээлж байх шаардлагатай. Үүнийг аль болох эрт хийх нь зөв. Мөн гүжирдлэг, гутаан доромжлохоос үүдэн ямар эрсдэл учирч болох, ямар хуулийн хариуцлагын өмнө зогсож болох талаар редактортоо эртхэн хэлчих нь зүгээр байдаг. Та бүгдийг хамгаалахын тулд сурвалжилга эцэслэгдэж дуусахаас өмнө редактор тань хуулийн зөвлөхтэй уулзсан байх ёстой юм.

Багаа Хэрхэн Бүрдүүлэх Вэ?

Хэрвээ та баг болж эрэн сурвалжилга хийхээр шийдсэн бол дараах зүйлсийг төлөвлөх шаардлагатай: Нэгдүгээрт, эрэн сурвалжлах ажлыг төсөл гэж үзвэл төслийн менежерээ олох хэрэгтэй. Энэ хүн бол туйлын чухал үүрэгтэй. Учир нь төслийн менежер багийг бүхэлд нь хариуцаж ажиллах бөгөөд гишүүдийн уялдаа холбоо болон хамтын ажлыг нэгтгэдэг. Хоёрдугаарт, багаараа сэдвээ дэлгэрэнгүй хэлэлцэж, хийх ажлын жагсаалтаа гаргахын тулд хурал зохион байгуулах хэрэгтэй.



Энэ үйл ажиллагаандаа зориулж дараах форматыг ашиглаарай:

- ? Хэрвээ чухал төлөвлөгөө нурж, биеллээ олохгүй бол хэрхэн хурдан шийдвэрлэх вэ?
- ? Багийн гишүүд хэзээ, хэрхэн харилцан уялдаатай ажиллах вэ?
- ? Менежер хэзээ, хэрхэн, ямар давтамжтайгаар гишүүдтэй уулзах вэ?
- ? Юуг эрэн сурвалжлах ажлын бүхий л үе шатуудад засах, сайжруулах, зөвлөмж болгох вэ? .
- ? Хүн бүр сэтгэл хангалуун, санал нэгтэй байх эцсийн үр дүнд хэрхэн хүрэх вэ? Ямар зардлыг буцаан төлөх шаардлагатай вэ?
- ? Багийн гишүүд шаардлагатай баримт бичгийн төлөө сэм чагнах, тагнуул хийх эсвэл мөнгө гаргах зэргийг хийж чадах уу?



Түүнчлэн багийн гишүүдийн ажил үүрэг нь маш тодорхой байх ёстой бөгөөд ингэснээр зөрчил, маргаан анхнаасаа үүсэхгүй. Мөн тэд эрэн сурвалжлах ажилд адил түвшинд оролцохын зэрэгцээ хамт олны өмнөөс ямар нэгэн шийдвэр гаргахгүй. Эрэн сурвалжлах ажлын төслийн менежер, байгууллагын дарга хоёрын харилцаа болон шийдвэрийг хэрхэн гаргах нь маш тодорхой байх ёстой. Тэд хоорондоо гэрээ байгуулан ажиллах хэрэгтэй бөгөөд багийн гишүүд, төслийн менежер, байгууллагын дарга хооронд ч мөн адил гэрээ байх ёстой.

Энэ мэт зохион байгуулалтыг хийхээс гадна бүгд сэдэвтэй танилцахыг чухалчлах нь зүйтэй. Хүн бүр үйл явц болон эрэн сурвалжилгыг тойрсон асуултуудыг ойлгож байна уу? Олон нийтийн өмнөөс асуудалд хандах сонирхол багийн гишүүдэд бий юу? Ахин дахин бодож эргэцүүлсэн сайн эрэн сурвалжлах сэтгүүл зүйн туршлага нь энэ ажилд чухал юм. Ийм л ажлаас жинхэнэ бодитой үр дүн гарна. Сайн туршлага, ёс зүй нь хэлэлцүүлгийн чухал хэсэг юм. Эхний таамаглалаа хөгжүүлэх хэрэгтэй бөгөөд хийх ажлын жагсаалтыг үндсэн мэдээлэл болон эх сурвалжаас шалтгаалан гаргах болно.

Эрэн сурвалжлах ажлын үйл явц, сэдвийг үр дүнтэйгээр үргэлжлүүлэх, зорилгодоо хүрэх зэрэг нь төслийн менежерээс хамаарна. Таамаглалыг сайжруулах, /шинэ/ эх сурвалжаа тодорхойлох, зөв хийх ажлын жагсаалт гаргах болон илүү нарийвчлах зэрэг нь баг хамт олны харилцаанаас хамааралтай юм.

Төслийн менежер эрэн сурвалжлах ажлын үр дүнд бий болох “жижиг” зохиолыг олж харсан байх ёстой. Тэрхүү “жижиг” зохиол та бүгдийн хөндөж байгаа сэдвийг олон нийтэд ерөнхийд нь ойлгуулах сэдэл болох юм. Төслийн менежер тогтмол уулзалт зохион байгуулж, аль болох багийн гишүүдтэй байнгын харилцаатай байхыг эрхэмлэх хэрэгтэй. Ингэхдээ аль болох албан харилцааг баримталж тэдний ажлын ахиц дэвшил, шинэчлэлд үнэлэлт өгч хамтын хүчийг бий болгоорой. Түүнчлэн төслийн менежер багийн бусад гишүүдийн хүчийг хэрхэн ашиглах вэ гэдэгт шийдвэр гаргана.

“SPOTLIGHT” /СПОТЛАЙТ/

“Спотлайт” нэртэй багийн эрэн сурвалжлах бүтээлийн жишээ орон нутгийн болон жижиг мэдээний редакциудын хувьд сайн туршлага болсон юм. 2002 онд “Бостон Глоб” сонины сэтгүүлчид Бостоны Католик шашины зарим сүмийн лам нар хүүхдүүдийг хүчирхийлж байсныг илрүүлсэн. Тэдний энэхүү бүтээл нь Америк даяар шуугиан тарьж, үүнээс улбаалан бусад хэвлэл мэдээллийн байгууллагууд өөрийн орон нутаг, улсад үүнтэй адил сэдвээр эрэн сурвалжилга хийсэн байна.

Ингээд тус эрэн сурвалжилгын хүрээнд “Спотлайт” хэмээх киног 2015 онд бүтээжээ.

VS.

ПАНАМЫН БАРИМТУУД

Панамын баримтууд бол олон улсын эрэн сурвалжлах багийн агуу том бүтээл бөгөөд маш их баримт дэлгэсэн сайн жишээ юм. Жилийн хугацаанд 70 орны 400 сэтгүүлч нэгдэж Панамын хуулийн фирмын мэдээллийн сүлжээнд эрэн сурвалжилга хийсэн. Ингэснээр улстөрч, тамирчид, гэмт хэрэгтнүүд гэх мэт бусад олон хүмүүсийн хууль бусаар ашиглаж байсан Панам дахь оффшор данснуудыг ил болгосон. Арван нэгэн сая гаруй бичиг баримтад дүн шинжилгээ хийсэн бөгөөд энэ ажлыг нэг хүн ганцаараа хийх боломж огтхон ч байхгүй. Өөрөөр хэлбэл энэ явдал нь том, жижиг маш олон эрэн сурвалжлах баг, хувь сэтгүүлчдийн хүчин чармайлтын оролцоотойгоор асар их баримтуудыг судалсан жишээ юм.

2016 онд энэ асуудал маш том шуугиан тарьсан бөгөөд эрэн сурвалжлах ажлын нэг том үр дүн болсон юм. Дэлхийн хэвлэл мэдээллийн байгууллагууд энэ тухай өөр өөрийн хэлээр дамжуулсан.

Тэмдэглэл:

Хэрвээ та багаар эрэн сурвалжилга хийх бол дараах зүйлсийг төлөвлөх шаардлагатай: Эрэн сурвалжлах ажлыг нэг төсөл гэж үзвэл хамгийн эхлээд төслийн менежерээ сонгох. Тэр маш чухал үүрэгтэй. Учир нь төслийн менежер багийг бүхэлд нь хариуцаж ажиллахын зэрэгцээ багийн гишүүдийн уялдаа холбоо болон хамтын ажлыг нэгтгэдэг хүч юм. Хоёрдугаарт, багаараа сэдвээ дэлгэрэнгүй хэлэлцэж, хийх ажлын жагсаалтаа гаргахын тулд хурал зохион байгуулах хэрэгтэй.



ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АРГА ТЕХНИКУУД

Эрэн сурвалжлах сэтгүүлчид судалгаа шинжилгээнийхээ явцад маш их хэмжээний мэдээлэл цуглуулдаг. Дийлэнх мэдээллийг компьютерт хадгалдаг. Хэрэв мэдээллийг электрон хэлбэрээр хадгалж байгаа бол хэрхэн хамгаалах талаар мэдлэгтэй байх ёстой. Эрэн сурвалжилгын явцад та үргэлж эх сурвалжтай үүсгэсэн харилцаагаа батлан дааж, аюулгүй байлгахад анхаарах хэрэгтэй. Энэ бүлэгт электрон мэдээллийг халдлагаас хамгаалах болон үүнтэй холбоотой олон төрлийн програм хангамж, ажлын орчныг хамгаалахад тус болох хэрэгслүүдийг танилцуулна. Ингэхдээ компьютерийн (Mac, Windows) болон ухаалаг утасны (Android, iOS) системтэй холбоотой мэдээллийг та бүхэнд хүргэнэ.

Мэдээллээ хэрхэн хамгаалах вэ?

Судалгааны ажлаа төлөвлөж, холбогдох эх сурвалжуудаа тодорхойлсны дараа та аль болох хурдан эрэн сурвалжлах ажлаа эхлүүлэхийг хүсч болох юм. Гэхдээ үүнээс урьтаж нэгэн чухал алхмыг хийгээрэй. Энэ бол мэдээллийн аюулгүй байдлыг хангах юм. Зөрчилдөөнтэй асуудлыг эрэн сурвалжлах үед магадгүй эсрэг талын хүмүүстэй таны харилцаа таагүй болж, тэд судалгааны ажлыг тагнаж чагнах, мушгин гуйвуулахыг эрмэлзэнэ.

Энэ үед та өөрөөсөө асуух хэрэгтэй: Хэн таны бүтээлийг олон нийтэд хүргэхийг хүсэхгүй вэ? Эдгээр хүмүүст танд байхгүй юу байна вэ? Таны судалгаа ямар төрлийн эх сурвалжид суурьлаж байна вэ?/Хүн эсвэл дижитал/Та мэдээллээ хамгаалахад ямар арга хэрэгсэл ашиглах хэрэгтэй вэ?

Танд мэдээлэл өгсөн эх сурвалжид мөн адил аюулгүй байдлын сэрэмжлүүлгийг өгөх хэрэгтэй юм. Мөн эх сурвалж тань мэдээллээ гадны хүчин зүйлсээс хамгаалах аргыг мэдэж буй эсэхийг нягтлаарай. Гэхдээ аюулгүй байдлыг 100 хувь хамгаална гэж байхгүйг санах хэрэгтэй. Та аюулгүй байдлыг хангахдаа эсрэг тал чинь мэдээлэлд нэвтрэхийн тулд цаг хугацаа, хөрөнгө хүч ихээр зарцуулахаар хийнэ гэсэн үг. Дараах бүлгүүдэд мэдээлэл хадгалах төхөөрөмжийг хамгаалахад туслах аюулгүйн байдлын стратегийн талаар танилцуулна. Үүнд таны ашиглаж болох аппликэйшн болон програмын жишээг оруулсан. Интернэт орчин үргэлж хувьсан өөрчлөгддөг учраас та энд санал болгосон програмыг суулгахаасаа өмнө тус бүрийн хамгийн сүүлийн хувилбар бий эсэхийг нягтлан шалгаарай. Та хэт хямд програм худалдан авах хэрэггүй.

Танд үнэтэй болон үнэгүй хамгаалалтын програмын хувилбарыг санал болгодог. Таны хэрэглээнд аль програм нь хамгийн сайн нийцэхийг шалгасны эцэст сонгоорой. Таныг “open source”бүхий програм хангамжийг хэрэглэхийг зөвлөж байна. IT-ийн мэргэжилтэнгүүд эдгээр программыг ямар кодоор бичсэн бэ гэдгийг харж болдог учраас аюулгүй байдлыг хамгаалдаг. Энэ төрлийн програмын аюулгүй байдалд зөрчил илэрч, мэдээлэл алдагдах үед маш хурдан мэдэгддэг. Харин хувийн програмын аюулгүй байдал алдагдаж байгаа эсэхийг зөвхөн зохиогч нь шалгаж болдог.

ХАЙ

УУЛЗ

АСУУ

БИЧ

Нууц Үгийн Аюулгүй Байдал

Компьютер, гар утсаа нээхэд та нууц үг хийх шаардлагатай байдаг. Та Wi-Fi төхөөрөмж болон и-мэйл хаяг руугаа нэвтрэхдээ нууц үг ашигладаг байх хэрэгтэй. Та мэдээллээ кодолж нууцалсан ч давхар нууц үгээр хамгаална. Тиймээс найдвартай нууц үг бол мэдээллийг аюулгүй хадгалах гол алхам юм. Та хэдий чинээ нууц үгээ ойр ойрхон солино төдий чинээ мэдээллээ сайн хамгаална. Та гар утас, компьютер гэх мэт хэрэгслийнхээ нэвтрэх код болон өөрийн мэйл, мессенжер хаягийнхаа нууц үгийг хамгийн багадаа гурван сард нэг удаа солих ёстой. Wi-Fi төхөөрөмжийн нууц үгийг доод тал нь жилд хоёр удаа солих хэрэгтэй. Бусад хэрэгслийнхээ нууц үгийг жилдээ нэг удаа өөрчлөөрэй.

Найдвартай нууц үг зохиох зөвлөмж:

- ▶ Экаунт /хаяг/ бүр өөр нууц үгнүүдтэй байх
- ▶ Толь бичигээс олдох үгийг ашиглахгүй байх
- ▶ Гэр бүлийнхээ гишүүд, найз нөхөд, гэрийн тэжээвэр амьтдынхаа нэр, төрсөн огноо зэргийг ашиглахгүй байх
- ▶ Аль болох урт нууц үгтэй байх, 15 тэмдэгттэй нууц үг найдвартай сайнд тооцогддог
- ▶ Нууц үгэнд санамсаргүй байдлаар жижиг, том үсгүүд, тусгай тэмдэгт, цифрүүд оруулсан байх

Ихэнх хүмүүст нууц үгийг тогтооход бэрхшээл тулгардаг. Харин энэ байдлаас зайлсхийх нэг арга бол товчлол ашиглах юм. Жишээ нь: Wlw8,m-lbtmcitt (When I was 8, my little brother threw my cat in the toilet’).

Хэрэглээний эсвэл мэргэжлийн компьютераас таны нууц үгийг задлахад хэр хугацаа шаардагдахыг туршиж болдог олон сайт байдаг. Үүний нэг бол password.kaspersky.com. Иймэрхүү сайтад жинхэнэ нууц үгээ оруулснаар аюулгүй байдал алдагдаж болох тул ижил төстэй байдлаар оруулж турших хэрэгтэй.

Хэрэв та экаунт бүрийнхээ нууц үгийг санахгүй бол [KeePass](#) эсвэл [Safe in Cloud](#) зэрэг аппликэйшнийг ашиглаж болно. Эдгээр нь таны нууц үгийг аюулгүй хадгалан, мэдээллийг нууцлах бөгөөд та зөвхөн ганц найдвартай “Мастер” нууц үгээр л хандан орох боломжтой. Мөн энд нууц үг үүсгэгч ч байдаг. Эдгээрийг та гар утасны аппликэйшин дотроос суулгах боломжтой.

Нууц үгээ хадгалж, хамгаалахын зэрэгцээ та нэг удаагийн нууц үг (ОТР) ашиглах зайлшгүй шаардлагатай. Эдгээр нууц үгүүд нь зөвхөн нэг удаад л ашиглагдах бөгөөд (2FA) стандарт нууц үгэн дээр чинь нэмэлт нууцлал

болон ашиглагддаг. Энэ аргыг банкны гүйлгээ хийхэд ашигладаг TAN үүсгэгчтэй харьцуулж болох юм. OTP нууц үгийг [Google Authenticator](#) (Android/iOS), [Authenticator Plus](#) (Android) болон [2STPAuthenticator](#) (iOS) үүсгэн тусгай тэмдэгт, мессежний аль алинаар хүлээн авч болдог. Facebook, Gmail эсвэл Twitter гэх мэт маш олон сүлжээнүүд OTP нууц үгийг аль хэдийнэ санал болгодог болсон. Өөр бусад и-мэйл сүлжээнийхэн (жишээ нь [mail-box.org](#)) 2FA стандарт нууц үгийг санал болгодог. OTP нууц үгийг ашиглаж эхэлсэн сүлжээнүүдийн байнга шинэчлэгдэж байдаг жагсаалтыг та [twofactorauth.org](#) сайтаас үзэж болно.

Идэвхгүй хадгалагдаж байгаа мэдээлэл /Data at rest/

Өргөн хэрэглэгддэг аюулгүй байдлын хангах хэрэгслүүдийн талаар гүнзгийрэхээс өмнө төхөөрөмжид мэдээлэл хадгалагддаг хэлбэрүүдийн талаар ойлголт авах нь чухал. Мэргэжилтнүүд мэдээллийн хадгалагдах хэлбэрийг “**data at rest**”, “data in use”, “data in motion” зарим тохиолдолд “Data in transit” гэж ангилдаг.

“Data at rest” гэдэг нь төхөөрөмжид хадгалагдсан бүх мэдээллийг идэвхтэй байдлаар шилжүүлэн, зөөвөрлөх боломжгүй гэсэн үг. Харин үүний оронд мэдээллийн хатуу диск, сүлжээ, архив болон мэдээллийн сангаас олж авч болно. Урт хугацаанд хадгалах мэдээллийн хувьд таны сүлжээ, фолдер, мэдээлэлд хандах боломжтой хүмүүсийг хянаж байх нь чухал юм.

Эхний алхам бол админы нууц үгийг солих. Заримдаа админ нууц үг байдаггүй эсвэл маш богино нууц үгтэй байдаг. Ингэснээр хакерууд төхөөрөмжинд хялбархан нэвтрэх боломжтой болдог. Хоёрдох алхам бол компьютертоо админы эрхээр үргэлж нэвтрэхээс зайлсхийх. Windows системүүд ялангуяа ердийн хэрэглэгчид бүх эрхийг автоматаар олгодог. Компьютертоо өөр шинэ Админ экаунт нээн, үүнийгээ зөвхөн шаардлагатай үед ашиглаж байх. Ердийн экаунтынхаа хэрэглэгчийн эрхийг аль болох цөөн байлгах. Үүний дүнд та вирусээс хамгаалагдах юм. Учир нь танд ахиж аппликэйшн суулгах эрх байхгүй юм. Түүнчлэн экаунтын эрхийг бусад буруугаар ашиглагдахаас сэргийлж, зочны экаунт буюу guest account үүсгэхгүй байхыг зөвлөж байна.



Нууцлал /Encryption/

Дараагийн алхам бол өөрийн төхөөрөмж, хадгалагдсан мэдээллийг нууцлах юм. Нууцлах гэдэг нь мессеж болон мэдээллийг зөвхөн эрх бүхий кодыг тайлах нууц үгтэй хүн л үзэхээр кодлох үйл явц юм. Тиймээс хакеруудад системийг эвдэх боломжийг олгохоос сэргийлэх найдвартай нууц үг ашигла. Энэ төрлийн нууцлал нь таны төхөөрөмжийг бага зэрэг удаашруулдаг гэдгийг анхаарна уу.

Төхөөрөмжийн хатуу дискийг хамгаалах

Байшингийн чинь урд гадны хүмүүсийг нэвтрүүлэхээс хамгаалдаг маш том хаалга байна гэж төсөөл. Энэ хаалгыг та зөвхөн дотроос нь хэд хэдэн гинжээр гинжлэн цоожилсон тохиолдолд л аюулгүй гэж үзэж болно. Энэ хаалга бол таны хатуу диск юм. Үүнийг хамгаалснаар та өөрийн компьютертаа хакеруудыг нэвтрэхэд амаргүй болгох хамгаалалтын гинж хийж байна гэсэн үг юм. Эдгээр гинж хангалттай бат бөх эсэхийг шалгахад одоогоор хамгийн найдвартайд тооцдог AES 256 нууцлалын аргачлалыг ашиглаарай.

Мөн хатуу дискийг нууцлах бусад програм хангамжууд бол **Vera-Crypt** (Windows) болон **FileVault** (Mac) эсвэл **Crypto Disk** зэрэг програм хангамжууд юм. Мөн **7-ZIP** (Linux) ашиглан бүх файлуудаа нууцлалтай нэг архивт оруулан хадгалах юм.

Утсаа шифрлэн нууцлах (Encrypt)

Гар утсыг компьютерын оронд ашигладаг болсон өнөө үед гар утас болон дээр нь байгаа баримт бичгүүдээ encrypt хийх буюу шифрлэн нууцлах нь чухал. Тухайлбал, iPhone гар утсыг анх худалдан авахад тэд аль хэдийнэ шифрээр хамгаалагдсан нууцлалтай байдгаас шууд ажиллуулах боломжгүй байдаг. Харин Андроидын хэрэглэгчид утсыг тохиргооноос нь нууц үг хийн хамгаалах хэрэгтэй байдаг.

USB дискийг хамгаалах, файлыг давхар нөөцлөх

USB диск бол өнөөгийн сэтгүүлчдийн мэдээллээ хадгалдаг өөр нэгэн хэрэгсэл учир гар утас, компьютерийн адил мөн хамгаалах шаардлагатай байдаг. Түүнчлэн USB дискийг үндсэн төхөөрөмжүүд дэх файлуудаа хадгалахад ашиглах боломжтой. Баримт материалд асуудал үүсэхээс сэргийлэн олон хувь хуулбарласан байхыг зөвлөдөг. Эдгээр хувиа та өөр төхөөрөмжүүдэд давхар шифрээр нууцлан хадгалсан байх ёстой.

Ашиглагдаж байгаа мэдээ мэдээлэл (Data in use)

“**Data in use**” нэр томъёо нь таны төхөөрөмжид байгаа идэвхитэй ашиглагдан, баримт бичиг болон төлбөрийн баримт хэлбэрээр тогтмол өөрчлөгдөж байдаг баримт мэдээлэл, өгөгдлүүдийг хэлдэг. Энэхүү мэдээлэл нь ихэвчлэн төхөөрөмжийн шуурхай санах ой буюу RAM эсвэл Cache-д хадгалагдаж байдаг. Энэ бүлгээр бид энэ төрлийн баримт мэдээллийг хамгаалдаг програм хангамжуудын талаар мэдээлэл өгнө.



Firewall, антивирус болон HIP програм хангамж

Та төхөөрөмжнийхөө firewall-ыг идэвхижүүлсэн байх нь маш чухал юм. Эдгээр програм нь таны төхөөрөмжийг интернэттэй холбогдоход ашигладаг өгөгдлүүдийг хянадаг. Энэ програм хангамжууд нь яг л баарны үүдэн дэх хамгаалалтын ажилтан шиг ажилладаг. “Firewall” бүр нь интернэтээр дамжин ирсэн гадны зочин нэг бүрийг төхөөрөмж рүү нэвтрүүлэх, таны сүлжээ рүү дэлгэрэнгүй мэдээлэл илгээх эсэхээ шийдвэрлэж байдаг. Цоожгүй үүд хаалга бүр хорон шинжтэй гадны програм хангамж, вирусг төхөөрөмж рүү нэвтрүүлэн, хялбархан хохирол учруулдаг. Ихэнх компьютерүүд хувьд та системд firewall-ийг өөрөө идэвхижүүлэх боломжтой байдаг бөгөөд “firewall”-оос гадна өөр бусад гадны **McAfee**, **BitDefender** болон **Kaspersky** гэх мэт хамгаалалтын програм хангамжуудыг давхар суулгах хэрэгтэй байдаг.

Та гар утсан дээрээ firewall-ыг нь идэвхижүүлэн, **NoRoot Firewall** эсвэл **Net-Guard** (Android), **Norton** (iOS) гэх мэт антивирусы програм хангамжуудыг давхар суулган ажлуулах боломжтой.

Интернет эх сурвалжуудтай мэдээлэл солилцон харилцсаны дараа таны төхөөрөмжийн мэдээллийн аюулгүй байдалд халдан нэвтэрч, үйл ажиллагааг тань хянаж, нууц үгнүүдийг хүртэл хулгайлах боломжтой. Тиймээс зөвшөөрөлгүй суусан байж болзошгүй хорон шинжтэй програм хангамж, вирусээс хамгаалах ёстой юм. Антивирусын програм хангамжууд нь эдгээр вирус, бусад програм хангамжуудыг системд хайж, тэднийг систем дэх мэдээлэл рүү нэвтрэх замыг нь хааж устгадаг. Эдгээр антивирусы програм хангамж нь зөвхөн таны компьютерийг хамгаалаад зогсохгүй, гар утсыг тань ч хамгаалж байдаг. Компьютерт ашиглаж болох бидний зөвлөж байгаа бүтээгдэхүүн нь **ESET**, **Kaspersky**, **Bitdefender** (Windows, Linux), **Microworld**, **Bitdefender**, **AVG** (Mac) юм. Харин ухаалаг утсанд хэрэглэж болох програмууд нь **Avast Mobile Security** (Android) болон **Norton**, **Lookout** (Mac) юм.

Ихэнх хүмүүс дээр дурдсан эхний хоёр аппликэйшныг өмнө нь сонсож наад зах нь нэг удаа антивирусны программыг суулгаж үзсэн байдаг. Гэсэн ч ашиглагдаж байгаа мэдээллээ бүрэн хамгаалахад (HIP) буюу таны төхөөрөмж, сүлжээний үндсэн системийг хянан, хамгаалж байдаг нэмэлт програм хангамжуудыг суулгах хэрэгтэй юм. Энэхүү нэмэлт урьдчилан сэргийлэх програм хангамж нь систем, сүлжээг хянан, бүх боловсруулалт, юу таны төхөөрөмж, сүлжээний үндсэн системийг хянан, хамгаалж байсан аливаа мэдээллийн аюулгүй байдлын зөрчлийг мэдээлж байдаг.

Malware буюу вирусыг илрүүлэхэд HIP програм нь таны одоогийн хэрэглэгчийн загвар жишээг програм хангамжийг ашигладаг байнгын хэв маягтай чинь харьцуулж байдаг. Энэ төрлийн аюулгүй байдлын үйлчилгээг үзүүлдэг програм хангамж бол **McAfee** юм.

Өнгөцхөн харахад, энэ бүх аюулгүй байдлын програм хангамжийг суулгах нь сүрдэм, төвөгтэй ажиллагаатай мэт санагдах боловч энэ гурван хэрэгслийг бүгдийг нь нэг програм хангамжинд багтаасан нь ч байдаг. Эсвэл нэг нэгнийхээ үйл ажиллагааг дэмждэг гурван өөр програм хангамжуудыг суулгасан ч болдог. Жишээ нь үйлдлийн систем бүрт эдгээр хэрэгслүүдийг бүгдийг нь багтаасан програм хангамж нь **McAfee**, **BitDefender** болон **Kaspersky** юм. Жил бүр мэдээллийн аюулгүй байдлыг хангах салбарт ажилладаг програм хангамж боловсруулагч, нийлүүлэгч компаниудыг хооронд нь сорьж, байр эзлүүлэн жагсаадаг маш олон тооны байгууллага, сэтгүүлүүд байдаг. Тиймээс аливаа програм хангамж худалдан авахаасаа өмнө одоогоор ямар компани, ямар антивирусны програм хамгийн сайн үйлчилгээ үзүүлж байгааг судлан мэдэх боломжтой юм.

Интернет орчинд нэрээ нууцлах

Хүмүүсийн тэр бүр хайхардаггүй мэдээллийн аюулгүй байдлын нэг том эрсдэл бол Wi-Fi төхөөрөмж юм. Хакерууд таны Wi-Fi төхөөрөмж рүү нэвтэрснээр, сүлжээнд чинь бүрэн нэвтрэх боломжтой байдаг. Тиймээс та анхныхаа Wi-Fi нууц үгийг өөрчлөн, аль болох найдвартай нууц үгээр сольж байх ёстой. Үүний дараа Wi-Fi төхөөрөмжөө encrypted хийх буюу шифрлэн нууцлах ёстой. Одоо байгаа хамгийн аюулгүй шифрийн арга бол WPA2 бөгөөд та мэдээллээ кодлохоос өмнө энэ функцийг ашиглаж чаддаг болсон байх ёстой. Хэрэв та Wi-Fi төхөөрөмжийг хэрхэн шифрлэхээ сайн мэдэхгүй байгаа бол интернет үйлчилгээний компаниасаа туслалцаа аваарай. Харин интернетэд холбогдох хамгийн аюулгүй арга бол LAN-аар холбогдох юм. Хэрэв гэрээсээ ажиллах бол зөвхөн LAN кабель ашиглан интернет орчинд ажиллаарай.

Ингээд та өөрийн роутер буюу Wi-Fi төхөөрөмжийн аюулгүй байдлыг хангасан бол одоо интернетэд хайлт хийх талаараа бодох ёстой болжээ. Та судалгаа шинжилгээ хийх үедээ интернетийг суурь мэдээлэл, боломжит мэдээллийн эх сурвалж олохоор ашигладаг. Интернетэд эмзэг сэдвээр эрэл хайгуул хийх нь таны үйл ажиллагааг хянах тагнуулуудад илүү их өртөмхий болгодог. Тиймээс, та өөрийн судалгаа шинжилгээний ажлаа хамгаалахын тулд хайлтын системээ нууцлан хамгаалах нь маш чухал. Ингэснээр та өөрийгөө болон ирээдүйн эх сурвалжаа хамгаалах боломжтой болно.

Аливаа хөндлөнгийн хяналтыг даван мэдээлэл хайн интернетэд аюулгүй аялах хоёр арга байдаг: Таны байршлыг харагдуулахгүй нууж байдаг VPN (Хувийн виртуал сүлжээ) болон прокси сүлжээний аль алиныг нь ашиглаж болно. VPN нь таныг яг л өөр сүлжээнд байгаа мэт болгох гарц гэж ойлгож болно. VPN-ийг ашиглах энгийн аргачлал бол програм хангамж суулгах бөгөөд ихэнхдээ та ухаалаг гар утас, компьютер эсвэл хайлтын систем болох програм хангамжийнхаа алинд нь сонгон ашиглах вэ гэдгээ шийдэж болдог. VPN-ийг идэвхжүүлсэн бол та өөрөө байгаа мэт харагдах хуурамч байршлыг сонгож болдог. VPN-ийн ийм үйлчилгээ үзүүлдэг зарим газруудаас дурдвал [ZenMate](#), [CyberGhost](#) болон [ExpressVPN](#) зэргийг нэрлэж болох юм. Гэвч ихэнх VPN нийлүүлэгчид нь үнэ төлбөртэйгөөр үйлчилгээ үзүүлдэг гэдгийг анхаараарай. Төлбөрийн мэдээллүүд хадгалагдан үлдэх бөгөөд хэдий энэхүү онлайн хайлтын аргыг ашигласан ч таны төлбөр төлсөн ул мөр үлдэх болно. Харин хэдий жаахан төвөгтэй боловч үүнээс өөр нэгэн арга бол өөрийн VPN-дээ тохиргоо хийх юм.

Өөр нэгэн алдартай проху сүлжээ нь TOR (The Onion Router) юм. TOR браузерыг ашиглаж байхад та өөр IP хаягтай харагддаг. Үүнийг нь ашиглах боломжтой. Учир нь TOR бол шифрлэгдсэн компьютерүүдийн сүлжээ юм. Хэрэглэгч бүр энэ сүлжээнд нэвтрэх эрхтэй байдаг. Эдгээр сүлжээнүүдээс гурав болон түүнээс дээш тоогоор ашигласны дараа хэрэглэгч гарах хэсэгт хүрдэг. Энэ нь тухайн хэрэглэгчийн албан ёсоор ашиглаж байгаа IP хаяг юм.

Гэсэн хэдий ч энэ нь та огт ул мөр үлдээхгүй гэсэн үг биш. Жишээлбэл 2014 оны 11-р сард холбооны мөрдөх товчоо болон Европын аюулгүйн албад TOR-ийг гэмт хэргийн үйл ажиллагаандаа ашигласан 17 хүнийг илрүүлэн баривчилсан. Гэвч ийм үйл ажиллагааг хийхэд маш их ажиллагаа, хөрөнгө мөнгө шаарддаг. Тиймээс хэрэв тэд зэвсгийн наймаа хийж, насанд хүрээгүй хүүхдийн порно бичлэг түгээгээгүй л бол нууц албадууд энэхүү аргачлалаа хэрэгжүүлэн та бүхнийг мөрдөн илрүүлэх эрсдэл бага. Гэвч та сайн тоноглогдсон нууц албатай, хэвлэлийн эрх чөлөө багатай улс оронд үйл ажиллагаа явуулж байгаа бол энэ талаар анхаарах хэрэгтэй юм. TOR браузер

нь андройд төхөөрөмжид ухаалаг утасны аппликэйшн хэлбэрээр (**Orfox** болон **Orbot** add-on-oor) ашиглагдах боломжтой. Proxu браузер хайж байгаа iOS үйлдлийн системийн хэрэглэгчид **Onion Browser** луу нэвтрэх хэрэгтэй.

Clouds үүлэн технологи ашиглан хадгалах

Dropbox, **Google Drive**, **OneDrive** гэх мэт нийтэд зориулсан үүлэн технологийг үнэгүй, хялбархан ашиглах боломжтой байдаг ч эдгээр clouds-д нууц файл, зураг бусад баримтаа хадгалахаас зайлсхийх шаардлагатай. Та Cloud-д хадгалсан файлуудад юу тохиолдохыг хянах аргагүйгээс гадна cloud-ийн үйлчилгээ үзүүлж таны мэдээллийг хадгалан хамгаалж байгаа компаниас хараат байна гэсэн үг.

Cloud-д тулгуурласан автомат шифрлэлттэй өөр нэгэн хамгаалалтын хувилбар бол **BlauCloud** юм. Энэ сүлжээ нь open-source cloud-ийн шийдэл буюу **ownCloud** юм. Мэдээлэл ХБНГУ-д хадгалагддаг учир хэрэглэгчид нь ХБНГУ-ын мэдээллийн аюулгүй байдлын чанга хатуу хуулиар хамгаалагдаж чаддаг. Хэдий энэ нь илүү аюулгүй арга байдаг ч та мөн л тухайн үндсэн системд өөрийн мэдээллээ итгэн даатгаж байгаа хэрэг. Мэдээллийг өөр газарт илүү найдвартай хамгаалахад NAS (Network attached Storage)-ийг ашиглан өөрийн хувийн cloud-ыг үүсгэх юм. Гэвч NAS нь нэлээд үнэтэй байдаг.

Биет байдлаар хадгалах

Маш нууц баримт бичгийг хадгалахад та тэр бүр олон хувилаад байх хэрэггүй л болов уу. Энэ тохиолдолд, файлаа бүгдийг нь сканнердаад хатуу дискэндээ эсвэл USB дискэндээ хадгалах хэрэгтэй. Түүнчлэн файлуудаа давхар шифрлэн хамгаалах хэрэгтэй гэдгээ мартуузай. Үүний дараа хэрэв таныг хэн нэгэн мөрдөн тагнаж байгаа бол энэ дискүүдээ нуух аюулгүй газрыг олох хэрэгтэй. Аливаа зүйлийг нуух хамгийн сайн газар бол сейф эсвэл цоожтой шүүгээ сав байдаггүй гэдгийг санаарай. Түүнчлэн та үзэг, ээмэг, бугуйвч болон бусад зүйлд нуух хэмжээтэй жижиг USB диск ашиглаж ч болох юм. Та нууц мэдээллээ хадгалах хамгаалах газрыг сонгохдоо аль болох шинэлэг, хүний санаанд оромгүй газар нуух хэрэгтэй. Гэхдээ нуусан газраа өөрөө мартчихалгүй олдог байх ёстойг анхаараарай.



Камер, микрофоныг идэвхигүйжүүлэх

Тодорхой програм хангамжийг ашиглахад гуравдагч этгээд таныг өөрийн чинь төхөөрөмж дэх камерыг ашиглан хянаж, микрофоноор нь чагнах боломжтой байдаг. Камерыг энэ байдлаар ашиглуулахгүй байх хамгийн хялбар арга бол камерынхаа нүдийг халхлан цаас наах юм. Энэ арга нь хакер таны үйл ажиллагааг камер ашиглан харахаас найдвартай хамгаалах бөгөөд өөрөө камер ашиглах үедээ л цаасаа авч байх нь илүү хялбар. Өөр нэгэн ойролцоо хувилбар бол төхөөрөмж дэх камераа идэвхгүй болгох. Гэвч та камер болон микрофоноо ашиглах тоолондоо тэдгээрийг дахин идэвхжүүлдэг гэдгийг санаж байх ёстой бөгөөд таны гар утасны камер, микрофоныг ч гэсэн яг үүнтэй ижил ашиглан тагнаж чагнах боломжтой.



Мэдээллийг аюулгүй байдлаар устгах

Хэрэв таныг мөрдөн тагнаж байгаагаас та компьютер дэх бүх мэдээллээ устгах шаардлага тулгарсан бол дараах зааварчилгааг дагаарай: Компьютерийн delete товчлуураар устгаж болохгүй; Ингэснээр таны тухайн файл руу хүрэх зам л харагдахгүй болдог болохоос үндсэн файл чинь төхөөрөмжийн чинь хатуу дискэнд хэвээрээ хадгалагдаж байдаг учир гуравдагч этгээд хялбархан сэргээн авах боломжтой.

Энэ арга зүй нь дижитал зургийн аппаратнуудын адилаар зөөврийн дискнүүдийн хувьд ч мөн адил. Бүхий л замаар өөрийн мэдээллээ бүрэн устгах аргыг эрэлхийл. Жишээлбэл та [Eraser](#), [Secure Eraser](#) (Windows-д хоёуланд нь) болон [Super Eraser](#) (Mac)-г ашиглаж болох юм. Эдгээр програмууд нь өөр өөр матриц ашиглан таны файлыг маш олон тооны тоон өгөгдлөөр давхарлан бичэснээр эх файлыг сэргээх аргагүй болгодог.

Үүнээс гадна, та төхөөрөмж дээрх аливаа програм хангамжуудыг тогтмол устган, дахин шинээр суулгаж байхыг (жилд хоёроос доошгүй удаа) зөвлөж байна. Мөн файлуудаа устгах зорилгоор дискүүдэд формат хийхдээ хатуу дискээ тэр чигт нь форматлахаас урьдчилан сэргийлж анхаарал болгоомжтой байх хэрэгтэй. Тиймээс та дээр санал болгосон програм хангамжуудыг ашиглан энэ үйл ажиллагааг аюулгүй гүйцэтгэх боломжтой.

Мэдээлэл дамжуулах үеийн аюулгүй байдлыг хангах (data in motion)

Энэ хэсэг эрэн сурвалжлах сэтгүүлчдийн харилцаа холбооны аюулгүй байдлыг хангахад маш чухал. Энд бид **‘data in motion’** буюу и-мэйл, мессеж бичих үед ашиглагддаг нэг сүлжээнээс нөгөө сүлжээ рүү дамжиж байгаа мэдээллийн аюулгүй байдлыг хэрхэн хамгаалах талаар тайлбарлах болно. Дараах програм хангамж нь мэдээллийг гуравдагч этгээд замаас нь барих, хүлээн авагчид очихоос өмнө мэдээлэлд өөрчлөлт хийхээс хамгаалдаг.



Аюулгүй байдлаар и-мэйл ашиглах

Gmail, Yahoo, Hotmail зэрэг түгээмэл ашиглагддаг и-мэйл буюу электрон шуудангийн үйлчилгээ үзүүлэгчид нь эрэн сурвалжлах сэтгүүлчдийн хувьд маш аюултай. Учир нь, ихэнх электрон шуудангийн аппликэйшнүүдийн аюулгүй байдал, хувь хүний нууцыг хамгаалах стандарт маш сул байдаг. ‘Gmail’ мэтийн хэрэгслүүд нь хакеруудын анхаарлыг их татдаг учир нь Google дээрх сайтууд нь маш түгээмэл байдаг шүү дээ. Ийм учраас та мэдээлэл дамжуулах хэрэгсэл болон мэдээллийн агуулгаа хамгаалах шаардлагатай байдаг. Үүнийг та хоёр шатлалаар гүйцэтгэх боломжтой. Та аливаа электрон шуудангийн үйлчилгээг ашиглахаасаа өмнө дараах нөхцөлүүдийг судлаарай:

- 1) Өгөгдөлийн оролт, гаралтын хамгаалалт буюу (SSL) болон
- 2) Мэдээлэл дамжуулалтын хамгаалалт (TLS)

Энэ хоёр төрлийн аюулгүй байдлын үйлчилгээг үзүүлдэггүй электрон шуудангийн үйлчилгээг авах хэрэггүй. SSL болон TLS нь нэг серверээс нөгөө сервер лүү онлайн дамжих таны и-мэйлийг шифрлэн кодлох замаар аюулгүй байдлыг нь хангадаг. Гэсэн хэдий ч таны тэрхүү и-мэйл шифрийн хамгаалалтгүй, цэвэр текст хэлбэрээрээ хоёр серверт хоёуланд нь хадгалагдан үлддэг. Энэ нь тухайн серверийн админууд таны и-мэйлийг үзэж, өөрчилж чадна гэсэн үг.

И-мэйлийн агуулгыг нууцлан хамгаалахад, **Pretty Good Privacy (PGP)** нь аюулгүйн сайн шийдлийг санал болгодог. Хэрэв та PGP ашиглан и-мэйлээ хамгаалсан бол хүлээн авагчаас өөр хүн үзэх боломжгүй. Харин сул тал нь ингэж и-мэйл явуулах нь амаргүй байдаг учраас тэр болгон их ашиглагддаггүй.

PGP нь нийтийн, хувийн гэсэн хоёр төрлийн түлхүүр үүсгэдэг криптографик систем юм. Энгийнээр тайлбарлавал нийтийн түлхүүрийг тухайн и-мэйлийг



шифрлэн хамгаалахад, харин хувийн түлхүүр нь хамгаалалтыг тайлахад ашиглагддаг. Тэгэхлээр нийтийн түлхүүрийг хүн бүр эзэмшиж болдог ч хувийн түлхүүрийг зөвхөн тухайн хэрэглэгч л ашигладаг. Хэрэв та PGP хамгаалалттай и-мэйлийг өөр хэн нэгэнд илгээх болвол танд и-мэйлээ нууцлахад илгээгчийн тань нийтийн түлхүүр нь хэрэгтэй. Та энэхүү нийтийн түлхүүрийг нь илгээгчээсээ болон public key server-ийн аль алинаас нь авах боломжтой.

И-мэйл хүлээн авагч нь таны и-мэйлийг өөрийн хувийн түлхүүрийг ашиглан, холбогдох нууц үгээр нь тайлан уншина. Харин PGP-г ашиглахын тулд таны мэдээлэл хүлээн авагч мөн энэ үйлчилгээг ашигладаг байх ёстой.

Бидний зөвлөж болох и-мэйл үйлчилгээнүүд бол **Thunderbird** болон хүн бүхний мэддэг **Microsoft Outlook** бөгөөд PGPadd-ons үйлчилгээг үзүүлдэг. Хэрэв та Gmail гэх мэт өөр и-мэйл үйлчилгээнүүдэд PGP-г ашиглахыг хүсвэл **Mailvelope**-ийг ашиглаарай. Гэвч эдгээр нийтлэг хэрэглэгддэг и-мэйл үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын хувьд, PGP илгээгч, хүлээн авагч болон и-мэйлийн нэрийг нууцалж чаддаггүйг анхаарах хэрэгтэй.

Дунд нь ямар нэгэн зуучлалын шат дамжлага ордоггүй илгээх серверээс хүлээн авах сервер хүртэл нууцлалтайгаар мэдээлэл дамжуулдаг өөр нэгэн и-мэйл үйлчилгээ бол **ProtonMail** юм. Энэхүү үйлчилгээ ZKS-ээр зохиогдсон бөгөөд мэдээллийг ProtonMail серверт илгээхээс өмнө хэрэглэгчийн компьютерийг сүлжээтэй холбодог програм хангамжийг ашиглан и-мэйл болон хэрэглэгчийн мэдээллийг шифрлэн нууцална. Энэ и-мэйлийн үйлчилгээ үзүүлэгчийн серверүүд нь Швейцар улсад оршдог бөгөөд нууцлал нь SSL-д тулгуурлаж, харин PGP болон код нь open source байдалтай байдаг. **Thunderbird** болон үүнтэй ойролцоо хэрэгсэл болох **Evolution**-ы хоорондын ялгаа нь **ProtonMail** нь Evolution-ы зөвхөн клиентээр зогсохгүй, и-мэйл үйлчилгээ үзүүлэгч компани нь юм.



Текст мессежний аюулгүй байдлыг хангах

Хамгийн сүүлийн үеийн харилцаа холбооны чиг хандлага нь **WhatsApp**, **Telegram**, **Facebook Messenger** болон **Snapchat** гэх мэт и-мэйл, мессенжер хамтдаа нэг дор байдаг хэрэгслүүдийг бий болгохоос аль болох зайлсхийж байна. Хэдхэн секундийн дотор та мэдээлэл, баримт бичгээ дэлхий даяар түгээх боломжтой. **WhatsApp** гэх мэт компаниуд нь өөрсдийн end to end-encryption нууцлалыг сурталчилдаг ч аль нь ч бүрэн хамгаалалттай байж чаддаггүй. Ерөнхийдөө нууц мэдээллийг мессенжерээр дамжуулах нь аюултай. Дээр дурдсанаас илүү нууцлалтай үйлчилгээ үзүүлдэг **Signal**, **Telegram** эсвэл **Wire** гэх мэт текст мессежний үйлчилгээтэй програм хангамжууд байдаг бөгөөд iOS, Android-уудад хоёуланд нь ажилладаг.

Эдгээр аппликэйшнуудийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг whispersystems.org-ээс авч болно.



Нийтийн хэрэглээний төхөөрөмжид аюулгүй байдлаа хангах

Олон нийтийн ашигладаг харилцаа холбооны төхөөрөмж ашиглахаас аль болох зайлсхийх хэрэгтэй. Та өөрийн хувийн төхөөрөмжид аюулгүй байдлаа хангах нь илүү хялбар байна. Нийтийн төхөөрөмжийг өмнө нь хэн ашиглаж, мөн ямар вирус, програм хангамж суусан эсэхийг мэдэхгүй шүү дээ. Хэрэв та нийтийн компьютер ашиглах болсон бол файлыг компьютерт хуулахгүйгээр өөрийн гэсэн USB төхөөрөмж дээрээ ажиллах хэрэгтэй.

Хэрэв та ингэж ажилласан бол мэдээлэл чинь нийтийн компьютерийн шуурхай санах ой буюу богино хугацааны санах ойд хадгалагдах бөгөөд зөвхөн USB төхөөрөмж компьютерт залгаатай үед л ашиглагддаг.

Компьютерийг унтраасны дараа уг компьютерт тухайн файлаас чинь аливаа үйл ажиллагаа, өгөгдөл хадгалагдан үлддэггүй. Түүнчлэн, өөр үйлдлийн систем ашиглах үед та USB дискийг ашиглаж болдог. Жишээ нь та boot хийсэн USB дискээр Linux үйлдлийн систем ашиглаж болно. Windows үйлдлийн системтэй компьютерт USB дискээ boot хийсний дараа та флэш буюу usb дискэн дээрх Linux систем дээрээ ажиллах боломжтой болно.

Гэвч энэ үед компьютер дээр чинь юу ч хадгалагдан үлдэхгүй гэдгийг санаарай. USB дискийг boot хийх нь өөрөө ажиллагаа шаарддаг. Тиймээс та хэрэв энэ аргачлалыг ашиглахыг хүссэн бол вебсайтаас хэрхэн хийх талаар хичээлүүдийг үзэх хэрэгтэй.

Та олон нийтийн үнэгүй Wi-Fi сүлжээнд орохоос зайлсхийх ёстой. Учир нь та уг сүлжээнд хэн байгаа, мөн таны мэдээлэлд ямар аюул учирч болохыг мэдэхгүй шүү дээ. Үнэ төлбөргүй Wi-Fi сүлжээнд холбогдох гэж байгаа бол үргэлж VPNs ашиглах хэрэгтэй. Энэ нь танд бага ч гэсэн нууцлалын боломж олгох болно.

Аюулгүй сонголт: LINUX

Linux үйлдлийн систем бол гар утас, компьютертаа ашиглаж болох өөр нэгэн үйлдлийн систем юм. Ихэнх компьютерийн мэргэжилтнүүд энэ системийг ашигладаг. Мөн мэдээллийн технологийн мэргэжилтнүүд энэ үйлдлийн системийг хамгийн аюулгүй үйлдлийн системд тооцдог. Сүүлийн үеийн Linux системийн хувилбаруудыг бусад системийн адил ашиглахад хялбар болсон. Эдгээрээс нэрлэвэл **Ubuntu**, **openSUSE**, **Debian**, **Mint** болон **Elementary OS** нар юм.

Linux системийн хамгийн том давуу тал бол үнэгүй, open source дээр бичигдсэн, ямар ч төхөөрөмжид сууж болдог юм. Хэн ч source code-ийн алдаа, security bug гэх мэт аюулгүйн хамгаалалтыг сайжруулах боломжтой учир бусад үйлдлийн системүүдийг бодвол илүү ил тодорхой байж, алдаа согогууд нь хурдан засагддаг. Linux систем Windows эсвэл Apple шиг өргөн тархаагүй учраас Linux-ийн платформд харьцангуй цөөхөн вирус байдаг. Linux-ээс жил бүр хамгийн шилдэг Linux системийн хувилбаруудын жагсаалтыг танилцуулдаг.

Програм хангамжуудын талаар мэдээлэл авах линкүүд:

Хамгийн сайн хамгаалалттай, USB дискэнд ашиглаж болох:

@ tails.boum.org

Зөөврийн компьютерт тохиромжтой, хамгийн өргөн хэрэглэгддэг:

@ ubuntu.com

Өнгө үзэмж сайтай:

@ elementary.io

Хэрэглэхэд хялбар:

@ opensuse.org

@ linuxmint.com

Серверүүдэд тохиромжтой:

@ debian.org



Утсаар хэрхэн аюулгүй дуудлага хийх вэ?

Нууц мэдээллийн талаар эх сурвалжтайгаа аль болох биечлэн ярилцахыг хичээгээрэй. Утасны яриаг гуравдагч этгээд хялбархан чагнах боломжтой тул нууц мэдээллийг ямар ч үед утсаар ярихгүй байх хэрэгтэй. [Skype](#) гэх мэт өргөн хэрэглэгддэг сүлжээнүүдэд end to end encryption байдаггүй. Түүнчлэн, [WhatsApp](#), [Wire](#) болон [Signal](#) нь хоёр төхөөрөмжийн хоорондох дуудлагуудыг нууцалсан байдаг ч 100 хувийн баталгаа өгч чадахгүй юм.

Эх сурвалжтайгаа уулзах газраа товлосон бол утсаа гэртээ орхих, эсвэл унтрааж, батарейг нь салган авсан байх хэрэгтэй. Түүнээс гадна, та Faraday Cage утасны гэр ашиглаж болно. Энэ нь цахилгаан соронзон дохиог хаадаг. Edward Snowden-ий аргачлалд харилцан ярианыхаа нууцлалыг хадгалахын тулд утсаа хөргөгчид хийх юм.

Түүнчлэн, утсан дээр аппликэйшнүүдийн тоог хязгаарлах хэрэгтэй. Аппликэйшн суулгах бүр аппликейшнд таны утасны тодорхой функц, өгөгдлийн сан зэрэгт нэвтрэх зөвшөөрөл асуудаг. Тиймээс тэдгээр аппликэйшнүүдэд өгөх зөвшөөрлийг аль болох хязгаарлах хэрэгтэй. Android болон iOS үйлдлийн системтэй гар утасны Privacy тохиргоонд уг зөвшөөрлийг идэвхгүйжүүлэх функц байдаг. Гэвч аппликэйшнүүдэд хандалтын зөвшөөрлийг өгөлгүйгээр ажиллуулж болдоггүйг санаарай.

Анхаар:

Энэхүү гарын авлагын дагалдах вебсайт нь **investigative-manual.org**
Та эндээс мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой
тайлбар видео, дэлгэрэнгүй мэдээллийг авах
линкүүдийг үзэж болно.



ТЭМДЭГЛЭЛ:

Ерөнхийдөө, энэхүү бүлгийн зорилго нь аюулгүй ажлын байрны орчны ач холбогдлыг таниулах бөгөөд эрэн сурвалжлах ажилд аюулгүй байдлыг 100 хувь хангах боломжгүй гэдгийг санах хэрэгтэй юм. Энд өгсөн мэдээллээр бид танд эх сурвалжтайгаа хэрхэн аюулгүй байдлаар харьцах, мэдээлэгчтэй уулзахаас өмнө ямар арга хэмжээ авахыг дурдсан. Та одоо эрэн сурвалжлах сэтгүүлзүйн дараагийн алхмуудыг хийхэд бэлэн болсон бөгөөд эдгээрийг доорх бүлгүүдэд тайлбарласан болно:

Эрэн сурвалжлах ажлынхаа хамрах хүрээг хэрхэн тодорхойлох вэ?
Эх сурвалжтай уулзахдаа хэрхэн оновчтой асуултууд асуух вэ?
Хэрэгтэй мэдээллээ олж авахад ярилцлага хийх ямар аргачлал ашиглах вэ?



ТАВДУГААР БҮЛЭГ

СУДАЛГАА, СУДАЛГАА, СУДАЛГАА

Энэ бүлэгт эрэн сурвалжлах сэтгүүлчийн судалгаа хийх гол ур чадварын талаар ярилцана. Сэтгүүлчид мэдээлэл боловсруулах, зураглах, баримтын мөрөөр яаж явахаа мэддэг байх, компьютерын тусламжтайгаар сурвалжлах зэрэг аргачлалыг сайтар эзэмших хэрэгтэй. Зарим түүхийг бичихэд тоон мэдээллийг задлан шинжлэх шаардлага тулгардаг учир тоог ойлгох чадварт суралцах нь чухал.

ТОДОРХОЙЛ	ЭРЖ ОЛ	ТӨЛӨВЛӨ	ХАМГААЛ
-----------	--------	---------	---------

Хэрхэн мэдээлэл авах вэ?

Гадаад улсад төрийн эсвэл хувийн хэвшлийн мэдээллийг олон нийтээс нууцалж, Нууцын тухай хууль, Терроризмын эсрэг хуулиар далайлгах эсвэл төрийн албан хаагчид зүгээр л нээлттэй болгохыг хүсдэггүй. Европт төрөөс бизнесийн салбарт өгдөг татаасыг мэдээллийн эрх чөлөөний үүднээс хүлээн зөвшөөрөхийн тулд долоон жил (2000-2007 он) зарцуулсан юм. Бизнесийн салбарт өгдөг төрийн татаасыг юунд зарцуулдгийг Европын ард түмэнд ойлгуулахын тулд зургаан улсын сэтгүүлчид хамтран ажиллаж, тухайн мэдээллийг түгээхийн тулд шүүхэд гомдол гаргасан. Үр дүн нь төсөөлснөөс илүү байсан. Төрөөс татаас авсан нэрсийн жагсаалтыг томоохон аж үйлдвэрийн эзэд, хааны гэр бүлийн гишүүд тэргүүлсэн ажээ. Жижиг эсвэл эрсдэлд байгаа компаниуд биш тэдний өндөр ашиг орлоготой компаниуд татвар төлөгчдөөс бүрдүүлсэн хэдэн сая фунт стерлинг, евро авсан байлаа.

Нээлттэй бүртгэлийн тухай хууль тогтоомж бараг бүх улсад байдаг ч үр дүнтэй хэрэгжүүлэхэд асуудал тулгарсаар байна. Сэтгүүлчид хэрэгцээтэй мэдээллээ авахын тулд цаг ямагт шаргуу хөдөлмөрлөх хэрэгтэй. Нэг хууль бол хаалга онгойлгоход л тусална, гэтэл сэтгүүлч хаалга хүрэх замаа олж, онгойтол тогших болдог. Үүний тулд холбогдох хууль тогтоомжийг сайтар ойлгох шаардлагатай.

Хэрэв та мэдээллийн тухай хууль байхгүй улсад амьдардаг бол Нууцын тухай хуулиар бүхнийг хориглодог нөхцөлтэй тулгарч магад. Иймээс төрийн алба эсвэл хувийн хэвшлээс мэдээлэл авахдаа бэрхшээлтэй таарна. Цаашилбал, төрийн албан хаагчдад мөнгө төлж хэрэгцээтэй баримтаа авахаас өөр замгүй байж мэднэ. Та мэдээлэл авахын тулд мөнгө төлөх болвол үүнээс хэрхэн зайлсхийх вэ? Мэдээлэл авахын тулд хууль тогтоомж, туршлагатай хашир нэгэнтэй нүүр тулах хүнд хэцүү урт зам таныг хүлээж байна.

Хэрэв танай улсад Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль тогтоомж үйлчилдэг бол мэдээлэл авахын тулд дараах зарчмыг удирдлага болговол зохино:

- Тухайн сэдвээр алба хаагч эсвэл мэргэжилтний зүгээс ямар зүйл нийтэлсэн байгааг олох, холбогдох баримтаа үзүүлэх туршуултай болох
- Тухайн мэдээлэл “ил тод” байгааг юуны өмнө нягталж хэвших. Заримдаа хэсэг хүмүүст хүргэдэг судалгаанд нууц баримт бичгийг эшлэл хэлбэрээр хураангуйлж оруулсан байдаг.
- Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг сүүлийн алхам байдлаар ашиглах. Та зүй ёсны байж болох бүх аргыг ашигласны дараа мэдээллийн эрх чөлөөний хуулийн дагуу баримт бичиг шаардвал гомдол улам илүү баталгаатай болно.
- Алсыг харж төлөвлөх: Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн журам нь удаашрах боломжтой тул маргаашийн дотор өөрт хэрэгцээтэй баримт бичгийг авахад хэцүү болж магад. Иймээс хамгийн зөв мэдээлэл агуулагч этгээдийг танин мэдэж, хандах.
- Баримт бичиг авахын тулд нэр эсвэл дэс дугаарыг тодорхой хүсэлт тавих. “Өөрт байгаа бүхнээ” өгөхийг хүсвэл үр дүн гарахгүй.
- Өөрийн хүсэлтээ баримт болгон хадгалах, хүлээн авсан хариултдаа маш болгоомжтой хандах. Өөрийн ажлыг баталгаажуулан хадгалснаар та эрх баригчдын зүгээс Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг гуйвуулж, хэрэгжүүлдэггүй гэдгийг мэдэхээс гадна ямар нэгэн зүйл нууж байна гэдгийг нотлох боломжтой.

Хэрхэн мэдээллийн сантай болох вэ?

Эрэн сурвалжлах сэтгүүл зүй нь тогтолцоо хэрхэн ажилладаг эсвэл ажиллах ёстойг ойлгоход тулгуурладаг. Та сэдвээ хэрхэн олсон, төлөвлөгөөний дагуу яаж эрэн сурвалжилга хийсэн хүртэл багтана. Хариулт авахын тулд өөрийн асуултаа дараах байдлаар боловсруулна: Энэ үйл явц эсвэл тогтолцоо хэрхэн ажиллах ёстой вэ? Хэн, юуг, хэзээ, яаж хийх ёстой байсан бэ? Үйл явцаа

хэрхэн баримтжуулж, тэмдэглэсэн бэ? Ямар стандарт эсвэл хэмжүүртэй вэ? Үүнийг хэрхэн тогтоосон, хэн мөрдүүлэх вэ? Илүү дэлгэрэнгүй, цогц байдлаар хариулах тусам хаана, хэзээ юу буруугаар эргэснийг дүгнэхэд амар болно.

Үүний зэрэгцээ эрэн сурвалжлан нягтлах явцыг цаг хугацааны хэлхээсээр тэмдэглэх нь маш чухал. Та өөрийн бэлдсэн түүхээ он цагийн дарааллаар харуулах ёсгүй ч үйл явдлуудаа цаг хугацааны хэлхээсээр болсон үйл явдлыг “тодотгон” харуулвал зохино. Ийнхүү та өмнө, дараа юу болсон, нэгэн зэрэг юу тохиолдсон зэргийг илүү тодорхой харж чадна.

Та чанарын болон тоон шинжтэй мэдлэг, мэдээллээ ялгах шаардлагатай. Тоон мэдээллийн тухайд тоо ашиглан зураглахыг ойлгоно. Жишээлбэл, ямар нэгэн эм уух үед хэдэн удаа чанарын шалгалт хийх вэ? Усны бохирдлын түвшин ямар байна вэ? Сүүлийн таван жилийн хугацаанд хотод гарсан гэмт хэргийн тоо ямар байв? Тоогоор дамжуулан нотлох баримтыг гаргаж ирдэг бөгөөд жижиг хотын тухай сэдэв нь үндэсний хэмжээнд нягтлан шалгах асуудал болдог билээ. Яг л танай нутаг дахь сургууль завсардалтын тухай статистик тоо баримт улсын дүнд нөлөөлөхтэй адил.

Харин чанарын зураглалд хүмүүс, үйл явдал, учир шалтгаан, сэдэл, мэдрэмж, нотолгоо үндэслэл ярина. Дэлхийн олон улсад тоон мэдээлэл эсвэл бүртгэл статистик баримтад нэвтрэхэд хэцүү байдаг шалтгаан нь ийм ажлыг огт хийгээгүй гэдэгтэй холбоотой. Уг нөхцөлд буюу мэдээлэл дутмаг орчинд асуудлыг нягтлан шалгах хоёр арга зам бий. Өөрийн ажиглалтаа ашиглах болон холбогдох хүмүүстэй үйл явдлын бүтцийн дагуу ярилцлага хийх. Ийм байдлаар та өөрийнхөө мэдээллийн санг бий болгож чадна. Ямар нэгэн асуудлыг эрэн сурвалжлахад та хэн нэгэн хүн эсвэл бүлэг этгээдтэй нүүр тулах бол мэдээллийн сангаа ангилан хадгалснаар өмчилсөн газар, гудамжны хаяг зэрэг нь өмчлөгчийг заах чиг болох боломжтойг санаарай. Судалсан бүх мэдээллээ эмхлэхдээ цахим төслийн удирдлагын хэрэгсэл ашиглаж, ярилцсан хүмүүс, эх сурвалжийн утас, холбоо барих хаяг, мэдээлэгч, тэдний салбартаа ажилласан туршлага зэргээр мэдээллийн сан үүсгэнэ. Асуулт, үйл явдлын дараалал зэргийг бүлэглэх боломжтой тул ажлын тэмдэглэлд олж авсан үйл явдал, нотлох шаардлагатай таамаг, холбогдох баримт бичиг, үйл явдал, тоон мэдээ, мэдээллийн сан, тэмдэглэл, ярилцлага зэргийн холбоосыг нэмж болно. Evernote талбарыг сэтгүүлчдийн дунд түгээмэл ашигладаг, гэхдээ нууцлах мэдээллээ хадгалах бол найдвартай биш. Мэдээллээ удирдах програм, талбараа сонгохдоо аюулгүй байдлаа давхар бодоорой.

Бүтэцчилсэн ярилцлага

Таны сэтгүүлчийн зөн илэрч тухайн ярилцаж байгаа хүнээс хамгийн шилдэг түүх бүтээнэ гэж бодтол явуургүй болох нь бий. Гэхдээ танд хэрэгтэй зүйл бол бодит үйл явдал билээ. Та хүнийг хэрхэн “мэдэрдэг” вэ? Тэр хүн ямар үнэт чанартайгаас эхлэн, түүний хувийн намтрыг нягтлаарай. Түүнийг мэдэх эсвэл хамт ажиллаж байсан хүмүүстэй ярилцаарай. Тэд түүнийг хэрхэн тодорхойлж байна вэ? Эндээс олж авсан баримт нь танд хэрэгцээгүй санагдаж та өөрийн ажилдаа эргэлзэж магад. “Ойрын хүрээний нөхөд”-өөс болгоомжил, хэлсэн үг бүрт шууд итгэж болохгүй.

Бүтэцчилсэн ярилцлага гэдэгт сэтгүүлч ярилцлага хэлбэрээр хүмүүстэй ярилцахыг тооцохгүй боловч ийм төрлийн яриа хийх хэрэгтэй. Хүмүүс юу туулж, гэрчилснээс шалтгаалан өөрийн гэсэн мэдээллийн сан, тоон баримт бий болгохдоо дэс дараатай ажиллах шаардлагатай. Та бүх ярилцах хүнээсээ асуух тогтсон асуултын жагсаалт (ганцаарчлан ярилцах үед шинэ зүйл гарч ирвэл нэмэлт асуулт шинээр тавьж болно) багцлахдаа бүтэцчилсэн ярилцлага хийвэл зохино. Эх сурвалжийн аман мэдэгдлийг харьцуулахад бичмэл бүртгэл байхгүй учир чанарын талаас нь мэдээллээ эмхлэх нь чухал.

Энэ арга нь бага хэмжээний судалгаа хийхэд тохиромжтой бөгөөд дараах байдлаар ажиллана:

- (1) Үйл явдлыг тодруулах зорилготой асуултын цогц жагсаалттай болох. Жишээлбэл, эх сурвалжаас хамгийн эхэнд юу болсон тухай тэд юу санаж байгааг асуух. Энэ байдлаар та хэзээ асуудал эхэлсэн (танихгүй хүн хүчиндсэн эсвэл халдсан, ургац алдсан, зам эвдэлсэн, нутгийн хүмүүс алга болсон гэх мэт), үүсч болох үр дагавар (хүмүүс “Х болох үед яг таарсан юм байна” гэж хариулж магад), бусдын хариултыг (“Бид Х хот руу нүүхээр шийдсэн” гэх мэт) үнэлэх боломжтой.
- (2) Бүх эх сурвалжаас тогтсон хэдэн асуулт асуух.
- (3) Тодорхой, ойлгомжтой асуулт асуух, нарийвчилсан мэдээлэл авахыг хичээх, алдаа мадаггүй хариултаа тэмдэглэх. Хаалттай эсвэл шууд төгссөн асуулт тавих замаар тодорхой хариулт авдаг ярианы хэлбэрт хамаарах ч дэлгэрэнгүй, голыг нь олсон хариулт олох хэрэгтэй үе ч тохиолдоно. Эх сурвалж аль ч байдлаар хариулсан байсан мэдээллийн сангаа бий болгоход ашиглаж болно.

Цаасан мөр

Таны мэдээллийн сангийн олон мэдээлэл нь төрөл бүрийн цаасан мөрнөөс эхтэй байж магад. “Цаасан мөр” гэж багийн ахлагч түрүүлэн гүйн жижиг цаас тасдан мөр үлдээж, багийнхандаа зам заах зуур үлдсэн гишүүд цаасан мөрөөр нэхдэг сургуулийн сурагчдын уралдаант тоглоомоос гаралтай үг. Цаасан мөр эрэн сурвалжлах сэтгүүл зүйд адил утгаар үйлчилнэ: Таны таамаглалыг дэмжихэд хэрэгтэй баримт бичгийг тодорхойлон, хэрхэн авах стратеги боловсруулна. Нэг баримт бичиг ашиглан дараагийн холбогдох баримт бичигт хүрэх байдлаар илэрнэ. Та цаасан мөрөөр явахдаа олсон зүйлийнхээ холбоосыг эргэн харна.

Та холбоотой байж магад гэсэн анхлан олсон баримт бичгээ хураангуйлан тэмдэглээрэй. Жишээлбэл, нэг хүний товч намтарт (СиВи) түүнийг иргэний дайны (алмазнаас үүдэлтэй зөрчилдөөн үүссэн) хөлд өртсөн нэгэн уул уурхайн компанид хамгаалалтын ажилтнаар ажиллаж байсан гэжээ. Тэр хүн ажлаа хэрхэн сэлгэснийг товч намтар нь шууд илэрхийлэхгүй байж болно. Одоо тооны чадвар хэрэгтэй болно. Янз бүрийн ажилд ажилласан жилийг нь нэмж үзэхэд нийт хөдөлмөр эрхэлсэн хугацаанаас баримт бичигт дурдаагүй хэсэг байгааг харна. Гэнэт албан тушаалаас буусан эсэхийг харуулах ажлын тэмдэглэл эсвэл компанийн бүртгэл олж болзошгүй. Та эндээс тухайн хүний хөдөлмөр эрхэлсэн түүхийн талаарх баримт бичгийг нэмж хайхад хүрнэ. Та түүнийг хулгайлсан эсвэл залилсан хэмээн хүний нөөцийн хэлтэст гомдол гаргасан байхыг олж магад. Ийнхүү улам цаашлан цагдаа, шүүх, шоронгийн архиваас тухайн хүнтэй холбоотой үл мэдэг сэжиг нэхэх болно. Өөрөөр хэлбэл, та нэг баримтаас өөр баримтад хүрэх ба улам баталгаажуулсан нотлох баримт олно.

Та холбогдох болон холбоогүй баримт бичгүүдээ ялгасны дараа өөрийгөө бусдыг хэр ойлгодог эсэхийг нягтлах хэрэгтэй. Тухайн этгээдийн оронд тавьж, юу болсон талаар боломжийнхоо хэрээр зураглана: Тэр юу хийсэн байж болох вэ? Тэр А сонголт эсвэл Б сонголтыг сонгосон бол ямар ялгаа гарах байсан бэ? Ийнхүү та оргүй сэжмийн хойноос утга учиргүй гүйхээс сэргийлнэ. Таван жил гадаадад амьдарч байсан нэг хүнийг шууд Ерөнхийлөгчийн “зөвлөх”-өөр томилсон тохиолдолд түүний талаар Ерөнхийлөгчийн Тамгын газраас мэдээлэл хайх нь ямар ч утгагүй. Энэхүү томилгоо нь олны нүднээс далд, хэдхэн зүйл бүхий хялбар, богино хугацааны гэрээнд тулгуурлан хийсэн байх болно. Үүний оронд тэрхүү хүний амьдарч байсан гэх газар эсвэл аль аль улсын хилээр зорчсон тухай мэдээллийг хилийн чанадаас хайвал илүү үр өгөөжтэй.

Цаасан мөрөөр явахад олон нийтийн мэдэх эсвэл төрийн албаны баримт бичиг ихэвчлэн таарах учир хувь хүнд байгаа баримт бичигт нэвтрэхийн тулд бүтээлчээр эх сурвалж олж авах чадвараа ашиглах хэрэг гарч мэднэ.

Олон сэтгүүлч номын сан, архив ашиглах нь энгийн зүйл гэдэг. Үсгийн дарааллаар ангилсан болохоор та эрж байгаа хүнийхээ нэрийг хайж болох ч дандаа санаснаар болохгүй. Хэрэв та компьютерт оруулсан тэмдэглэл ашиглаж байгаа бол тухайн нэртэй холбогдох үр дүн гарах ч дагаад хэрэггүй олон зүйлс илрэх болно.

Олон улс оронд ялангуяа буурай улсад төрийн албаны бүртгэл, тэмдэглэл нь биет байдлаар тоосонд даруулан хадгалагдаж байдаг. Та тухайн өрөөнд нэвтрэх эрхтэй хаалгачтай хэл амаа олж, баримт бичгийг хэрхэн ангилсан болохыг мэдэхийн хамт ашиглаж сурах хэрэгтэй болно. Ийнхүү маш их цаг хугацаа, эрч хүч хэмнэнэ шүү.

Төрсний гэрчилгээ, жолооны үнэмлэх зэрэг нийтийн бүртгэлээс хайж эхлэх нь мөр хайх шилдэг алхамд тооцож магад. Гэхдээ мэдээлэл түгээх цахим сангаас хүний тухай хайхад гайхам ашигтай. Байгууллага бүр өөрийн гэсэн цахим хуудастай (вебсайт), хувь хүний тухайд блог, олон нийтийн сүлжээнд (сошил медиа) хаягтай байдаг. Хэрэв өөрийн жинхэнэ нэрээ ашиглах хүсэлтэй этгээд бол мэдээллийн хайлтын хэсэгт тухайн хүнтэй холбоотой шүүхийн нэхэмжлэл эсвэл их сургуульд суралцаж байсан зэрэг барьцтай мэдээлэл гарч ирнэ. Мэдээ нь орон нутгийн барилга (банк, компани, төрийн байгууллага гэх мэт), хууль ёсны мэдэгдэл (гэрээслэл, нэрээ өөрчилсөн, гэрэлсэн, оршуулсан бүртгэл, дуудлага худалдаа, тендер, хураан авсан/шаардаагүй өмч гэх мэт), баривчилсан, ял шийтгэсэн тухай хувь хүнд хамаарах болон цаасан мөр болгох маш их хэмжээний мэдээлэл агуулдаг. Мэдээллийн дээрх хэсэг бүр таны учрыг нь олохыг хүсч байгаа зангилаанд сэжүүр болно.

Нэгтгэвэл та цаасан мөрөөр:

Вэбээр хайх, архивт очих, тухайн хүний талаар мэдэхийг хүссэн баримт сэлтээ эвлүүлэх хүртлээ эх сурвалжаа шахаж яриулна.

» Мэдээллийг зураглах арга ашиглан дээрх баримт бичгийг зураглахын хамт дутагдалтай, зөрчилдөөнтэй, авцалдахгүй байгаа хэсгийг тодруулна.

» Дутаад байгаа хэсгийг ямар баримт бичгээр нөхөх эсвэл зөрчилдөөнтэй хэсгийг хэрхэн шийдэхээ эргэцүүлж, эдгээр баримтын мөрөөр нягтлан шалгаж эхлээрэй.

Компьютерын тусламжтайгаар сурвалжлах нь (КТС)

Компьютерын тусламжтайгаар сурвалжлах гэдэг нь сэтгүүлч нь мэдээ бэлтгэхийн тулд мэдээлэл цуглуулах эсвэл дүн шинжилгээ хийхдээ компьютер ашиглахыг хэлдэг. Ялангуяа интернет нь сэтгүүлчдийн авах боломжтой мэдээллийн хүрээг тэлж, зохион байгуулах, олж авах, задлан шинжлэх чадварыг огцом тэлсэн. Алдартайгаас ДакДакГоу ([DuckDuck-Go](#)) болон дөрөв, таван хайгуулын талбараас зэрэг хайдаг [мета-хайгуулын](#) аргачлал бий. Цахим хуудаснаас үр өгөөжтэй хайгуул хийх нэг арга нь холбогдолгүй үр дүнг харуулахаас сэргийлж, түлхүүр үг, холбоо үгсээ хангалттай тодорхой бичих юм. Хайх шалгуураа тусгайлан зааж, үр дүнгээ тултал нь ашиглах боломжтой. [ДакДакГоу](#) ашиглахдаа цаг хугацаа, бүс нутаг, хэл зэргээр ангилан шүүх, эсвэл хайлт бүрийн үр дүнгээ тоогоор хязгаарлах судалгааны арга ч ашигладаг. Түлхүүр үгээр өөрийн хайж байгаа сэдвээ нарийвчлан харахад хэрэгтэй ч дангаараа хангалттай биш. Та Жон Смит гэдэг хүний тухай мэдээлэл хайж байна гэж бодъё. Хайлтын мөрөнд Жон Смит гэж бичин хайвал тус хоёр нэрийг харуулсан олон мянган баримт гарч ирнэ. Ийм хайлтын үр дүнд хөл алдахгүйн тулд Жон Смиттэй холбоотой түүний төрөлх хот, мэргэжил зэрэг онцгой шинжүүдийг оруулж болно. Хэрэв интернетээс хайсан мэдээллээ олон нийттэй хуваалцах, дэлгэцэн дээрх мэдээллээ зураглан хадгалах тохиолдолд сурталчилгааны цонхыг хааж, эрээ цээргүй мэдээллийг арилгавал зохино. Зөвхөн өөртөө зориулан мэдээллийн сангаа зохион байгуулалтад оруулж, хайхад амар байдлаар хийгээрэй. Интернетээс баримт бичиг хадгалах, ярилцлагын тэмдэглэлээ хуулахдаа мэдээллээ эргээд олоход хялбар байдлаар бэлтгээрэй.

Өмнө дурдсан төсөл удирдах аргачлалыг ашиглаж болох юм. Компьютерын тусламжтайгаар сурвалжлахад [ёс зүйн асуудлыг](#) давхар санаарай:

- ! Аль болох дэлгэрэнгүй эшлэл, цахим хуудасны холбоосоор дамжуулан эх баримтаа уншихаар оруулах, өөрийн олж ашигласан мэдээллээ ил тод байлгаарай.
- ! Мэдээллийн огноог шалгах зэргээр өөрийн мэдээллээ маш нарийн нягтлах.
- ! Тоон мэдээлэл, бүртгэлээс зөв зүйтэй дүгнэлт хийх. Уншигчид тооцоо хийж чадахгүй тул зөвхөн таны бичсэнд итгэх хэрэгтэй болно.

Зарим судалгааны аргыг [researchclinic.net](#) цахим хаягаас үзээрэй.

Хэрхэн Мэдээллийн Сангаа Уудлах Вэ?

Мэдээллийн санг уудлах нь олдсон нотлох баримтаа хамгийн объектив байдлаар шинжлэхэд туслах үйл явц билээ. Аль сэжим нь таныг зөв замаар явж байгааг харуулах талаар эргэцүүлээрэй: Хулгай хийдэг сувилагчийн тухай эмнэлэгт хэвтсэн нэг өвчтөний гомдол уу эсвэл сүүлийн таван жилд Эрүүл мэндийн яамны сахилгын хороонд хулгайн асуудлаар ирсэн гомдлын дагуу зохион байгуулсан сонголт, халсан шийдвэр үү? Дээрх бүх мэдээлэл байсан ч тоо баримт буруу ойлгогдох, өөр мэдээлэл өгөх боломжтойг санахын хамт мэдээллийн санд сүүлийн арав гаруй жилийн түүх бий гэдгийг мартаж болохгүй.

Олон улсын мэдээлэл сангаас илүү холбогдохуйц үр дүнг гаргаж мэднэ. Жишээлбэл, хөгжлийн тусалцааны хандивлагчид жил бүр хэдий хэмжээний мөнгө зарцуулсан тухай тайлагнадаг. Өөрийн улсад ажиллаж байгаа хандивлагчдын тайлангаас хэрэгтэй мэдээллийг авч, шинжилснээр “Манай улсын төрийн албан хаагчдын сургалтад хандивлагчид ихэнх мөнгөө зарцуулжээ” гэсэн гарчигтай бүтээлийг хүргэж чадна.

Мэдээллийн санг уудлах нь зөвхөн санхүүтэй холбоотой байх албагүй. Нийгмийн сүлжээний /social network/ дүн шинжилгээ хийж террорист бүлэг, улс төрийн намын дэмжигчид, нийгмийн хамгийн нөлөөтэй, баян хүмүүсийн тухай түүх бэлтгэж байсан юм. Эдгээр сүлжээнд тухайлсан мэргэжилтнүүд, газарзүйн байрлалаас хамааралтай бүлэг, улс төрийн нам дахь алдартай хүн байж болно. Тэд хэдэн төгрөгийн орлоготой, хэнтэй хамтран ажилладаг, тэдний нийгэмд үзүүлэх нөлөөг илтгэхүйц байдлаар нийгмийн сүлжээнд хэрхэн дүрсэлдэг зэрэг өгөгдлийг хослуулна.

Та бусад сэтгүүлч болон бусад байгууллагын мэдээллийн санг ашиглан өөрт хэрэгтэй бүх мэдээллийг нэгтгэж чаддаг байх нь чухал. Сэтгүүлчид болон, байгууллагууд мэдээллийг сэдэвчилсэн байдлаар мэдээллийн сандаа хадгалдаг. Ингэхдээ өгүүлэл, судалгаа, холбоо барих гэх мэтээр мэдээллийг ангилах нь бий. Энэхүү мэдээллүүд нь суурь судалгаа болдог. Дэлхийн эргэн тойронд ажиллаж байгаа эрэн сурвалжлах сэтгүүлчдэд зориулан АНУ болон Европт мэдээллийн санг уудлах боломжтой төв байгуулсан байдаг.

Жишээлбэл, АНУ-ын Никар Гуантанамогийн буланд хоригдсон хүмүүсийн тухай мэдээлэл цуглуулж, мэдээллийн сангаа нийтэд дэлгэсэн юм:

nicar.org/downloads



Тооны учрыг яаж олох вэ?

Яагаад, юуны учраас асуудал буруугаар эргэсэн, үүнийг хэн хариуцах талаар эрэн сурвалжлах сэтгүүл зүйд чанарын үзүүлэлт зонхилдог. Гэсэн ч эрэн сурвалжилж бичсэн түүх бүрт тооны мэдээлэл орсон байдаг. Төсвийн алдагдал хэр их байсан бэ? Манай улсад хууль бус агнуурын тоо хэд вэ? Жил бүр хэдэн өвчтөнг эмнэлэг хүлээн авдаггүй вэ?

Багахан үзүүлэлтээс том тоог тайлбарлан илэрхийлэх, хувьд шилжүүлэх зэрэг хялбар үйлдлээр тоог учир утгатай болгохоо та мэддэг байх хэрэгтэй. Тоонд үнэхээр дуртай хүмүүс сэтгүүлч болоогүй байдаг. Тоо бол хэцүү зүйл биш төдийгүй эрэн сурвалжлах түүх бичих үндэс юм.

Олон хүн өөрийгөө тооцоолох ямар ч ур чадваргүй хэмээн сэтгэж, амьжиргааны зардлаа төсөвлөх, галт тэрэгний тийз улирлаар авах, төлбөр нэмсэн талаар тохиролцох зэргийг өдөр бүр өөртөө хэцүү аргаар боддог. Математик зааж байгаа ихэнх сургуулийн арга нь хүүхдийг айдаст автуулж, математикийн шинжлэх ухааны үзэл санааг бодит амьдралд ашиглаж сургаагүй байдаг.

Сэтгүүлчдэд хэлэх сайн мэдээ бол хэвлэл мэдээллээр харуулах тоо нь хэрэглээнд голчлон анхаарч, маш хүчтэй чанарын мэдээлэл (хэн тоон мэдээ цуглуулдаг, хэрхэн, яагаад гэдгийг ойлгох) болдог. Та үндсэн ойлголттой байх шаардлагатай. Жишээлбэл, та сувилагчийн ажлын байрны тодорхойлолт, ажлын үр өгөөжийг нягтлахыг хүсвэл тухайн салбарын мэргэжилтэнтэй хамтарч болох бөгөөд тэр танд “ажлын нэг өдөр”-ийн цагийн хуваарийг мэдэхэд тусална.

Ажиглалт, ярилцлагаар олж авах зүйлсийн тухайд:

- ? Ямар ажилд хамгийн их цаг зарцуулдаг вэ? Сувилагч цаг хэмнэх боломжтой юу? Ямар боломж байна вэ? Сувилагч цагийн хуваарийн дагуу ажиллахад хэт их ачаалалд орж байна уу?
- ? Сувилагчийн ажлын байрны тодорхойлолт нь эмнэлэгт ирэх өвчтөнүүдийн дундаж тоотой уялдаатай юу? Нэг өвчтөнд хэр их хугацаа зарцуулдаг вэ?

Үүнтэй адил агаарын чанарыг шинжлэх тохиолдолд агаарт байгаа бохирдуулагчийг мэдэх, эдгээр нь эрүүл мэндэд аюултай эсэх, ямар түвшинд хүрвэл хор хөнөөлтэйг эмнэлгийн мэргэжилтэнгээс асууна. Өөрийн улсын агаарын чанарын индексийг бусад улс орныхтой харьцуулаарай. Агаарын чанарын индекс нь удаан хугацаанд үзүүлэлт өөрчлөгдөөгүй, эсвэл бохирдлын түвшин тогтмол өсдөг, байх ёстой стандартаас доогуур ч байж мэднэ! Сэтгүүлчийн ажил бол эдгээр тоог тайлбарлах, асуудал улам ноцтой

болж байгаа эсвэл анхаарах төдий эсэхийг тодорхойлоход оршино. Тоо дангаараа хангалттай байдаггүй. Одоогийн нөхцөл байдал буюу “Яагаад тухайн асуудалд анхаарах болсон бэ?” гэдэгт таны бүтээл оршиж магад.

Тухайлбал, Цаг агаарын тухай тоон мэдээ нь олон улсын хувьд хамгийн удаан цуглуулсан статистик мэдээлэл байдаг. Африкт колонийн үеийн эрх мэдэлтнүүд хамгийн анх тоон мэдээг бичиж тэмдэглэсэн бөгөөд үер, ган гачгийн талаар уламжлалт аман түүхээс эрж хайх боломжтой. Азийн олон улсад цаг агаарын үзүүлэлтээр мэдээллийн сан бүрдүүлсэн байдаг. Түүн өмнөд Европт албан ёсоор цаг агаарын бүртгэлийг XIX зууны сүүлчээс эхлүүлсэн. Уур амьсгалын өөрчлөлтийг эрэн сурвалжлах үед танай улсад үер, ган тохиолдоогүй байж болно. Тэгвэл цаг агаарын үзүүлэлт хэрхэн хэлбэлзэж байгааг харьцуулан, шинжлэх нь зүйтэй.

Бүтээл бичихдээ үргэлж ямар мэдээлэл илүү ач холбогдолтойг эрэлхийлээрэй. Зарим хүн танд сэжүүр өгөх ч та сэдвийг бүхэлд нь судлах ёстой. Эрэн сурвалжлах бүтээлийн санаа нь ном уншиж байхад, санамсаргүй сонссон ярианаас эсвэл хэвлэлийн мэдээнээс төрж болно. Хэвлэлийн мэдээнд тоо баримтыг дурдахдаа задалж дүгнэхээс илүү олны нүдэнд өртөхөөр тод бэлддэг. Хэвлэлийн мэдээнээс ч та эрэн сурвалжлах бүтээлийнхээ үндсэн мэдээллийг авч, улам томруулан бичих боломжтой. Сайн эрэн сурвалжлах сэтгүүлчид сэжүүрийг олж хардаг. Харин тэр, бүдүүвч, хүснэгт зэрэг тоон мэдээнд эргэлзэж байгаарай. Эдгээр нь чухал харагдах ч тус мэдээллийг боловсруулсан арга, судалгааг хэрхэн хийсэн, түүврээ яаж авсан, хэн санхүүжүүлсэн, хэвлүүлсэн, ямар нэгэн нарийвчилсан мэдээлэл орхисон эсэхийг эрэн сурвалжлах сэтгүүлчийн хувьд заавал асуугаарай.

Жиших, харьцуулах бүлэг

Хоосон тооноос олон зүйл гаргаж чадахгүй. Нийт хүн амын тодорхой хэсгээс түүвэр хийсэн болохыг санаарай. “Таван эмчийн дөрөв нь” гэх нь итгэл үнэмшилтэй сонсогдох ч Англид мэргэжлээрээ ажиллаж байгаа 20 эмчээс авсан бол 16 эмчийн хариулт хангалттай биш. Тэд нийт эмч нар юу бодож, эргэцүүлж байгааг төлөөлөхөд хангалтгүй байна.

Түүвэр судалгаанд олон шалгуур тавьж харах хэрэгтэй. Жишээлбэл, сэтгүүлчид улс даяар судалгаа хийхдээ эсрэг тэсрэг байр суурийг тусгахын тулд бүх төрлийн хот, эмнэлгээр орсон эсэхийг асууна. Утсаар ярьсан,

цахимаар харилцсан эсвэл нүүр тулж уулзсан зэрэг ямар аргаар судалгаа авсан бэ? Сэтгүүлчид судалгааны итгэл үнэмшилтэй байдлыг нягтлахын тулд сэдэв, үр дүнгээс хамаарч харилцан адилгүй шалгууруудыг тавьж болно.

Графикийг тайлбарлах нь

Графикийг тайлбарлахын тулд эн тэргүүнд тэмдэглэгээг сайн хараарай! График хаанаас эхэлж, дуусаж байгаа хэмжээг ойлгох хэрэгтэй. Өчүүхэн өөрчлөлтийг тодотгон харуулахын тулд эхлэл болон дуусах цэг хооронд гарсан өөрчлөлтийг дүрслэн харуулахад хангалттай. График тайлбарлах үедээ хувийг нягтлаарай. Жиших, харьцуулах бүлгийн талаар ямагт санаарай.

Заримдаа хоёр өөр төрлийн мэдээллийг нэг графикаар харуулах нь бий. Гэхдээ тус графикаар илэрхийлсэн мэдээллүүд нэг нь нөгөөтэйгөө уялдаа холбоотой гэдгийг баталж харуулдаггүй. Хүүхэд нас нэмэх тусам өсөж том болдог. Мөн нас нэмэхийн хэрээр хэлний чадвар сайжирна. Гэхдээ бие махбодийн өсөлт хэлний чадварыг нэмэгдүүлнэ гэсэн үг биш. График, хүснэгтийг дахин дахин уншиж, мэдээллийн хамаарлыг олж үнэлэх нь чухал. Тухайн хамаарлыг тодотгосон адил төрлийн эсвэл харьцуулсан судалгаа бий эсэхийг нягтална. Ямар нэгэн үйл явдлын дараа дараагийн өрнөл байдаг учраас эхний асуудлын шалтгаан нь хоёр дахь үйл явдлаас болсон гэж баталж болохгүйтэй адил. Мэдээлэл дангаараа ч нотолгоо болж чадахгүй. Одоогийн нөхцөл байдлаа дахин нягтлах, шалтгааныг тодруулах, эхний үйл явдал удаах нөхцлийг үүсгэсэн хэмээн нотлох тодорхой механизмыг судалсан байхыг шаарддаг.

Та одоогоор мэдээллээ цуглуулчихсан, боломжит эх сурвалжийнхаа нэрсийг гаргачихсан, өөрийн гэсэн мэдээллийн сантай болчихлоо. Тэгвэл дараагийн бүлгээс баг болж чадах хүнийг хэрхэн таних, тэдний мэдлэгийг хэрхэн нэмэгдүүлэх талаар тайлбарлана.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

ЧШШ... ОЙЛГОЛТООС МЭДЛЭГ РҮҮ

Аман эх сурвалж бол эрэн сурвалжлах зарим сэтгүүлчдийн хувьд маш том хөрөнгө гэж болно. Хэрэв эх сурвалжтайгаа итгэл төрүүлсэн харилцаа тогтоож чадвал шуугиан дэгдээсэн томоохон бүтээл гаргаж чадна. Энэ бүлэгт эх сурвалжтай хэрхэн харилцаа тогтоох, тэдний итгэлийг олж мэдээллээ олон нийтэд хүргэх зөвшөөрөл авах талаар өгүүлнэ. Үүнтэй уялдан тухайн сэдвээр мэргэшсэн шинжээч болон луйварчинг ялган таних, мөн өөрийн бодлоо гүйцээхийн тулд сэтгүүлчдэд нөлөөлөх бодолтой лоббичин, давхар бодолтой нөхдийг таних асуудал багтана.

Сайн эх сурвалжийг яаж таних вэ?

Эх сурвалж олох, хөгжүүлэх, хадгалах нь эрэн сурвалжлах сэтгүүлчийн хувьд маш чухал ажил. Хамгийн чухал, найдвартай, тодорхой эх сурвалжид гол төлөв гэрч, нүүр тулсан хүмүүс, нэг бол тухайн явдалд оролцсон хүмүүс байдаг. Та гэрчийн нэрсийг гаргахдаа тухайн хэрэг явдал болсон газарт байсан хүмүүсийн нэрийг шүүрдэх, эсвэл түүвэрлэн уулзаж тодорхойлно. Хүмүүс өөрсдийгөө байсан, оролцсон гэвэл үнэхээр тийм эсэхийг заавал шалгах ёстой. Хэрэв эх сурвалж үйл явдлыг биеэр туулсан бол маш үнэ цэнэтэй болох нь дамжиггүй. Хэрэв та өөрөө болсон явдлыг нүдээрээ харсан бол чухал гэрч гэсэн үг.

Та бүтээл бичих бүртгээ өөрийн эх сурвалжийн сүлжээний хүрээг тэлэх боломжтой. Мэдээллийг сурвалжлах явцад энэ бүхэн бий болдог зүйл. Хэрэв та төслийн хүрээнд эрэн сурвалжлага хийж байвал та асуудалд маш ойр, найдвартай эх сурвалжаас бүрдсэн сүлжээг урьдаас бий болговол зохино. Сэтгүүлч нөхдөө үл тоож болохгүй, тэдэнд хувь хүмүүстэй тогтоосон харилцаа байж болно. Харин өрсөлдөөн ширүүн тохиолдолд та дэлгэрэнгүй хуваалцах шаардлагагүй. Таны бичих бүтээлтэй илэрхий холбоотой хүмүүсийг сураглах боломжтой ба спорт клуб, шашны байгууллага, хандивын зэрэг байгууллагын тооцож үзээрэй.

Тухайн сэдэвтэй ямар нэгэн байдлаар холбоотой учраас тэдгээр хүмүүсийн харьцаа эсвэл хандлага хэдийнэ тогтсон байх магадлалтай тул өөрийн эрэл хайгуулдаа нөлөөлөх хүчин зүйл гэж тооцвол дээр. Тухайн этгээдтэй өмнө холбоотой байсан бизнесийн хуучин түнш, салсан хань, ажилтан, эмч, багш, цагдаагийн эсвэл цэргийн халагдсан алба хаагч гэх мэт хүнийг мартаж болохгүй. Мөн тэдэнтэй маргалдаж, заргалдаж байгаа хүмүүс ч маш чухал гэрч байж болно. Энэ бүхнийг та үг сэтгэл хөдлөл, хандлагаас нь ажиглаарай. Хөгжлийн судлаач Жое Ханлон үүнийг “түүнийг мэддэг эмэгтэйг олох” гэж тодорхойлдог.

Эх сурвалжийг үнэлэх нь

Хүмүүс янз бүрийн шалтгаанаар таньд сэжүүр өгөх боловчихэнх нь эрэн сурвалжлах сэтгүүлзүйд туслахгүй эсвэл болсон явдлыг дэлгэн харуулахад хангалтгүйбайдаг. Та эх сурвалжтай уулзах үед ч адил зүйл тохиолдож мэднэ. Танд ямар нэгэн зүйл хэлэхдээзовлон шаналал, нөхцөл байдал, итгэл үнэмшлээсээ хамааран зарим зүйлийг дөвийлгөх эсвэлбусдын талаар огт дуугарахгүй байх нь бий. Танд зарим эх сурвалж туслахыг хичээж, таны

сонсохыг хүсч байгаа гэж бодсон зүйлээ ярина. Эх сурвалжаа урьдчилан судалснаар зарим зүйлийг илүү тодруулан харах ба тэдний яриаг сонсохдоо тасралтгүй ажиглах ч бас тустай.

Хүмүүс заримдаа илэрхий алдаа гаргаж, нарийн тодорхой зүйлийг мартдаг. Тиймээс та гуравдагч, хараат бус эх сурвалжаас аливаа зүйлээ баталгаажуулах хэрэгтэй.

Бие биенээ мэдээгүй хоёр эх сурвалжаас авсан нотлох баримт ч гэсэн нэг зүгт (тэр бүр тийм байхгүй ч) чиглэвэл зохино. Танд хоёр дахь эх сурвалж байхгүй эсвэл хангалттай цаггүй тохиолдолд та “энэхүү эшлэлийг батлах боломжгүй байлаа” хэмээн нууцаа дэлгэхэд хүрнэ. Бүтээлээ бичихэд хэт олон нягтлан шалгаагүй эшлэл, шаардлага, гомдол байвал нь таныг эрэн сурвалжлах сэтгүүлч мөн үү гэдэгт эргэлзэхэд хүргэнэ.

Хэрэв таны хоёр дахь эх сурвалж мэдээллийг баталгаажуулахаас илүүтэй зөрчилдвөл яах вэ? Энэ тохиолдолд та аль аль талаас юу олсноо мэдээлж, эсвэл бүтээлдээ зөрчилдөөн оруулаарай. “Дотоод хэргийн сайд зэвсэглэсэн хүмүүс хил давсан гэж хэлсэн ч Батлан хамгаалах яамнаас тэднийг зэвсэггүй байсан гэжээ.” Таны бэлдэж байгаа бүтээлтэй зарим зүйл огт тохирохгүй бол та зүгээр орхиж болохгүй шүү, учир нь таны найдвартай, мэргэжлийн байдлыг эрсдэлд оруулна. Семур Херш зэрэг маш сайн бүртгэл хийсэн, эх сурвалжийн маш өргөн сүлжээтэй сэтгүүлчид хүртэл заримдаа нэг эх сурвалжид найддаг. Бүр гарын таван хуруунд багтах нь бий.

Та хэнтэй ч ярилцах бай эн тэргүүнд тухай хүн тань өөрийгөө хэн гэж харж байгааг мэдэх нь чухал. Тэд өөрийн ажил, хаяг, гэр бүлийн мэдээлэл, цэргийн бүртгэл, паспорт, иргэний үнэмлэх, жолооны үнэмлэхээ баталж чадах уу? Хэрэв эх сурвалж тань гэмт хэрэг үйлдэж байсан, сэтгэцийн өөрчлөлттэй, санхүүгийн асуудалтай, хүчирхийлсэн, луйвардсан этгээд бол тэдний хэлсэн зүйлд эргэлзэх шаардлагатай. Эх сурвалж ярилцахаас татгалзвал тэрээр яагаад мэдээллийг нуух болсон ноцтой шалтгаан байгаа бөгөөд та тэдний хэлэх мэдээлэлд итгэх эсэхээ өөрөө шийднэ гэсэн үг.

Та юу хайж байгаагаа мэдсэн цагт та хэр зэргийн зүйл олж авахаа үнэлж чадна. Эх сурвалж цогц тайлбар хэлэв үү, эсвэл олон салангид нотлох баримт өгөв үү? Та тэдгээр олон салангид хэсгийг бусадтай нийлүүлж, нэг мөр нягтласнаар өөр дүгнэлт хийж чадах уу? Эх сурвалжийн



туулсан туршлага нь түүний амьдарч байгаа газрынхаа амьдралыг төлөөлөх нэгэн мөн үү? Цаг үеэ олсон уу? Эсвэл олон жилийн өмнө болсон тул бүх зүйл өөрчлөгдөж, нарийн зүйлсийг санахаа больсон уу?

Мэргэжилтэн

Түүхч, судлаач, хуульч, инженер гэх мэтчилэн бараг бүх салбарт мэргэшсэн мэргэжилтэн байдаг. Корпорацийн хэргийг судлах үедээ (үндэстэн дамнасан корпорацийн үйл ажиллагаа гэх мэт) тохирох мэргэжилтэнг олох нь маш чухал. Яг л тус компанид ажилладаг хүнийг олохтой адил. Юуны өмнө тэрээр хэрхэн ийнхүү мэргэшин туршлага хуримтлуулсан, таны эрэн сурвалжилж байгаа үйл явдалд оролцсон эсэхийг тодруулвал зохино. Таны судлах сэдвээр нэг салбарын өөр өөр мэргэжилтэнгүүд шинэ санаа өгч магад. Та хүний эрхийн зөрчлийг бичиж байгаа тохиолдолд хуульч, цагдаа, эмч, байцаагчийн байр суурийг бүтээлдээ оруулсан эсэх нь хүний эрхийн үзэл санааг дэмжигчдийн хувьд чухал байж болно.

Харин бүх мэргэжилтэн адил байр суурьтай эсвэл найдвартай байдаггүй. Мөн итгэж болох бусад сэтгүүлчдээс зөвлөмж авч, тухайн хүнээ



интернэтээс судлаарай. Судлаачид арилжааны зорилгоор санхүүжилт авч судалгаа хийдэг, мөн лоббичин байдлаар аль ч талд ажиллаж мэдэх тул тэд хэний төлөө судалгаа хийдэг болохыг олж мэдээрэй. Тэдний судалгааны эцэст ямар шүүмж өгүүлсэн, тодорхой салбарын хүрээнд ямар ярвигтай санааг илэрхийлэн сайшаасан эсвэл шүүжилсэн болохыг санаарай. Найдвартай мэргэжилтэн байсан ч түүний хувийн байдал болон түүний тайланг хүртэл нягтлан шалгах хэрэгтэй. Хэрэв цөөнгүй мэргэжилтэн санал нэгдэхгүй тохиолдолд уншигчдад зориулан нөхцөл байдал юугаараа ялгаатай байгааг харуулах хэрэгтэй. Түүнчлэн зарим мэргэжилтэнгүүдийн байр суурь үнэхээр жин дарсан учраас та тэднийг байр суурийг харуулсан боловч энэ нь буруу нотолгоо байж мэднэ. Мэргэжилтэнгүүд тэнцүү хуваагдсан тохиолдолд үүнийг тайлбарлах боломжийг уншигчдад үлдээвэл зохино.

Хэвлэл мэдээлэл дэлхийн дулаарлын талаарх мэтгэлцээнийг тэнцвэртэйгээр харуулсаар ирсэн. “Дэлхийн дулаарал гэж үгүй” хэмээн мэтгэлцэж байсан “мэргэжилтэн” бол эрчим хүчний лоббичдын төлбөр төлсөн хэвлэлийн төлөөлөгчид байсныг бид саяханаас мэдсэн. Үнэндээ олон жилийн турш дэлхий дулаарал үргэлжилж, аюултай байгааг илтгэсэн шинжлэх ухааны нотлох баримт үлэмж их байсан юм.

Олон улсад төрийн байгууллага бол, мэдээллийн хамгийн найдвартай мэргэжлийн эх сурвалж гэж тооцох нь бий. Хараат бус судалгааны тайлан, маш тодорхой хурлын тэмдэглэл, шүүхийн ажиллах журам, бүртгэл бүхий баримтыг олох хүртэл их хол зам туулсан билээ. Ач холбогдолтой зөрчилдөөнтэй сэдвээр эрэн сурважилга хийж байгаа бол, гэнэн бас аюултай таамаглалыг батлахад хүрнэ. Төрийн албан хаагчид бусад мэргэжилтэнгүүдийн адил зөв юм уу буруу хариулт өгч магадгүй. Тэд тухайлсан асуудлаар мэдээлэл өгөхдөө төрийн дарамттай нүүр тулсан байж болзошгүй. Бусад эх сурвалжийг үнэлэхдээ түүнд энэ тухай ярих сонирхол байгаа эсэх болон мэдээллий агуулгыг анхаараарай. Түүнчлэн мэргэжилтэнгүүд маш мэдлэгтэй бөгөөд өрөөсгөл хандсан хий хоосон мэт таамаглал дэвшүүлж болно. Гэхдээ тэдний таамаглал зөв байж ч болно гэдгийг анхаараарай. Мэргэжлийн бус хүнээс авсан мэдээлэлтэй адил хоёр дахь эх сурвалжаас тэдний өгсөн бүх мэдээллийг нягтлаарай. Аль болж өгвөл төрийн байгууллагын мэргэжилтэнтэй албан бус байдлаар, тусгайлан цаг авах журмыг мөрдөлгүйгээр ярилцаарай. Ийм байдлаар ярилцснаар эшлэх боломжгүй боловч таны бүтээлийн хүрээг тэлж өгнө.

Бид олон улсын байгууллагын тайланг бодлого боловсруулахад ашиглах эх сурвалж хэмээн хардаг тогтсон хандлагатай. Гэтэл тэдний зүгээс танай нутгийн эсвэл ажиллаж байгаа улсаас хэрэгтэй хүнтэйгээ холбоо барих мэдээллийг таньд өгч чадна. Тэд танд туслах үүрэг хүлээгээгүй ч, тэдний ашиг сонирхолд нийцсэн асуудлаар та эрэн сурвалжлаж байгаа гэдгээ ойлгуулж чадвал бүрэн дэмжих боломжтой. Нөгөө талаас хандивлагч байгууллага (бусад байгууллагын адил), бусад агентлаг өөрийн бодлого, зарчимтай бөгөөд түүнийгээ чанд даган мөрдөж, байгууллагаа бэхжүүлдэг. Та тэдний санал, мэдээллийг бүтээлдээ тусгахаар бол тэнцвэржүүлэх шаардлагатай бөгөөд өөр эх сурвалжтай ярилцах хэрэгцээ гарна.

Та сэдвээ бэлдэж байгаа, эсвэл аль хэдийнэ мэдээлэлтэй гэж дүгнэсэн бол холбоо барих зарим хүнээ “алгасч” болно. Та үүнийг хувийн сүлжээгээ ашиглах, эрэн сурвалжилсан бүтээлээ урьдчилсан байдлаар нийтлэх замаар гүйцэтгэх боломжтой. Энэ үед шинэ хүмүүс нэмэлт мэдээлэл сайн дураар өгөх, нэг бол эргэлзээт эх сурвалж таны түүхийг “зөв” болгоно. Хоёр үзүүртэй зүү мэт энэ тактикт давуу, сул тал байх учир болгоомжлоорой.

Таны шүүмжлэлийн талаар хүмүүс мэдэж, өөрийн нотлох баримтаа нуух, эх сурвалжийг чимээгүй болгох, таны эсрэг гар мухардуулах арга хэмжээ ч авах боломжтой шүү.

Таны эрэн сурвалжилгын үнэн мөнийг батлан даах мэргэжилтэн олдохгүй бол та урагшлахгүй гэсэн үг. Та тохиромжгүй мэргэжилтэнгээс асуусан, эсвэл буруу асуулт тавьсан бололтой. Бүтээлдээ ялгаатай байр суурийг тусгах нь таныг хэвшмэл ойлголтгүйг харуулах учир эрс тэс бодолтой мэргэжилтэнгүүд тантай уулзах сэдэл төрүүлж мэднэ.



Шүгэл үлээгч, хаалгач, үүд нээгч

Цөөнгүй тохиолдолд сайн унших замаар “шүгэл үлээгч”-тэй (өөрийн ажиллаж байгаа байгууллагын доторх муу муухайг жигшсэн ажилтан) уулзаж болно. Хөгжингүй орнуудад олон компани, байгууллага, төрийн албанд шүүмжлэлт сэтгэлгээтэй, мэдээллээ хуваалцах боломжтой албан бус цахим уулзалтын “өрөө” байдаг. Харин эдгээр цахим орчноос өөрийн бүтээлдээ мэдээлэл ашиглаж болохгүй. Жинхэнэ шүгэл үлээгч мөн эсэх, таны шаардлагыг дэмжих эсэхийг тэрхүү эх сурвалжтай нүүр тулан уулзсанаар баримтаа баталгаажуулах хэрэгтэй.

Таныг аврах боломжтой байгууллага дотор байгаа маш чухал холбоотон бол ёс суртахууны шаардлага, өөрийгөө “нүднээс далд” ажиллах эрсдэлд оруулсан хүмүүс юм. Хаалгач гэдэгт нарийн бичгийн дарга, хүлээн авах, үүдний жижүүр зэрэг таныг дотогш оруулах, хэн орж, гарч байгааг хэлдэг хүнийг хэлнэ. Өндөр албан тушаалтанд л зөвхөн анхаарч алдаа гаргав. Хүн бүртэй мэргэжлийнхээ хувиар сайн холбоо тогтоохыг хичээ. Хаалгачид нь биечлэн хамгаалахаас илүүтэй мэдээлэлд нэвтрэх хяналт бүхий бэлгэ тэмдгийн шинж илэрхийлдэг. Хаалгачид бол банк, орлогын газар, төрийн байгууллагын ажилтны хувиар хөдөлмөрийн гэрээний тодорхой хэсэгт нууц хадгалах гэрээ байгуулж, мэдээлэл задруулахгүй байх үүрэг хүлээсэн болохыг бүү мартаарай. Танд ямар нэгэн ноцтой шалтгааны улмаас туслаагүйг санаж, огт сэжиг төрүүлэхгүй харилцан өөрийн чадлын хэрээр тэдний талаар нууцлаарай.

Ямарваа нэгэн мөрдөн шалгах ажиллагаанд тустай асуулт бол “Энэ мэдээлэл хэнд байгаа вэ?”. Мэдээлэл нь ихэвчлэн өөрийн гэсэн хэд хэдэн хаалгачтай байдаг. Хэрэв танд Эрүүл мэндийн яам баримт бичиг өгөхөөс татгалзсан бол Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, эрүүл мэндийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага, тэр салбарт ажиллаж байгаа их дээд сургуулийн судлаач, парламентын дэргэдэх Эрүүл мэндийн байнгын хорооны идэвхтэй

гишүүн зэрэг тус мэдээлэлд нэвтрэх боломжтой эрх мэдэл бүхий этгээд байж болно. Судлаачид нь ямар нэгэн хэрэг болохуйц мэдээлэлгүй байж болох ч хэн нь “хэн” болох, хэн чухал, хэн шийдвэр гаргадаг болохыг хэлж чадна.

Хаалга нээгчид гэдэгт нөлөө бүхий хүмүүсийг ойлгоно. Хэрэв тэдэнд та таалагдах, таны үйл хэрэгт итгэвэл үнэ цэнэтэй, тантай бусад хүн ярилцахыг шахах боломжтой. Хаалга нээгчид олны хүндлэл хүлээсэн төрийн алба хаагч, ахмад биш ч гэсэн байгууллагадаа эсвэл нийгмийн бүлэг дотор итгэл хүлээсэн хувь хүн байна. Тэд “Энэ сэтгүүлч зүгээр, түүнтэй ярилцаж болно” гэж хэлмэгц хүмүүс үгийг нь сонсож дагадаг. Та хэрэгтэй хүмүүсээ тодорхойлон, боломжтой үедээ тэдэнтэй харилцаа тогтоогоорой.



Давхар бодолтой нөхөд

Албан ёсны хэвлэлийн төлөөлөгч, лоббичдыг “давхар бодолтой нөхөд” гэдэг. Тэд ажил олгогчийн зүгээс хариуцсан ажлыг гүйцэтгэх, үйл явдал дээр хамгийн эерэг тайлбарыг “давхар” хийхээр хөлслөгдсөн байдаг. Давхар бодолтой нөхдийг таних тийм ч амар биш. Жишээлбэл сайдын албан ёсоор томилсон хэвлэлийн төлөөлөгч ил байдаг. Гэтэл ямар нэгэн үйл явдлыг эсвэл аль нэг талыг хөхиүлэн дэмжихээр нууцаар хөлслөгдөн сэтгүүлчдийн тухайд яах билээ? Нүднээс далд ажиллаж байгаа алба хаагч эсвэл арилжааны эх үүсвэрээс далдуур авсан мэдээлэл байвал яах бол? Ямар нэгэн бүтээгдэхүүнийг сурталчлахаар арилжааны компаниас хөлс авсан “мэргэжилтэн” ч юм уу? Сайтар шалгаагүй цахим хуудаст нэргүйгээр өгсөн материал байж ч мэднэ. Бидний тэр бүр мэдэхгүй “давхар бодолтой” нөхөд том, жижиг асуудалд оролцох нь ихэссээр байна. Жишээлбэл, АНУ-ын Засгийн газар Персийн булангийн талаарх олон нийтийн ойлголтыг “удирдан залах” зорилгоор арилжааны компанийг ашигласан ба уг байгууллагын удирдах албан тушаалтан өөрийгөө “мэдээллийн дайчин” хэмээн ам бардам нэрлэж байв.

Харин хуурамч мэдээнээс илүүтэйгээр танигдсан давхар бодолтой нөхрийн учрыг олоход амар. Та сайдын хэвлэлийн төлөөлөгч асуудлыг далдлах, амжилтыг тодруулах үүрэгтэй хөлсний ажилтан болохыг мэднэ. Худлаа хэлж байгааг багахан судалгааны үндсэн дээр хялбархан нотлох боломжтой учир ур чадваргүй нэгэн байдал удалгүй баригдана. Уулзахын өмнө урьдчилан судалж, сайн ярилцах техникийг хослуулснаар бултах боломжгүй, чулуу хөөлгөхөөс сэргийлж чадна. Та өөрийнхөө ажлыг хийдэгтэй адил хэвлэлийн төлөөлөгч ажлаа хийж байгааг санаарай.

Албан ёсны хэвлэлийн төлөөлөгч, засгийн газар, томоохон корпорациуд хүртэл өөрийн удирдлагын зорилгыг олны нүднээс далд бэхжүүлэх,

заримдаа бүр өөрсдийгөө дэмжүүлэхээр тагнуулын алба ажиллуулдаг. АНУ-ын Засгийн газар өөрийн тагнуулын албаар дамжуулан Садам Хуссейны “Үй олноор устгах зэвсэг”-ийн тухай зохиомлоор хэвлэл мэдээлэлд тарааж байсан ч хожим ийм үйл явдал болоогүй нь илэрсэн байна.

Болсон явдлыг зохиомлоор тараах нь тусгай албаны бүхэл бүтэн хэлтэс дангаар хариуцаж хэвлэл мэдээлэлд нөлөөлөхийг зорьдог өдөр тутмын ажил болсон байна. Тэд сэтгүүлчдийг байнга тагнаж, мөрдөн байцаагчаас юу мэдсэнийг олох, бүр өөртөө элсүүлэхийг оролддог (заримдаа, чаддаг гэвч). Мөн давхар бодол төрүүлэх зорилгоор сэтгүүлчдэд мэдээлэл цутгаж, сэтгүүлчдээр дамжуулан олон нийтийн санаа бодлыг эргүүлэхийг зорьдог болжээ. Хэдийгээр танд үндэслэлтэй сэдэл хэлж ирсэн хүн маш чухал мэдээлэлтэй хуурцаг, баримт бичиг өгч, танд “туслах”-ыг ихэд хүсэж байсан ч маш, бүр маш болгоомжтой хандаарай.

Африкийн эрэн сурвалжлах сурвалжлагчдын сүлжээний форумыг үндэслэгч Эвелин Гронинк Парис хотноо 1988 онд алуулсан Африкийн үндэсний конгрессын төлөөлөгч Дулсие Септемберийн талаар эрэн сурвалжилжээ. Энэ хэргийн үеэр Францын тусгай алба өөрийн гүйцэтгэсэн үүргээ илчлэхгүйн тулд сонинд гадны алуурчныг “дүрсэлсэн” худал тайлан маш ихээр тараасан юм. Гронинк бүр “хууртсан бизнес эр”-ийн Францын зэвсгийн наймаачинтай хийсэн “300 цагийн хуурцагт бичсэн яриа” байгаа гэж зарласан.

Түүний эх сурвалж нь луйвардуулсан хариугаа авахын тулд хэвлэл мэдээлэлд хандсан гэж хариулж байжээ. Гронинк их хэмжээний мөнгө, цаг, хяналтын камераар бичих боломж, онгоцны тийз, холбоо тогтоох сүлжээ зэргийн талаар асууж эхлэх үед “луйвардуулсан хохирогч” гардуулсан ба тэрхүү эх сурвалж Лондон руу өөрийн амьдарч, ажиллаж байсан, тодруулбал Английн Засгийн газар эсвэл Английн зэвсгийн үйлдвэр рүү буцсан хэмээн сэжиглэдэг байна.

Эрхий хурууны дүрмийн дагуу эх сурвалж таныг олохоос илүүтэйгээр та эх сурвалжаа олох нь ямагт илүү байдаг. Тантай харанхуй гудамжинд уулзахыг шаарддаг “нууц мэдээлэгч” этгээд чинь “Тэд намайг мөрдөж байна” гэсэн ганц үгээр уулзахдаа яагаад нуугдаж байгаагаа далдалдаг бол “тэдний” нэг байх нь дамжиггүй. Ялангуяа “халуухан” түүх бэлдэж байхдаа та өөртэй чинь ярих хүсэлгүй, хэлсэн нь зүйлс нууц, нэг бол нэрээ хэлэхээс цааргалсан олон эх сурвалжтай тулах болно. Та өөрийнхөө эх сурвалжийн талаар нарийн тодорхой мэдэхгүй бол тэднийг ямар төрлийн мэдээлэл хэлэхийг мэдэж чадахгүй. Хамгийн эрсдэлтэй эх сурвалж бол утасны цаанаас хоолойгоо нууцалсан нэгэн шүү. Вотергейт дээр нууц мэдээлэгч байсан ч гэсэн.

Эх сурвалжаа яаж хамгаалах вэ?

Эрэн сурвалжилсан бүтээл нь заримдаа эрсдэлтэй, ялангуяа улс төрийн асуудалтай улсуудад их ноцтой бөгөөд сэтгүүлчдийг баривчилж, тэдний амь насанд нь аюул учирч болно. “Нүднээс далд” л биш бол нягт нямбай, нууцаа хадгалж ажиллах нь чухал. Та бүтээлээ нийтэлснээс шалтгаалан учирч болох аюул занал, нийгэмд үзүүлэх үр өгөөж, олон нийтийн мэдээллийг ил болгох ашиг сонирхлыг өөрийн эх сурвалждаа сануулах үүрэг хүлээнэ. Та дээрх шалтгааныг аль аль талаас нь тайлбарласан хойноо таны бэлтгэсэн түүхэнд өөрийнхөө нэрийг дурдахыг эх сурвалж “мэдэж” зөвшөөрсөн гэж болно. Та эх сурвалжтайгаа утас эсвэл цахим шуудангаар дамжуулан түүхийнхээ талаар хэлэлцэх, уулзах эрсдэлийг ухаарсан эсэхийг нягтлаарай.

Таны яриаг чих дэлсэх, сонсох, хуулах (утасны дуудлага), эвдлэх (цахим шуудан) боломжтой газар эх сурвалжтай битгий ярилцаарай. Таны гар утасны дуудлага гэх мэтчилэн утасны бүртгэлийг тагнах, долгионоор хаана байгааг мөрдөхөд хялбар болохыг санаарай. Нууцаар уулзах гэж байгаа бол гар утсаа унтраан, зайгаа салгаарай. Эх сурвалж болон гуравдагч талтай холбоотой тэмдэглэл, бүртгэлээ аюулгүй газарт хадгалаарай. Ямар нэгэн хоёрдмол санаагүй, нээлттэй, өөрийгөө таниулсан гэрч бол аугаа нэгэн билээ. Эрх мэдэлтэй нэгний давхар бодол, худал хуурмаг, алдаа завхрал, гэмт үйлдлийн эсрэг тэмцэх цорын ганц үр дүнтэй арга зам юм.

Ийм хүнтэй учрахад танд цаг хэрэгтэй. Харин нэг нэгнийг ярь хэмээн хүчлэх эсвэл шууд яриаг нь бичиж болохгүй. Тэд эргэлзэх болсон шалтгааныг ухаж, тодруулан асуухаас эмээх хэрэггүй. Тодорхой асуулт бол “Таны нэрийг мэдсэнээр юу болох юм бэ?” Заримдаа хууль бус цагаач өөрийгөө харуулчихвал албадан гаргачих вий, төрийн ахмад алба хаагч ажлаас халагдах вий, шоронд орох вий, ХДХВ-ын халдвартай хүн нийгмээс халдлагад өртөх вий гэсэн хувийн айдас нь гол шалтгаан болох үе бий. Та ямар нэгэн мэдээлэл солилцохоос өмнө эх сурвалждаа түүний тухай бусдад мэдээлэл өгч магадгүй гэдгээ тайлбарлаарай. Та түүний тухай мэдээллийг хэрхэн нууцлах, байгаа байршил, хувийн мэдээлэл, одоогийн нөхцөл байдал, бүр хүйсийг нь хэрхэн дурдахаа ярилцаарай. Та тодорхой мэдээллийг нууцлах, дурдах гэсэн эх сурвалжийн шаардлагыг зөвшөөрч, эрхлэгч, хамтран ажиллаж байгаа хүмүүсдээ ойлгуулаарай. Эрхлэгч хүртэл эх сурвалжаа нэрлэхийг шаардаж магад. Та эрхлэгчийн өрөөнөөс цааш энэхүү мэдээлэл гарахгүй гэдгээ тодорхой болгоорой. Энэ бол сурвалжлагч, эх сурвалжийн хоорондын харилцааг илэрхийлэх цорын ганц маш чухал зарчим билээ. Хэрэв та хэн нэгний талаар мэдээлэл гаргахгүй гэж амласан бол шоронд орох байсан ч хэлсэн амлалтандаа хүрэх ёстой. Гэхдээ эх

сурвалждаа чадахгүй зүйлээ бүү амла. Эрүүгийн хэрэгтэн болсон эсвэл таалал төгссөн нэгний өмнө ёс суртахууны үүрэг хүлээхийн оронд нэрийг нь мэдэхгүй, нууц эх сурвалж ашигласан нь дээр.

Олон улс оронд эх сурвалжаа нэрлээгүйн улмаас эрүүгийн хэргийн хохирогч болсон сурвалжлагч, эрхлэгч байгааг мартаж болохгүй. Эдгээр улсад хэвлэл мэдээлэлтэй холбоотой асуудлыг иргэний эрх зүйн маргаан гэхээс илүү эрүүгийн гэмт хэрэг гэж үздэг учраас шүүхээс эх сурвалжийн талаар хэлэх шийдвэр гарч, татгалзсан тохиолдолд шүүхийг үл хүндэтгэсэн, саад болсон гэх үндэслэлээр шоронд ял эдэлдэг. Та эрэн сурвалжилга хийхээсээ урьтаж эх сурвалжаа хамгаалахад бэлдсэн эсэх, өөрийн нөөц боломжоо эргэн нягтлаарай.

Сем Сөл, Мейл энд Гуардиан, Йоханнесбург:

Сэтгүүлчээр ажиллахдаа туулсан миний хамгийн муухай туршлага бол эх сурвалжаа алуулах байсан. Надад зориулан тэрээр маш их мэдээлэл өгсөн ч нөхцөл байдлаа эргэн харахыг хүсээгүй. Тэр өөрийнхөө талаар мэдүүлэхийг хүсээгүй ч түүнтэй хамтран ажиллаж байсан хүмүүс түүнийг хэн болохыг мэдэх маш хялбар

байсан учир баригдсан. иймд магадгүй эх сурвалжаас авсан мэдээллийг бага багаар нийтлэх нь таныг намнах шалтаг болохгүй бөгөөд өөрийнхөө нэрийг ашигласнаар өөртөө эрсдэл дуудахгүй юм. Энэ бүхэн шүгэл үлээгчийн үйлдэл гэдэг нь аажимдаа харагдана. Энэ бол эх сурвалжаа хамгаалах нэг арга юм.

Эх сурвалжаа аюулаас хамгаалах нь та бэлдэж байгаа түүхдээ нэргүй эх сурвалж ашиглах олон шалтгааны нэг. Нэр нь үл мэдэгдэх эх сурвалж бол хянахад хүндрэлтэй, нарийн тодорхой илтгэх боломжгүй байдалд оруулж, уншигчдын эрэн сурвалжлах ажилд итгэх итгэлийг бууруулдаг. Тэд анхдагч, дотроос мэдээлэгчийн мэдлэг болон чухал мэдээллээр хангаж нэмэлт нотлох баримт руу чиглүүлдэг. Та бүтээл, эх сурвалж, эрэн сурвалжлах ажилдаа маш сайн анхаарал хандуулж эцсийн шийдвэрээ гаргаарай. Та эх сурвалжтай ярилцан түүнийг бүтээлдээ хэрхэн эшлэх, дурьдах зэргийг аль болох аюулгүй байдлаар тодорхойлоорой. “Ойн аж ахуйн яамтай ажиллаж байгаа хүрээлэн буй орчны судлаач” гэсэн нэр нь яамны хөлсөлсөн цор ганц өсудлаач биш тохиолдолд тохиромжтой.

Өөрийгөө хамгаалах нь

Сэтгүүлчийг хамгаалах хууль үйлчилдэг, нэг бол хуульгүй байх нь улс бүрт харилцан адилгүй боловч шүүхэд нотлох баримтыг хүлээн зөвшөөрдөг. Хууль мэдэх, учрах эрсдлээ ухаж ойлгох, түүний үр дүнг тооцох нь таны хариуцлагын асуудал.

Эх сурвалжтай хаана уулзахаа сайтар эргэцүүлэн шийдээрэй. Олны өмнө ил байсан нь дээр үү, эсвэл хувийн орчин байх уу? хүн хөлхсөн, дуу шуугиантай газар уу, далд, хүний хөлнөөс зайдуу юу? дүрс бичлэгээр тухайн газрыг хянаж байгаа эсэхийг нягтлаарай. Та хоёрын яриаг хүн сонсохоос айж байвал дуу чимээ ихтэй газар уулзаарай. Дуу чимээтэй газар бусад хүн таны юу хэлснийг сонсоход (нууцаар чагнах) хүндрэлтэй!

Дэвтэрт тэмдэглэх, компьютерт, авиан, дүрс бичлэгээр хадгалсан бүртгэлээ аль болох оновчтой бичих, шаардлагатай үед шууд үзэхийн тулд огноогоор ангилан хуваарилах хэрэгтэй. Эх сурвалжид шаардсан мэдээлэл байгаа эсэх маш тодорхой байвал тохирно. Эх сурвалж үнэндээ юу харсан, мэдэж байгаа, хэлж чадах, ямар сэдэлтэй, юу гэж ярих талаар туршиж, эх сурвалжийн яриаг салаа утгагүй бүтэн үгээр илэрхийлэх ба чадвал хуурцагт хуулаарай. Эх сурвалжаас асуусан төлбөр, төлсөн баримт зэрэг харилцсан бүх харилцаагаа тэмдэглээрэй. Бүтээл бичихэд зарцуулсан зардал төлбөрийн баримттайгаа нийцэх ёстой.

Та эх сурвалжтайгаа ил тод, шударга харилцаж байгаарай. Ямар нэгэн шалтгаанаар тэднийг хуурах, мэхлэх ёсгүй. Хүрч чадахгүй зүйлээ бүү амла, учрах боломжгүй үр дагаврыг бүү тооцоол. Та эх сурвалждаа татагдах, мэргэжлийн үүднээс шийдэж чадахгүй асуудалд битгий ороорой.

Та үнэнийг өгүүлж байгаа гэдгээ бүх үйлдлээрээ батлах ёстой. Эх сурвалжийн мэдээлэлд хүндэтгэлтэй хандахдаа шүүн тунгааж, мэргэжлийн үүднээс эргэлзэнгүй хандаарай. Эх сурвалжийн хувийн мэдээллийг давхар баталгаажуулан, хэлэхийг хүсээгүй мэдээлэлд эргэлзэнгүй хандаарай. Төвөгтэй асуулт асуугаарай. Эх сурвалжтай харилцахад ямар нэгэн ахицгүй, урьдаас төлөвлөөгүй асуудалд бэлтгэлтэй байж, юу буруу болсноо ямагт лавлаж байгаарай. Төгс гэрч гэж байхгүй тул хожим урьдчилан мэдэхгүй байсан эх сурвалжийн талаарх мэдээлэлд цочирдохгүй байхыг хүснэ. Эх сурвалжаа хамгаалахын тулд харилцан тохиролцсоноос хальж, бүтээлийн агуулгыг хянах эрх таны эх сурвалжид байхгүйг ойлгуулаарай.

Бичмэл мэдүүлэг

Өөрийгөө болон гэрчээ хамгаалах нэг хэлбэр нь хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн, гарын үсэг зурсан, гэрчийн мэдэгдэл буюу бичмэл мэдүүлэг болно. Нөлөөтэй хүмүүст аминч үзэл давамгайлах учир сэтгүүлчтэй харилцахдаа илүү бие даасан, захиран тушаасан зан байдал гаргадаг. Цаашилбал өөрийгөө эрсдэлд оруулах мэдээлэлтэй ирэхэд хүргэнэ. Энэхүү хууль зүйн баримт бичгийн дагуу хуудас бүрд хуульчийн хамт байлцан гарын үсэг зураарай. Үүнийг ихэнх улсын шүүх хүлээн авах бөгөөд эрх зүйн хувьд үр дүнтэй. Ийнхүү таны эх сурвалж шүүхэд ирэх, шаардлагатай тохиолдолд нотлох баримтаар хангахаа илэрхийлж байна. Мөн итгэл даах хуульчдад хадгалуулаарай. Хэрэв таны бүтээлд маргаан үүсвэл тус баталгаанд тулгуурлан шүүх хамгаалж чадна гэсэн нөхцөлд эх сурвалж өөрийгөө илчлэхээ илэрхийлэх юм. Тодруулбал, эх сурвалж хэлсэн үгнээсээ буцвал энэ нь таны хамгаалалт болно.




Заналхийлал, сүрдүүлэгтэй тэмцэх

Таны “буруутан” этгээд чинь маш хүчтэй, аюултай бол та дангаар нүүр тулахаас зайлсхийж, асуух асуултаа албан байдлаар илгээх боломжтой. Та түүний амьдарч буй газарт очихгүй байх, түүний холбоотнуудад өөрийн царайгаа мэдүүлэхгүй байх нь тустай. Хэдийгээр тус ярилцлага сайн болохгүй байж мэдэх ч бүтээлийг амьд болгоно. Бүтээлээ нийтлэхээсээ өмнө танай байгууллага таныг хэрхэн дэмжих, хамгаалахыг нягтлаарай. Хэрэв та ганцаар ажилладаг бол өөрийгөө дэмжих байгууллагатай холбогдох боломжтой.

Маш ноцтой асуудлаар эрх мэдэлтэй хүн, эсвэл байгууллагаас асуулт асуух нь хуулийн болон бие махбодын аюул занал учруулж болзошгүй. Энэ нь эрхлэгчийн зүгээс сэдвийг орхиход хүргэж магадгүй. Харин таны бүтээл баттай бол дайралтанд өртмөгцөө бусдыг гутаах байдлаар эрхлэгчээ аашлуулахгүйн тулд сэнхрүүлэх хэрэгтэй. Нэгдүгээрт, тэд муу нэртэй болж шүүхэд заргаа алдаж магадгүй (жишээлбэл, зэвсгийн худалдаанд оролцсон компаниудад хамаарна), хоёрдугаарт шүүхэд ирүүлсэн хэргийг шийдвэрлэхдээ тэдний зүгээс далдлахыг хүссэн нотлох баримтыг сэтгүүлчийн зүгээс дахин хэвлэх эрхтэйгээр ил болгоно. Хэрэв таныг сүрдүүлж, мөшгөж, эсвэл ямар нэгэн байдлаар заналхийлж байгаа хүнтэй нүүр тулбал Сэтгүүлчдийг хамгаалах хороо, Хил хязгааргүй сурвалжлагчид зэрэг байгууллагаас туслалцаа хүсээрэй.

Сонгон авсан эх сурвалжаа үнэлж, тухайн хүнд тулгарах аюул заналыг тооцоолсон учраас ярилцлага хийх цаг иржээ. Дараагийн бүлгээс хэрхэн асуултаа төлөвлөх, ярилцлагын үеэр биеэ хэрхэн авч явах, ярилцлага амжилттай хийх дүрмийн талаар мэдэж авна.



ДОЛООДУГААР БҮЛЭГ

ОНОВЧТОЙ АСУУЛТ АСУУХ НЬ

Ярилцлага бол (эрэн сурвалжлах ч бай, өөр төрлийнх ч бай) сэтгүүл зүйн үндсэн элементүүдийг агуулдаг. Гэвч эрэн сурвалжлах ярилцлагын хувьд илүү их бэлтгэсэн, сэдвээ (түүхээ) ухаж ойлгосон, өөрийн эх сурвалжаар дамжуулан судалгаа хийчихсэн байх ёстой. Ингэснээр оновчтой асуулт асууж чадна. Эрэн сурвалжлах сэтгүүл зүй нь эмзэг мэдрэмтгий, зөрчил маргаантай бөгөөд заримдаа хэн нэгний нэр хүндийг ч сэвтүүлэх аюултай. Тийм ч учраас ярилцлага хийх ур чадвараа хурцалж, ямар төрлийн асуултыг хэрхэн, хэзээ асуухаа бэлтгэх нь хамгаас чухал. Ярилцлага хийх үедээ ёс зүйн хэм хэмжээг ч анхаарах шаардлагатай.

Ярилцлага Хийхээсээ Өмнө Өөрийгөө Хэрхэн Бэлтгэх Вэ?

Ярилцлага нь харилцааны бусад төрлийн адил хоёр талт үйл ажиллагаа юм. Үр дүн нь ярилцлага өгч байгаа хүнээс гадна өөрөөс тань мөн маш их хамаарна. Сайн ярилцлага энгийн харилцан яриа шиг мэдрэмж төрүүлдэг. Төлөвлөсөн стратегийнхаа дагуу хэлж, хийж байгаа бүхэн чинь танд хэрэгтэй хариултаа авахад туслах болно.

Ярилцлагаас өмнө сэдвээ сайтар судалж, эх сурвалжаа тухайн сэдэвтэй ямар холбоотойг тодорхойлох нь зүйтэй. Оновчтой асуулт тавьж, дэлгэрэнгүй тайлбар авахын тулд шаардлагатай бүх баримт, мэдээллийг судлах хэрэгтэй. Асуудал хаана байгааг тодорхойлж, янз бүрийн хүнтэй ярилцлага хийхээр төлөвлөөрэй. Эс бөгөөс цөөн хүн, эх сурвалжаас хамааралтай болж, гол үйл явдлаасаа хөндийрөх эрсдэл тулгарна. Жишээлбэл, ажилчдаа дээрэлхэж зовоодог ажил олгогчийн талаар илүү мэдээлэл авахын тулд та албадан хөөгдсөн фермийн ажилчид, үйлдвэрийн ажилчдын байгаа газар нь очих ёстой. Харин хотод байрлах ТББ-аас та ийм “хоол” олж чадахгүй л болов уу. Газар дээр нь очиж цуглуулсан мэдээллээ сэдвийнхээ хүрээнд судалсан баримт бичгүүд, зорилго, төсөвтэйгөө уялдуулахын тулд “Data mapping” буюу мэдэлийн зураглалын арга ашиглаарай. Ингээд цуглуулсан мэдээллээ ижил төстэй газар, эсвэл бүр түүхийн өөр цаг хугацаанд болсон үйл явдалтай харьцуулж үзээрэй. Ийм ахисан түвшний бэлтгэл хийснээр та оновчтой асуулт асууж, шаардлагатай мэдээллээ олж авч чадна.

Хүмүүсийг яриулах

Сэдвийнхээ зорилго, нөхцлөөс хамааран та өөрийн гэсэн ярих түүхтэй хэн нэгэнтэй “алхаж ороод” шууд уулзах (хүмүүс ихэнхдээ үүнийг бүдүүлэг гэж боддог л доо), эсвэл “утсаар ярих” боломжтой байх хэрэгтэй. Хэрвээ ярилцах шаардлагатай эх сурвалж тань ямар ч боломж олгохгүй байвал та “харуулдах” арга ашиглаад үзээрэй. Тухайн хүнийхээ ажилладаг албан газрын хүлээлгийн танхим, үүдээр эргэлдэх, эсвэл тэр хүн очих олон нийтийн арга хэмжээнд оролцох мэтийн аргыг хэлж байгаа юм. Гэхдээ энэ нь муу үр дагавартай байж мэдэх бөгөөд та тухайн эх сурвалжаа “отож” байгаагаа илчлэх бүдүүлэг авир гаргаж болохгүй. Өөрийгөө эелдгээр танилцуулж, ярилцах боломж эрэлхийлж байгаагаа эвтэйхэн ойлгуулах хэрэгтэй. Хэрэв эх сурвалж таныг хардаж, сэрдээд халгаахгүй байвал түүний танилуудаар дамжуулан харьцах арга хэрэглэж ч болно. Аливаа нэгэн компани, байгууллага, төрийн албан хаагч, албан тушаалтантай ярилцлага хийх хүсэлтээ албан ёсоор, ихэвчлэн

тухайн байгууллагын хэвлэл мэдээллийн албаар дамжуулан илэрхийлэх шаардлагатай байдаг. Ямар ч тохиолдолд эелдэг байхаа мартуузай.

Хэн нэгэнтэй уулзах, эсвэл утсаар холбогдохоосоо өмнө сэдвийнхээ гол агуулга, өнцгийг багтаасан богино хэмжээний танилцуулга үг бэлтгэх нь үр дүнтэй байдаг. Ингэхдээ өөрийгөө сэтгүүлч гэдгээ хэдийд илчлэхээ сайтар бодох хэрэгтэй. Ямар тохиолдолд өөрийнхөө мэргэжлийг нууцалж, өөр ажил эрхэлдэг (худалдааны төлөөлөгч г.м.) мэт жүжиглэх хэрэгтэй вэ? Тухайн “дүр”-ээ хэрхэн үнэмшилтэй харагдуулж, итгүүлэх вэ?

Энгийн уулзалтын дараа тухайн хүнээ ирээдүйд холбоо тогтоох эх сурвалж болгохын тулд хичээх хэрэгтэй. Ярилцах асуудлуудаа жагсаалт хэлбэрээр бичиж, төлөвлөгөө гарга. Эх сурвалжийн сонирхлыг яг юу татах бол? Тухайн хүнээ энэ талаар яриулахын тулд хэрхэн “өдөөх” вэ? Төрийн албан хаагч болон баарны үйлчлэгч хоёртой уулзах арга барил тань өөр байх уу? Хэрэв тийм бол юугаараа өөр байх вэ? Өдөр тутам нэгэн хэвийн ажил хийж байгаа хүмүүсийн оюуны чадамжийг битгий л дутуу үнэлээрэй! Мөн зарцуулах цагаа маш тодорхой, бодитойгоор төлөвлө. Тухайлбал, засгийн газрын гишүүний хувьд 15 минут ч урт хугацаа байх бол гэмтэж бэртсэн хүн өөрийгөө нээж ярихын тулд таны бүтэн өдрийн цагийг авч ч мэднэ.

Хэрвээ эх сурвалж чинь асуултуудаа урьдчилаад явуулахыг хүсвэл хэлснээр нь хийсэн нь дээр болов уу. Гэхдээ энэ нь ерөнхийдөө тийм ч сайн туршлага биш. Ярилцлагын үеэр хөндөж болох сэдвүүдийн ерөнхий тоймыг л явуулахыг бодоорой. Учир нь, асуултуудаа урьдчилж явуулснаар ярилцлага хиймэл, “модон” болох тал бий. Гэвч заримдаа, тухайлбал мэргэжилтнүүдээс тухайн сэдвээр илүү өндөр түвшний мэдээлэл авахын тулд асуултуудаа урьдчилан явуулж, тэдэнд бэлтгэх цаг, боломж өгөх хэрэг гардаг. Ямар ч байсан илүү нарийн, дэлгэрэнгүй мэдээлэл авахын тулд ярилцлагынхаа дундуур нэмэлт асуулт асуух эрхээ үргэлж хадгалж байгаарай.

Эх сурвалж тантай уулзахаас татгалзах боловч мэдэгдэл гаргаж өгөх тохиолдол бий. Үүнийг бүтээлдээ хэрхэн эвтэйхэн тусгах арга замуудын талаар эрхлэгчтэйгээ зөвлөлдөх хэрэгтэй. Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн төв ВВС-гийн томъёоллыг санал болгодог: “Бид ярилцлага хийх хүсэлт тавьсан боловч хэн нь ч боломжгүй байв, тэгээд дараах албан бичгийг ирүүлсэн” гэж тэмдэглээд албан бичгийг бүхлээр нь хавсаргадаг байна.

Хэрвээ эх сурвалж чамтай ярилцахыг хүсч байвал газраа зөв сонгоорой. Тухайн хүний гэр эсвэл ажлын байр нь тэдний “хөрс” учраас сэтгэлзүйн хувьд тав тухтай байх давуу талыг олгодог. Ингэснээр тэд илүү чөлөөтэй байж, таны хувьд тэднийг орчин нөхцөлтэй нь хамт харах нөхцөл бүрдэнэ. Танай ажлын байр таны сэтгэлзүйн хувьд илүү тухтай байж болох ч тэдний хувьд аюулгүй байдал нь хангагдаагүй мэт сэтгэгдэл төрүүлэх тал бий.

Ярилцлага ямар байвал зүгээр вэ гэдгээ тодорхойлж, олон нийтийн газар байх уу, эсвэл нууцлагдмал газар байх уу гэдгийг сонгох шаардлагатай. Ямар орчин нөхцөл үүсгэмээр байна, эргэн тойронд чинь ямар төрлийн чимээ шуугиан байвал тохиромжтой байна гэх зэргийг харж, тухайн чимээ харилцан яриа бичиж авахад саад учруулах эсэхийг мөн бодолцоорой.

Албан ёсны уулзалтын хувьд нарийн мэдээллүүдээ утсаар өгөх, и-мэйлээр явуулах, факсдах зэргээр өгчихсөн байвал дараа нь ярилцагч тань “мартчихсан” гэж шалтаг тоочихгүй байх болно. “Танд эргээд мэдэгдье” гэдэг нарийн бичгүүдэд итгээд хэрэггүй. Хариу өгөх хангалттай хугацаа хүмүүст өг, тэгээд дахин залга. Шаргуу бай. Гэхдээ яршигтай биш.

Асуултуудаа урьдчилан төлөвлөх

Ярилцлага чинь ихэнх талаараа бүтэлгүйтсэн ч өөрт шаардлагатай зарим мэдээллээ олж авах хэмжээний бүтэцтэй ярилцлага зохион байгуулаарай.

1. Халаалт (амьд харилцаа эсвэл тааламжтай сэтгэгдэл төрүүлэх)
2. Хүлээн зөвшөөрөгдсөн баримтуудыг агуулсан суурь мэдээлэл өгөх
3. “Зөөлөн” асуултууд
4. “Хатуу” асуултууд

1
Бүтэц



2

Эхний үе
шат

Эх сурвалж чинь хэдий хугацааны дараа өөрийгөө нээж, ярихад бэлэн болохыг тооцоол. Ярилцлагынхаа эхний үе шат буюу халаалтыг аль болох богино бөгөөд хөнгөн байлгахыг хичээж, аль болох хурдан гол асуудал руугаа орохыг зориорой. Ингэхдээ хүндэтгэлтэй, эелдэг байдлаа хадгалах нь чухал. –Ярилцлагынхаа логик дарааллыг сайн бодолцож, эхний хэсэгт өөрт хэрэгтэй байгаа мэдээллээ ойлгуулж, дараа нь илүү хүнд асуултуудаа асуухаар төлөвлөх хэрэгтэй. Асуултууд тань ойлгоход хялбар, тодорхой бөгөөд оновчтой байх ёстой.

Толгойг нь эргүүлж төөрөгдүүлэм эмх замбараагүй нэг урт асуулт асууснаас товч, тодорхой, нэг нь нөгөөгөөсөө улбаалсан хэсэг бүлэг асуулт илүү дээр. Тэдгээр асуултаа урьдчилан бэлтгээрэй.

Олон утга бүхий хэд хэдэн асуулт нэг дор тавихаас зайлсхий. “Сайд аа, та тендерийн хууль бус үйл ажиллагааг мэдэж байсан уу? Та үйл явцад нь хяналт тавьсан уу? Яагаад ийм зүйл болов?” гэж асуувал нэгнийх нь л хариултыг авна. Ерөнхийдөө эх сурвалж чинь алинд нь хариулмаар байна, тэрэндээ л хариулна гэсэн үг.

Нэг өгүүлбэрт үгүйсгэсэн утгатай үг давхардуулан оруулахаас татгалз. Эс бөгөөс ойлгомжгүй байдал бий болно. Жишээлбэл:

“Та мөнгөө төлөөгүй гэдэг нь үнэн биш гэж үү?”

Ийм асуултын хувьд мөнгө төлсөн, эсэх тухай, эсвэл мэдэгдлийн үнэн худлын тухай хариултын аль нь байж болно. “Та мөнгө төлөөгүй гэдэг нь үнэн үү?” гэвэл илүү ойлгомжтой, энгийн болно.

“Та мөнгөө төлсөн үү?” гэвэл бүр ч илүү асуулт болно.

3

Үгүйсгэсэн
утгатай үг

4

Суурь

Бататгах асуултууд оруулах хэрэгтэй. Та хариултыг нь хэдийнэ мэдэж байгаа асуултууд гэсэн үг. Эдгээр асуулт ярилцлагын суурийг бий болгож, танд эх сурвалжаа илүү ойлгох боломж олгоно. Хэрвээ эх сурвалж чинь асуултууд хэт энгийн байгаад гайхширвал хүнд хэцүү асуултаар довтлох хэрэггүй. Харин “Уншигчдад энэ бүхний тухай миний биш, таны юу гэж бодож, ярьж байгаа нь чухал шүү дээ” гэх мэтээр тайлбарлаж болох юм.

Хаалттай асуулт (тийм/үгүй, эсвэл нэг үгээр хариулж болох асуулт) болон нээлттэй асуулт (ярилцагч өөрийнхөө санааг дэлгэрүүлэн тайлбарлах боломжтой) хоёрын ялгааг сайн ойлгох хэрэгтэй. Хаалттай болон нээлттэй асуултыг хольж, хаалттай асуултыг зөвхөн тулгаж асуухдаа л ашиглаарай.

5

Нээлттэй vs.
Хаалттай

Тоног төхөөрөмж

Ярилцлага хийхээсээ өмнө ашиглах төхөөрөмжөө бүгдийг нь шалгаарай. Дуу хураах, гараар тэмдэглэх хэрэгслүүд чинь ажиллаж байгаа эсэхийг заавал шалгаж хэвшээрэй. Мөн үзэг, дуу хураагуур, зай, SD карт гэх мэт зүйлсээсээ нэг илүүг байнга авч яваарай. Хэрвээ хэлсэн үгийг нь хэвлэн нийтлэх зөвшөөрөл эх сурвалжаасаа авах шаардлагатай бол гарын үсэг зуруулах баримт бичгээ авахаа мартуузай. Олон нийтэд зөвхөн нэг хэсгийг нь хүргэх урт хэмжээний ярилцлагын үед ийм зөвшөөрөл илүү хэрэгтэй байдаг. Харин компани, эсвэл улс төрийн байгууллагын хэвлэлийн төлөөлөгчөөс хэвлэн нийтлэх зөвшөөрөл авах шаардлагагүй. Учир нь, тэдний ажлын байрны тодорхойлолтын дагуу ярилцлага өгөхийг зөвшөөрсөн л бол түүний хэлснийг хэрхэн ашиглах нь сэтгүүлчээс л шалтгаална. Гэхдээ хэвлэлийн төлөөлөгчдийн ярьсан, хэлснийг гуйвуулах байдлаар олон нийтэд хүргэвэл тэд гомдоллох эрхтэй гэдгийг санаарай.

Ярилцлагын Үеэр Биеэ Хэрхэн Авч Явах Вэ?

Сэтгүүлчид ихэвчлэн өөрсдийн ажилладаг “муу хэвлэл”-ээс болж зовлонд унадаг. Тэд хэрэгт дурлаж, шуугиан дэгдээдэг, сөрөг хүчний талд ажилладаг хүмүүсийн нэр хүндийг унагадаг, ажлаа хийж байгаа хүмүүст саад учруулдаг, хүндлэл мэддэггүй гэх мэт муугаар хэлүүлдэг. Ийм зэмлэлүүдийн зарим нь үнэхээр үндэслэлтэй байдаг юм. Сөрөг сэтгэгдэл төрүүлэхгүйн тулд боловсон, ёс зүйтэй байхад л хангалттай. Бусдад бүдүүлэг хандаж, боломжгүй зүйл шаардаж болохгүй. “Би чам руу өдөр шөнө хамаагүй хүссэн үедээ залгах эрхтэй, харин чи надад миний хүссэнийг хэлж өгөх ёстой” гэсэн шиг аашлаад байвал та мэдээж өөртөө дайсан л бэлдэнэ.

Ихэнх хүн өөрийгөө эелдэг, шударга гэж бодох дуртай. Тэгвэл эх сурвалжтайгаа ийм харилцаа үүсгэхээс эхэлж яагаад болохгүй гэж? “Энэ яаж ажилладаг тухай надад тайлбарлаад өгөөч”, эсвэл “Та нийгмийн сайн сайхны төлөө энэ асуудлыг тайлбарлаж өгч тусална уу?”, эсвэл “Агаарын бохирдол хүүхдүүдийн амь насанд аюул учруулаад байна. Та надтай энэ тал дээр хамтран ажиллахгүй биз?” зэргээр эх сурвалждаа хандаж, асуух нь үр дүн өгдөг. Тухайн мэдээллийг хуваалцах нь олон нийтийн эрх ашиг, сайн сайхны төлөө гэдгийг л ойлгуулж чадвал ихэнх эх сурвалж сэтгүүлчдэд туслахад бэлэн байдаг.

Энэ нь зөвхөн стратегийн асуудал ч биш юм: “Дөрөв дэх засаглал” мэтийн нүсэр нэрээр бид өөрсдийгөө цоллодог боловч үнэндээ нэг ч сэтгүүлч улс төрчдийн үйл ажиллагааг хянахын тулд ардчилсан сонгуулиар сонгогдож байгаагүй. Сэтгүүлчид бол иргэний нийгмийн нэг хэсэг, тийм ч учраас засгийн газар ард түмэндээ үйлчилж байгаа, эсэхийг хянах үүргийг хуваалцдаг. Энэ үүргийнхээ хүрээнд сэтгүүлчид сонин, хэвлэл, телевиз гэх зэрэг олон нийттэй харилцах байгууллага руу нэвтрэх давуу эрхтэй байж бусдыг төлөөлдөг. Ялангуяа увайгүй байгууллагууд, авлигач улс төрчдийн буруу үйлдлийг илрүүлэхийн тулд нууц бичлэг хийх зэрэг хууль бус арга хэрэглэх гэж байгаа бол хүмүүстэй эвтэйхэн харьцаж, шударга, ил тод (ядахдаа аль болох ил тод) арга барил ашиглах нь зүйтэй.

Сэтгүүлчийн үүргээсээ хэтэрсэн үйлдэл гаргахгүйн тулд дараах асуултыг өөртөө тавьж байгаарай:

- ? Би өөрөө эрэн сурвалжлагдаж буй хүн нь байсан бол яах вэ? Би дэлхий ертөнцийг яаж харж, сэтгүүлчдийн үүргийг юу гэж бодох байсан бол?
- ? Би хэр найдвартай хүн бэ?
- ? Би бусдыг эрэн сурвалжилж байгаа шиг өөрт тийм зүйл тохиолдвол тэсвэрлэхийн аргагүй болох уу? Намайг юу зогсоох вэ?
- ? Миний хийх ёстой зүйлс болон ёсгүй зүйлс, тэнцвэр нь яг хаана байх вэ?



Ярилцлага хийх үндсэн дүрэм

Дүрэм 1

Цагаа барь

Хэрвээ чи хоцорч ирвэл эх сурвалжаа өөрөөсөө хөндийрүүлээд зогсохгүй цаг алдана, уучлалт гуйж мөн л цаг алдана. Тэгээд ярилцлагынхаа эхэн хэсгийг амьсгаадаж, анхаарлаа ч төвлөрүүлж чадахгүй өнгөрөөх магадлалтай.

Дүрэм 2

Зохимжтой хувцасла

Хувцсаа тохируулж өмсөх нь энгийн мэт боловч ярилцагчдаа анхны сэтгэгдлээр эвгүй ойлголт төрүүлэхгүй байх нь чухал. Сэдвийнхээ утга агуулгад нийцсэн хувцас өмсөхөөс гадна, тухайн хувцаслалт чинь зочноо хүндэтгэсэн, мөн таны амьдралын хэв маягийн талаар илтгэхээргүй энгийн байх хэрэгтэй.

Дүрэм 3

Хаана суухаа шийд

Шаардлагатай бол өөрийн ашиглах дуу хураагуур зэргээрээ далимдуулан суудлаа сонгож болно (“Энд суувал дууг чинь илүү сайн бичих байх” гэх мэтээр). Ярилцагчийнхаа нүд рүү харах боломжтой байрлалд суухыг зөвлөө. Гэхдээ эгц өөдөөс нь харж суух нь хэтэрхий нүүр тулсан байрлал тул тохиромжгүй. Ерөнхийдөө эсрэг талд нь, гэвч ярилцагчтайгаа бага зэргийн ташуу өнцгөөр суух хэрэгтэй. Ярилцагч та хоёрын хооронд өрж тавьсан ном, дэлгэсэн компьютер зэрэг анхаарал сарниулж, саад болох зүйлс байх ёсгүй. Зөөлөн буйдан дээр суувал юм бичихэд ч хэцүүгээс гадна тав тух нь нозооруулах эрсдэлтэй.

Дүрэм 4

Тохиромжтой үед харцаараа харилцах

Ярилцаж байгаа хүнийхээ нүүрний хувирлыг ажиглаж байвал илүү сайн харилцан яриа үүсдэг. Тэмдэглэл хөтөлж байгаа тохиолдолд ингэх нь хэцүү боловч үе үе, ялангуяа асуулт асуухдаа нүд рүү нь харж байгаарай. Асуултаа зүгээр л тэмдэглэлээсээ уншаад байвал нөгөө хүн чинь таныг ярилцлага хийж сураагүй шинэ сэтгүүлч, өөртөө итгэлгүй нэгэн байна гэж бодно. Эсвэл бүр өөрийнх нь хэлж, ярьж байгааг огт анхаарахгүй байна гэж ойлгож мэдэх юм. Энэ нь нэг талаараа бүдүүлэг зан авир бөгөөд нөгөө хүнийхээ чамтай ярилцах хүслийг унтраана.

Дүрэм 5

Биеийн хэлэмжийг анхааралтай ажигла

Өөрийнхөө болон ярьж байгаа хүнийхээ биеийн хэлэмжийг анхаараарай. Хамгаалалтын дохио зангаа, үйл хөдлөл нь булзайруулалт, заль мэхийг илтгэх бөгөөд энэ үед нь хүндхэн асуулт асуух нь тохиромжтой. Мөн аль үед эх сурвалж чинь хэцүүхэн байдалд орж байна, санаа амарч байна, инээж байна, уурлаж байна, уйдаж байна зэргийг тэдний үйл хөдлөлөөс л ажиглах боломжтой.

Дүрэм 6

Олон нийтэд цацах, эсэх

“On-the-record” гэвэл та эх сурвалжийн ярьсан бүх мэдээллийг ашиглаж, нийтэлж болно гэсэн үг. Харин “Off-the-record” гэвэл та тухайн мэдээллийг эх сурвалжийн нэрийг нууцалсан байдлаар л нийтэлж болохыг хэлнэ. “Background only” гэдэг нь эх сурвалжийн өгсөн мэдээллийг огт нийтлэхгүй, зөвхөн тухайн сэдвээ ойлгохын тулд хувьдаа л ашиглана гэсэн үг. Энэхүү олон нийтэд цацах, эсэх тухай ойлголт нь хууль эрх зүйн хүрээнд шийдэгдэх зүйл биш боловч эх сурвалж, сэтгүүлч хоёрын харилцан ойлголцлын нэгэн хэлбэр юм. Эх сурвалжтай ярилцахдаа л түүний өгсөн мэдээллийг нийтлэх, эсэх, хэдийд хэрхэн ашиглахаа тохиролцох нь зүйтэй. Ялангуяа эмзэг сэдвийн талаар олон нийтэд мэдээлэх гэж байгаа бол мэдээлж болно гэсэн зөвшөөрөлтэй эсэхээ дахин нягтлаарай. Хэрвээ ярилцлага чинь албан бус бол тэмдэглэл хөтөлж, дуу хураахаа түр зогсоогоод: “Би энэ талаар бичиж тэмдэглэж, дуу дүрсийг нь хурааж болох уу?” гэж асуугаарай. Харин ярилцлага чинь албан ёсных бол ингэж цаг алдалгүй хурдан шуурхай, үр дүнтэй ажилласан нь дээр. Тэмдэглэл хөтөлж, дуу хураах нь зарим эх сурвалжийг үргээх магадлалтайг анхаараарай. Дуу хураах төхөөрөмжөө нууж хаах хэрэггүй боловч ажиллуулахдаа аль болох эх сурвалждаа саад болж, залхаахааргүй байгаарай. Хэрвээ тэд сандарч, тэвдээд байвал “Ингэж бичиж авснаар би таны хариултуудыг үнэн зөв буулгаж чадна шүү дээ” гэж тайлбарлахад л болно.

Дүрэм 7

Үргэлж тэмдэглэл хөтөл

Тэмдэглэл хөтлөх нь чиний анхаарлыг төвлөрүүлэхээс гадна дуу хураах төхөрөөмжийн тэмдэглэж чадахгүй илэрхийлэл, сэтгэл хөдлөл, дохио зангаа зэргийг буулгадаг давуу талтай. Мөн дуу хураагуур чинь ямар нэг байдлаар ажиллаагүй тохиолдолд тэмдэглэлаа ашиглах боломжтой. Маш цэгцтэй, нямбай тэмдэглэл бичээрэй. Ингэхдээ эх сурвалжийнхаа эшлэлээс эхлээд өөрийн ажиглалт, дүн шинжилгээг тусгасан ч болно.

Дүрэм 8

Төвийг сахисан, нээлттэй асуулт асуух

Сэтгэл зүйч нараас суралцах хэрэгтэй. Асуултдаа өөрийн сэтгэл хөдлөлийг оруулахаас болгоомжил. Жишээлбэл: “Энэ нь эрх мэдлээ буруугаар ашиглах аймшигт хэрэг биш гэж үү?” гэхийн оронд “Ингэж эрх мэдлээ буруугаар ашиглаж байгааг та юу гэж бодож байна?” гэсэн нь дээр. Ингэснээр та эх сурвалжийнхаа сэдлийг ойлгож чадах юм. Гэвч араас нь шууд “Яагаад?” гэж асуувал тухайн хүнээ зэмлэсэн, эсвэл сэжиглэж байгаа мэт сэтгэгдэл төрүүлж болох юм. Тиймээс “Яагаад?” гэсэн асуултыг шууд бусаар асуу. “Яагаад энэ хэвлэлийн мэдээнээс болоод та уурлаад байгаа юм бэ?” гэхийн оронд “Хэвлэлийн мэдээ таны уурыг хүргэсэн гэсэн. Та энэ тухайгаа илүү дэлгэрэнгүй ярьж өгөөч?” гэж асуугаарай.

Дүрэм 9

Чимээгүй байх нь тийм ч муу зүйл биш

Эх сурвалж таны асуултад хариулж дуусахаар дараагийн асуулт руу орохоосоо өмнө түр амсхийх нь зүгээр байдаг. Харилцан ярианы дундах тэр хоосон орон зайг чи нөхөх гээд байх шаардлагагүй. Хэрвээ нөгөө хүнд чинь хариулахад бодох хугацаа хэрэгтэй байвал түүнийг нь өг. Тэдэнд сэтгэл хөдлөлөө дарах хугацаа хэрэгтэй байвал “За одоо үргэлжлүүлэх үү?” гэж хэлэхээсээ өмнө хүлээх хэрэгтэй.

Дүрэм 10

Сонирхож буй мэт харагд, сонирхоод үз

Ярилцлагын үеэр эх сурвалжаа анхааралтай сонсож байгаа гэдгээ илэрхийлэх үйлдлүүд хий. Хариултыг нь тэмдэглэж авах, эргээд түүнийгээ ашиглан нэмэлт асуулт тавих зэргээр байнгын идэвхитэй байх хэрэгтэй. “Энэ миний хүссэн хариулт мөн үү? Би үүнийг ойлгож байна уу? Үүнийг хэрхэн ашиглах билээ?” зэрэг асуултыг өөртөө тавь. Ярилцлага дууссан л бол эргээд нөгөө хүнтэйгээ уулзахад маш хэцүү байж болно шүү дээ. Та судалгаагаа хийсэн боловч эх сурвалж таны хүлээж байсан шиг хариулт өгөхгүй бол сандарч, сэтгэлээр унаж, сэдвээ өөрчлөх гэсний хэрэггүй. Ямар ч байсан үргэлжлүүлээд ярилц. Түүний шинэлэг төлөв байдалтай зохицон ярилцаж, хариултнаас нь ургуулан нэмэлт асуултууд тавиарай. Урьдчилан төлөвлөсөн сэдэв рүүгээ эх сурвалжаа “чихэж оруулах” гэсний хэрэггүй. Гэнэтийн зүйл эцэстээ бүтээлийг чинь илүү сайжруулж ч мэдэх юм. Тэгдэггүй юм аа гэхэд та үндсэн сэдэв рүүгээ дараа нь эргээд орж болно. Эх сурвалж чинь бүдүүлэг аашилж, таны хүссэн шиг ярилцлага хийхгүй байсан ч түүнтэй түрэмгий, зандрангуй харьцахгүй байх нь чухал.

Дүрэм 11

Цагаа зөв хуваарил

Цагаа тогтмол харж, асуултаа цагтаа багтаан хуваарилах хэрэгтэй. Мөн эх сурвалжтайгаа тохиролцсон цаг чинь дуусах үед ярилцлагаа үргэлжлүүлмээр байвал “Бидэнд дахиад хэдэн асуултын хүрээнд ярилцах цаг байгаа юу?” гэж асуугаарай. Ярилцлагаа хийчихээд “Таны өгсөн мэдээллийг ашиглан бичих нийтлэл пүрэв гарагийн дугаарт гарна” гэх зэргээр дараа нь юу болох тухай эх сурвалждаа мэдэгдээрэй. Гэвч нийтлэгдэхээс нь өмнө бүтээлээ уншуулах мэтийн биелүүлж чадахааргүй амлалт өгөөд хэрэггүй шүү.

Дүрэм 12

Түүхийг яг байгаагаар нь өгүүл

Сайн сэтгүүлчид эх сурвалжийнхаа өгсөн мэдээллийг үнэн зөвөөр л ашигладаг. Мэдээж хэрэг ярилцлагын үеэр хэлсэн зүйлийг худлаа нийтэлж болохгүй. Мөн асуулт, хариултын мөн чанарыг алдагдуулж, эшлэлийг нь ялган авахдаа эх сурвалжийнхаа хэлсэн санааг гажуудуулж болохгүй. Ялангуяа ярилцлагын эх хувилбарт дурдагдсан хариултуудаас өөрийн бүтээлдээ сонгож авч ашиглахдаа болгоомжтой, няхуур байх хэрэгтэй. Өгүүлбэрүүдийн бүтцийг өөрчилж, найруулах явцад утга санаа нь гажуудах эрсдэл бий. Түүхээ өгүүл, тэгэхдээ түүнд хамааралтай хүмүүсийн хариултыг тусга. Уншигчид чинь ухаалаг учраас үнэн хаана оршиж байгааг мэдэх л болно.

Эрэн Сурвалжлах Сэтгүүл Зүйн Ярилцлага Юугаараа Өөр Вэ?

Ямар ч ярилцлагын хувьд төлөвлөх, бэлтгэх, мэдээлэлд суурилсан уян хатан асуулт асуух нь чухал. Гэхдээ эрэн сурвалжлах сэтгүүл зүй нь таниас илүү ур чадвар шаардах бөгөөд арай өөр арга замаар мэдээлэл олж авдгаараа онцлог. Тэр “өөр” хэмээн нэрлэж байгаа зүйлсийн нэг нь цаг төлөвлөлт юм. Зөвхөн хэн хэнтэй ярилцлага хийх вэ гэдгээс гадна эрэн сурвалжилгынхаа яг аль үе шатанд, хэдийд тэдэнтэй ярилцах вэ гэдэг илүү чухал байдаг. Учир нь эрэн сурвалжлах сэтгүүл зүй нь агуулгын хувьд өөр. Мөн сэдэв нь ихэвчлэн өргөн цар хүрээтэй, эмзэг мэдрэмтгий байдаг учраас та эх сурвалжтайгаа дайсагнах, хамгаалах, чимээгүй өнгөрөх эсвэл бултах зэрэг янз бүрийн үйлдэл хийхэд хүрдэг. Тиймээс өөр төрлийн стратеги ашиглаж асуулт асуух техник ур чадвар таныг илүү амжилтад хүргэх болно.

Тохиромжтой цаг

Эрэн сурвалжилгынхаа гол баатартай хэзээ нүүр тулах вэ? Хэтэрхий эрт хугацаагаа товлон бүтээлээ нийтлэхээс чинь ч өмнө тэдэнд зугтах боломж өгчихнө. Харин эсрэгээрээ оройтвол тэд зугтана, бултах хариулт бэлдэнэ, эсвэл хууль эрх зүйн боломжийг ашиглан таны асуултыг үгүйсгэх болно. Иймд, маш их нотолгоо (дэмжлэг болох баримт бичгүүд) цуглуулж, ярилцлага хийх хамгийн тохиромжтой цагийг хүлээгээрэй.

Эмзэг өртөмхий байдал

Таны бэлтгэсэн сурвалжилга бүрэн дуусаагүй, бүгд зөв биш байлаа ч “ямар нэгэн зүйл” хийчихсэн л гэсэн үг. Ийм нөхцөлд, та эрэн сурвалжилж буй эрх мэдэлтэй хүмүүс, эсвэл байгууллагаас тайлбар хүсэж, шаардсанаар тэднийг аль хэдийнэ сандаргаад эхэлчихсэн гэсэн үг. Та тэдний асуудал болсон хэрэг. Тэд ямар ч байдлаар хариу өгч мэднэ. Энгийн нэг үгүйсгэлийн учрыг олоход хамгийн хялбар, та улам гүнзгий ухаж судалсаар байх хэрэгтэй. Мөн шууд биед халдах, хууль эрх зүйн сүрдүүлэг үзүүлэх, эсвэл бүр гуравдагч этгээдээр (ихэвчлэн таны редактор эсвэл хэвлэл мэдээллийн байгууллагын эзэн) дамжуулан айлгах, бүтээлийг хэвлэхийн өмнөхөн шүүхэд өгөх мэтийн нарийн арга хэрэглэж ч болно. Ийм тохиолдолд “гутаан доромжлох” гэсэн нэр томъёогоор халхавч хийдэг, уг нь бол гутаан доромжлох гэдэг нь илэрхий биш, тодорхой биш зүйл дээр хэрэглэгдэх учиртай.

Болгоомж, хянуур байдал

Эрэн сурвалжилгын гол зорилго нь мэдэгдэхгүй байгаа зүйлийг илрүүлэхэд оршдог. Өөрөөр хэлбэл, энэ нь санаатайгаар худал хэлсэн эсвэл ямар нэгэн зөвшилцлийн үүднээс дуугүй байх зэргийг илрүүлэх асуудал юм. Жишээлбэл, бага, залуу охидыг ашиглан хүний наймаа хийж байгаа талаар огт ам нээхгүй гэж зөвшилцсон засгийн газрын гишүүн парламентын, эсвэл нийгмийн өмнө худал хэлж болно. Эдгээрийг илчлэх нь цочирдуулам биш юм аа гэхэд гайхмаар байдаг. Тиймээс ч ярилцлагаа товлонх мэтийн ажлыг асар их мэдрэмжтэй зохицуулах нь чухал юм. Та яг юу хайж байгаагаа ярилцлагынхаа эхэнд илчилчихвэл эх сурвалж чинь ярилцахаас татгалзаж ч мэднэ. Хэрвээ та хөл хөдөлгөөн ихтэй олон нийтийн газар ярилцлагаа хийхээр шийдвэл эх сурвалжаа аюулд оруулж байж ч магадгүй. Эх сурвалждаа урхи тавихаасаа өмнө нэгийг тунгааж, хоёрыг бодох хэрэгтэй. Жишээлбэл, нэг сэдвийн дагуу ярилцана гэж уулзчихаад өөр сэдэв гаргаж ирэх, эсвэл гэр, ажлын байрнаасаа гарч байхад нь отож аваад, “үүдэнд нь” ярилцлага хийх зэрэг байж болно. Энэ нь хэн нэгний телевизийн нэвтрүүлгээр гоё харагдаж мэдэх ч яг таны хувьд байдлыг маш муугаар эргүүлж магадгүй. Хэвлэл мэдээллийнхэнтэй харьцаад сурчихсан олны

танил хүмүүс гэнэтийн асуултаас яаж булгах, эсвэл таныг үймээн дэгдээгч олиггүй амьтан мэт харагдуулахаа сайн мэддэг. Тэгээд таны хичээл зүтгэл, бэлтгэл ажлыг юу ч үгүй нураах вий.

► Ярилцлагын стратеги боловсруулах

Ярилцлага хийхэд ашиглаж болох гурван стратеги бий. Албан бус буюу мэдээлэл, баримт олж авах энгийн ярилцлагын хувьд бүх асуулт нь аль болох энгийн, тодорхой байх ёстой. Ярилцлагын явцад асуултууд илүү хүнд, мэдрэмтгий, чухал болохгүй гэсэн үг. Тэгвэл хүний хувийн амьдралтай холбоотой зүйлийнх нь талаар ярилцах гэж байгаа бол тухайн хүнийхээ талаар нэлээд нарийн асуултаас эхлэх нь зөв юм: Тэд хаана сурч байсан бэ? Хэнтэй гэрлэсэн бэ, яагаад? Тэд шүлгээ хэрхэн бичиж эхэлдэг вэ? Заримдаа эх сурвалжийн амьдралтай холбоотой чухал баримтуудыг хүргэхийн тулд хаалттай асуулт тавих хэрэгцээ ч гардаг. Мөн уншигчид ярилцлага өгч байгаа хүний үзэл бодлыг сонирхох дуртай байдаг. Тэгэхээр ярилцлага үргэлжлэхийн хэрээр асуултууд илүү өргөн хүрээ хамардаг болж ирнэ: Орчин цагийн романы үзэл баримтлалыг юу гэж бодож байна? Утга зохиолын шагналыг юу гэж боддог вэ, энэ жилийн шилдэг төрөлд хэн ялах бол? Ийм төрлийн ярилцлагын асуултууд яг л бүрээ шиг нарийнаас эхлээд илүү өргөн цар хүрээ хамрах бүтэцтэй байдаг. Ярилцлага үргэлжлэхийн хэрээр нээлттэй асуултууд асуувал тохиромжтой.

Харин эрэн сурвалжлах сэтгүүл зүйд дээрхээс тэс өөр стратеги ашиглах нь элбэг байдаг. Ийм төрлийн ярилцлага илүү өргөн хүрээний, ерөнхий асуултаас эхэлнэ: Засгийн газрын тендер авахын тулд ямар шаг дамжлага, үйл явцыг дамжих хэрэгтэй байдаг юм бол?, Энэхүү үйл явц нь шаардлага хангадаг уу? Засгийн газар үүнийг хэрхэн хянадаг вэ? энэ мэтээр асуултууд үргэлжлэхийн хэрээр илүү нарийвчилсан, төвлөрсөн болж ирдэг. Ингээд эрэн сурвалжлах сэтгүүл зүйн ярилцлагын хамгийн эцсийн, хамгийн хүнд асуулт нь хаалттай, эсвэл бүр чиглүүлсэн байх нь элбэг: Яг энэ гэрээний хувьд та тендерийн үйл явцын шаардлагыг хангаагүй юу? Яагаад? Иймэрхүү асуултаас болж эх сурвалж дуугаа хурааж, нэмэлт асуултад хариулахаас цааргалж эхэлдэг учраас л хамгийн сүүлд тавьдаг юм. Тиймээс ийм бүтэцтэй ярилцлага нь яг л юүлүүр шиг хэлбэртэй байдаг. Асуултууд нь өргөн цар хүрээ хамарсан ерөнхий байж байгаад төгсгөл рүүгээ илүү нарийн болж ирдэг.

Эрэн Сурвалжлах Сэтгүүл Зүйн Ярилцлагын Үеэр

► Чиний хүсч буй хариултаас бүх зүйл шалтгаална

Таны зорилго эрэн сурвалжлах сэтгүүл зүйн бүтээл болохоос “ялалт” байгуулах биш юм. Сэтгэлийн зовиургүй, тайван байхын тулд өөртөө шаардлагатай гэсэн хугацааг өг. Ярилцлагын гол зорилго нь үргэлж хариулт, мэдээлэл авахад орших бөгөөд таны асуултууд нэг ёсондоо түүнд хүрэх арга хэрэгсэл юм. Хөмсгөө өргөх, мөрөө хавчих, жуумалзах мэтийн таны сэтгэл хөдлөлийг илчлэх дохио бүрийг эх сурвалж чинь анзаарах болно. Та бол хүн учраас энэ мэт үйл хөдлөл хариу сэтгэгдлийг тань харуулж байдаг. Тэгээд ч телевизээр модон царай гаргах нь уйтгартай байдаг. Гэхдээ болгоомжтой байж, хэмжээ хязгаараа мэддэг байх хэрэгтэй. Сөргөлдөөн үүсвэл эх сурвалжид чинь шүүх хурлын үеэр үг хэлж байгаа мэт сэтгэгдэл төрж, өөрийгөө шууд хамгаалалтад авч эхэлдэг. Өдөөн хатгалга нь эцэстээ эмгэнэлт дуулиан, эсвэл үр ашиггүй чирэгдэл болоод дуусдаг. Таны түрэмгий зан буруу байдлаар илэрвэл таныг л муухай харагдуулна. Тиймээс хариу үйлдлээ санамсаргүй, сэтгэл хөдлөлөөр гаргаж ирэх бус харин санаатай, төлөвлөсөн байдлаар үзүүлэх нь дээр. Хэн нэгэн нь хэрүүл маргаан өдвөл эх сурвалж чинь асуултад хариулахаас аврагдлаа л гэсэн үг шүү дээ.

► Гол санаа руугаа шилж

Эх сурвалжийн чинь хариулт таны утгагүй асуултуудаас хавьгүй чухал. Тиймээс дэмий юм чалчихгүй, саад болохгүй байх хэрэгтэй. Туршлагатай улс төрч, бизнес эрхлэгч мэдээж хэдэн зуун мянган ярилцлага өгсөн байж таарна. Тэдний хувьд цаг үнэтэй, тэд асуултад чинь хариулмааргүй байвал хариулахгүй өнгөрч чадна. Хэрвээ та асуудлыг дэлгэж, ил болговол тэдний нэр хүнд, дүр төрх, албан тушаал, мөнгө, ирээдүй зэрэг нь нуран унахыг тэд сайн мэдэж байгаа. Тиймээс нөхцөл байдал, тухайн хүнийхээ талаар хувийн мэдээллийг анхааралтай уншиж, аажмаар гол асуултаа асуух гэж оролдоод бүтэлгүйтвэл шууд л шулуухан асуу. Хэрвээ тэдний хариулт ойлгомжгүй байвал асуултаа бага зэрэг өөрчлөөд дахин асуу. Зарим эх сурвалж дахин нэг тунгааж, шинээр хариулахдаа дуртай байдаг. Тэдний хариултыг маш анхааралтай сонсож, энэ үнэхээр хүссэн хариулт чинь мөн үү гэж өөрөөсөө асуу. Хэрвээ үгүй бол дахиад л оролдоод үз. Эх сурвалжийнхаа хэлж байгаад нэг л итгэлгүй байвал өөрсдийнх нь хариултыг асуулт болгон асуу (Тэгэхээр та ингэж хэлэх гээд байна уу?).

► Бүрэн дүүрэн хариулт ав

Эх сурвалж чинь танд тодорхой хариулт өгөхгүй, “сүүлийн үед”, “хэд хэдэн”, “маш олон”, “тодорхой ажил” зэрэг ерөнхий үг ашиглаж болно. Тэр үед нь тэдгээр хариултыг тодруулах замаар дахин дахин асуух хэрэгтэй “Яг хэзээ?”, “Хэчнээн?”, “Та тоог нь тодорхой хэлж болох уу?”, “Яг ямар ажил хийх юм бэ?” гэх зэргээр асуу. Мөн хаалттай хариултад ч энэ хамаатай. “Тийм”, “Үгүй” гэх хариулт нь эх сурвалж таны асуултыг шууд төгсгөж байгаа нэг хэлбэр юм. Заримдаа танд илүү мэдээлэл хэрэгтэй байгаа тохиолдолд дэлгэрүүлж асуух шаардлагатай болдог: “Та тус гэрээнд гарын үсэг зурсан уу?” “Тийм” “Та ингэх болсон шалтгаанаа тайлбарлаач?”.

Цааш үргэлжлүүлэхээсээ өмнө хариулт бүрийг сайтар хяна. Ярилцлага өгч сурсан хүмүүс танд юу гэж хэлвэл хүсч байгаа хариултыг чинь өгч байгаа мэт сэтгэгдэл төрүүлэхдээ сайн байдаг. Гэвч дараа нь тэмдэглэлээ дахин уншихад асуултаас чинь бултсан байхыг анзаарах болно. “Та Х дүүрэг дэх эмнэлэг рүү эм тариаг нь хүргүүлсэн үү?” гэж таныг асуухад “Мэдээж эмнэлгийн шаардлагатай гэсэн үйл ажиллагаа хийгддэгээрээ хийгдэж байгаа” гэж хариуллаа гэж бодъё. Таны асуултад “Тийм” гэж хариулсан мэтг боловч яг асууж байгаа зүйлд нь огт хариулаагүй байгаа юм. Тэр үед та “Яг ямар эм тариа хүргэсэн бэ?”, “Яг хэдний өдөр хүргэсэн юм бол?”, “Тэдгээрийг хүргэсэн гэсэн ямар баталгаа байгаа вэ?”, “Тэдгээрийг хүргэсэн гэсэн бичиг танд байгаа юу?” гэх зэргээр нэмэлт асуулт дагалдуулах хэрэгтэй. Хэрвээ ярилцагчийнхаа хариултыг бүрэн ойлгохгүй бол ингэж давтан асуугарай. Санаа зовсноосоо болоод ойлгосон мэт царайлнаас эргэлзээгээ арилтал асуусан нь дээр байдаг. “Наадахыг чинь манай уншигч, үзэгчид сайн ойлгохгүй л болов уу. Арай энгийнээр тайлбарлаад өгөөч?” гэж болно. Үүнтэй адилаар өгүүлбэрээ шинэчлэх ийм арга бас бий: “Хэрвээ би таныг зөв ойлгосон бол, Сайд аа, та ... гэж хэлсэн үү? Энэ зөв үү?”.

► Баримт материал, хавсралт

Ярилцлагын үеэр хэвлэлийн мэдээ, баримт бичиг, судалгаа, гэрэл зураг зэрэг хэрэг болж магадгүй материалын хуулбар авч яваарай. Эх сурвалж чинь таны хүлээгээгүй гэнэтийн зүйл хэлвэл эдгээр материалаасаа харах боломжтой. Дуу бичлэгийн төхөөрөмж болон тархиа байнгын харилцан хамааралтай ажиллуул. Учир нь ярилцлага дууссаны дараа тэд л үйл явдал хэрхэн өрнөснийг танд гэрчилж туслах юм. Дараа тодруулах зүйл байвал дахин холбогдож болох эсэхийг асуугаарай.

► Хуурамч бялдууч занд бүү хуурт

Энэ ярилцлага болохоос нөхөрлөл биш. Та мэдээлэл олж авах гэж байгаа болохоос дэмжлэг авах гээгүй биз дээ. Хэрвээ нөгөө хүн чинь танд “Наадах чинь үнэхээр мэдрэмжтэй асуулт байна” гэж хэлж байгаа бол таныг магтаж байгаа хэрэг биш, харин хариултаа бодох нэмэлт цаг хожиж байгаа хэрэг. Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн ярилцлагын дараа эх сурвалждаа сэтгэлээ онгойлгох боломж олго. Хачирхалтай нь ингэх нь саруул ухааныг нэмэгдүүлдэг. Энэ үед өөрөөс чинь асуух зүйл байгаа эсэхийг тодруулж, эелдэг, хүндэтгэлтэй харьцаарай. Мөн бүтээл чинь хэзээ нийтлэгдэхийг тайлбарлах сүүлийн боломж энэ юм шүү. Ярилцлагаа үргэлж дараах асуултаар төгсгөж байгаарай: “Таниас асуугаасай гэж хүссэн зүйл байна уу?” эсвэл “Өөр нэмж асуух зүйл үлдсэн болов уу?”.

► Үүрэг амлалт

“Хэвлэн нийтлэхээсээ өмнө надад үзүүлнэ гэсэн биз дээ? Үгүй гэж үү?” Олон нийтэд бүтээлээ хүргэхээсээ өмнө эх сурвалждаа үзүүлнэ гэж амлах, энэ тал дээр хэтэрхий анхаарал хандуулаад санаа тавих шаардлагагүй. Иймэрхүү харилцан яриа өрнөх үед шулуухан тодорхой байдлаар “Үгүй, ер нь бол иймэрхүү зүйл ярьмаар байгаа бол манай редактортой холбогдоорой гэж хэлсэн шүү дээ. Энэ бол түүний хаяг, утасны дугаар” гэх зэргээр тайлбарлахаасаа бүү эмээгээрэй. Хэвлэл мэдээллийн хэрэгслийг сайн ойлгодог, мэддэг хүн бол энэхүү эцсийн, яаруу сандруу хүсэлтийг чинь хүлээн авч ашиглах нь гарцаагүй.

► Эцсийн сэтгэгдлийг хайхрахгүй байж болохгүй

Ярилцлага дуусах үед эх сурвалж чинь биеэ барихаа больж, илүү чөлөөтэй, тав тухтай болж ирдэг. Энэ үед ярилцлагатай холбоотой нэр ус, албан тушаал эсвэл бусад янз бүрийн зүйлийг шалгахад хамгийн тохиромжтой. Үргэлж утасны дугаар, эсвэл холбогдох э-мэйл хаягийг нь асууж байгаарай. Ингэснээр дараа ямар нэгэн мэдээлэл тодруулж асуухад хэрэг болдог. Өөрийнхөө нэрийн хуудсыг ч мөн өгөөрэй. Эцэст нь хүндэтгэлтэй, эелдэг харилцаа үлдээх асуудлыг хайхрахгүй байж болохгүй. Цаг гаргасанд баярлаж байгаагаа илэрхийлээрэй. Тантай хэчнээн сөргөлдөж, ёжилсон байсан ч хамаагүй энэ бол маш чухал алхам юм. Тэднийг тантай ярилцах боломж олгож, сэтгэл гаргасанд нь баяртай байгаагаа илэрхийлэхийг оролд. Хэрвээ тухайн ярилцлага сэдвийнхээ хүрээнд ерөнхий мэдээлэл авах зорилготой байсан бол, эсвэл найзан дундаа ярилцаад өнгөрсөн бол, шинэ санаа мэдээлэл өгөхүйц өөр эх сурвалж таних эсэхийг асууж лавлаарай. Өөрөөр хэлбэл, өөр нэг хаалга онгойлгохдоо энэ хүнийхээ нэрийг ашиглаж байгаа гэсэн үг юм.

► Ярилцлагаа дуусмагц тэмдэглэлээ тэр дор нь шалгаж нягтлах

Ярилцлагаа дуусмагц тэмдэглэлээ унших нь зөв. Энэ бол богино хугацааны ой санамжаа эргэн санахад хялбар байдагтай холбоотой. Хэрвээ дараа өдөр хүртлээ тэмдэглэлээ нэг ч сөхөж харахгүй бол төгсгөл нь бүрхэг, сараачсан тэмдэглэл чинь яг ямар санаа агуулж байгааг, эсвэл яаралтай давхар шалгах ёстой зүйлээ мартах магадлалтай. Тэмдэглэлийнхээ хоосон үлдээж орхигдуулсан хэсгийг нөхөж бичээд, ярилцлагынхаа аль хэсгийг улам гүнзгийрүүлж судлах ёстойгоо шийдээрэй.

Пи Ар Мэргэжилтнүүдтэй Хэрхэн Учраа Олох Вэ?

Пи Ар мэргэжилтнүүд (төрийн байгууллага, компанийн хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажилтан) нь сэтгүүлч болон олны танил хүмүүсийн дундын харилцаанд маш чухал үүрэгтэй байдаг. Заримдаа тэд бүр ярилцлагад хамт орж, ярих шаардлагагүй сэдвүүдийг төлөвлөгөөтэйгөөр гаргаж ирэх нь бий.

“Guardian” сонинд ажиллаж байсан сэтгүүлч Дэннис Баркер, Английн засгийн газрын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажилтнаас (мэдээж хэрэг нэрээ нууцлахыг хүссэн) Пи Ар мэргэжилтнүүдтэй холбоотой дараах ойлголтуудыг авчээ.

Тэдний шалтаг үнэн ч байж болно. Гэхдээ л шалтаг учраас та ямар ч байсан тэднийг сорьж шалгах үүрэгтэй. “Хэрвээ та надад хэлэхгүй юм бол өөр хэн хэлэх юм бэ?” гэдэг асуулт үр дүнтэй байдаг. Таны асууж, шалаад байгаа албан тушаалтан тодорхой мэдээлэлгүй, эсвэл дээрээс авсан үүрэг, даалгавраа биелүүлж байх нь элбэг. Өөрөөр хэлбэл, эсэргүүцэх, хамгаалах хандлагатай байвал тэд ажлаа хийж байна л гэсэн үг. Тэр бол таны биш, хэвлэлийн ажилтны л асуудал. Маш онцгой тохиолдолд л биш бол засгийн газрынхан буруутай байсан ч өөрсдийгөө шүүмжлүүлэх дургүй байна шүү дээ. Тиймээс хэвлэлийн ажилтанд сөрөг зүйлийн хажуугаар эерэг зүйлсээ ярих боломжийг нь олгоорой. Ингэснээр тэд илүү нээлттэй болж ирдэг.

1

2

Иргэний нийгмийн чухал гэж боддог асуудлуудад сэтгүүлчид нэлээд анхаарал хандуулдаг л даа. Гэвч тэдгээр асуудал нь засгийн газрын хувьд нэг их чухал биш байвал л үнэхээр анхаарлаа хандуулах шаардлагатай байдаг. “Яагаад энэ талаар ярихгүй байгаа юм бэ?”, “Яагаад засгийн газар үүнийг анхаарахгүй байна вэ?” зэргээр асуугаарай. Сэтгүүлчдийн хувьд чухал зүйлс засгийн газрынхны хувьд тийм биш байж болно. Засгийн газар “илүү том асуудлууд”-тай ч байж мэднэ. Хэвлэл мэдээллийн ажилтнаас нарийн ширийн зүйлсийн талаар асуух нь тэднийг айлгаж, хэцүү байдалд оруулдаг бөгөөд үүнээс л тэд зугтаж байдаг юм.

Түрэмгий, шинэ сэтгүүлчид мэдлэг, мэдээлэл сайтай, туршлагатай, тайван сэтгүүлчдээс арай хурдан сэтгэл ханадаг. Хэвлэлийн ажилтнууд ч сэтгүүлчдийг ерөнхий мэдээлэл авчихаад сэтгэл ханаад яваасай, илүү ихийг ухаж төнхөхгүй байгаасай гэж хүсдэг. Туршлагагүй сэтгүүлчид “Эндээс гоё гарчиг гарахгүй юм байна даа” гэж бодох тэр мөчид л сонирхол нь буурч байгааг анзаарч болно. Гэтэл иймэрхүү дуулиан шуугиан эрж явдаг сэтгүүлчдийг замаас нь хазайлгах зорилгоор мэдээний ач холбогдлыг бууруулдаг Пи Арын тусгай аргууд ч байдаг. Харин шинэ мэдээлэл эрж хайхад анхаарлаа хандуулж, олсон баримт нь уйтгартай байсан ч цөхрөлтгүй оролдсоор байдаг туршлагатай сэтгүүлчид сайн бүтээл хийж чадна.

3

4

Хэрвээ таны мэдээллийг худлаа байна гэвэл тэр дор нь хүлээж авах шаардлагагүй. “Хэрвээ миний буруу бол би уучлалт гуйя, гэхдээ...” гэж хэлэхдээ бэлэн бай. Тэгээд сайн судалсан, хөдөлшгүй баримт бүхий мэдээлэл агуулсан асуулт араас нь асуух хэрэгтэй. Хэрвээ асуултыг хариулалгүй буцаавал дахиад л асуу. Зарим хэвлэлийн ажилтан таны асуултаас өөрөө асуулт гаргаж ирээд, сэдвийг хазайлгахыг оролддог. Тухайлбал, “Сайд гэрлэсэн хэрнээ өөр хүнтэй болсон гэдэг нь үнэн үү?” гэж таныг асуухад “Яагаад энэ асуудал дээр сэтгүүлч та нар ингэтлээ анхаараад байгаа юм бэ?” гэж хэвлэлийн ажилтан асууна. Тэгэхээр нь “Сэтгүүлчид юу гэж бодох нь хэнд ч хамаагүйг та мэдэж баймаар юм. Би энд уншигчдынхаа хариулт шаардаж байгаа асуултыг л тавихаар ирсэн. Манай редакци сайдын гэр бүлийн харилцааны талаар асуусан өчнөөн захидалд дарагдчихаад байна. Тиймээс та асуултад хариулна уу?” гэж хариу барих хэрэгтэй.

Хэрвээ асуултад чинь хариулаагүй мэт сэтгэгдэл төрвөл цөхрөлтгүй оролдсоор л бай “Би хариултыг чинь бүрэн гүйцэд ойлгосонгүй. Та дахиад нэг хэлээд өгөөч?”, “Таныг миний асуултад гүйцэд хариулсан гэж бодохгүй байна” гэх нь огт хариулаагүй гэсэн санааг хамгийн эелдгээр ойлгуулж байгаа хэрэг. “Та энэ асуултад хариулахгүй байсан нь дээр гэж үзээд байна уу?” “Ингэж хариулахгүй байхад чинь юу нөлөөлөөд байгаа юм бэ?” “Та надад энэ талаар хэлчихвэл танд юу тохиолдох бол?” “Хэн надад энэ талаар хэлж өгч чадах вэ?” зэргээр асуусаар байх хэрэгтэй.

Хэцүү асуулт руугаа ойртохдоо олон төрлийн арга ашиглаарай. Заримдаа хэцүү мэдээлэл олж авах нэг арга нь зүгээр л асуух байдаг. Гэвч хэрвээ та туршлагатай хэвлэлийн ажилтантай харилцаж байгаа бол шууд асуултыг чинь няцааж ч мэднэ. Энэ тохиолдолд илүү чадварлаг, нарийн нухацтай арга ашиглавал үр дүнтэй байдаг. Тэдэнд анхааруулга, сануулга өгөх, эсвэл тайлбар хэлэх боломж олгох зарим санааг дараах асуултуудаас аваарай: “Та ... гэсэн санаа гаргасан тайланг уншсан л байлгүй. Тийм үү?”, “Энэ тийм таатай асуудал биш боловч манай уншигчдын зүгээс намайг үүнийг асуугаасай гэж хүсч байгаа тул...”, “Энэ баримт мэдээллийг нэг тийш нь болгоход та туслаач...”, “Парламентын сөрөг хүчний зүгээс таны тухай хэлэхдээ...”, “Та энэ тал дээр тайлбар хэлмээр байна уу?”.

Эх сурвалжийн татгалзаж байгааг хариулт болгон ашиглах

Хэрвээ эх сурвалж чинь асуултад хариулах шинжгүй, түүнийгээ ч хэлж байвал та үүнийг урьдчилан таамаглаад бэлтгэлтэй байх шаардлагатай. Телевиз, радиод ашиглах дуу хураагуурт тэдний хариулахаас шууд болон шууд бусаар татгалзаж байгааг бичиж авах хэрэгтэй. Тэгээд бичлэгээ эвлүүлж, нэвтрүүлэгтээ шингээж болно. Харин сонин хэвлэлийн хувьд “Энэ тухай түүнээс асуусан боловч хариулахаас татгалзсан юм” гэж бичих боломжтой. Яагаад хариулахаас татгалзсаныг нь та өөрийн үгээр тайлбарлах шаардлагагүй. Зүгээр л юу болсныг байгаагаар нь хүргэ. Дүгнэлт хийх, шүүмжлэх эрхийг үзэгч, уншигчдадаа үлдээ. Хуулийн дагуу асуулт асууж байхад шийдэмгий эсэргүүцэхээр ярилцлага хийх ямар ч боломжгүй болдог. Гэхдээ энэ нь зарим талаараа үр дүнтэй байдаг. “Уучлаарай, Сайд аа, энэ асуудалтай холбоотойгоор таныг ямар нэгэн тайлбар хэлэхээс татгалзана гэж би уг нь бодоогүй. Тиймээс надад зөвхөн өөрийн ажиглалт болон мэргэжилтнүүд, гэрчүүдийн хэлснийг л ашиглахаас өөр арга алга даа. Таныг ярилцлага өгөхөөс татгалзлаа гээд

оруулчих уу?” гэж болно. Ухаалаг хүн бол тэр үед ямар нэгэн зүйл хэлсэн нь дээр гэдгийг ойлгох болно. Ингэсэн ч хамтран ажиллахаас татгалзвал зүгээр эелдгээр орхин яваарай.

Хэрвээ эх сурвалж тодорхой асуултад хариулахгүй гэдгийг та хэн нэгнээс урьдчилан мэдэж авсан бол ямартай ч бүх бэлдсэн асуултаа асууж, тодорхой болгох хэрэгтэй. Ялангуяа шууд нэвтрүүлгийн үеэр ингэх нь тохиромжтой байдаг. Ярилцаж байгаа хүн тань ч, үзэгчид тань ч таныг ямар ч байсан асуусныг мэдэх хэрэгтэй. Эс бөгөөс та тухайн асуултыг огт асуугаагүй гэсэн шүүмжлэлд өртөх болно. ”Хэрвээ асуусан бол би хариулах л байсан” гэж эх сурвалж чинь тайлбарлаж мэднэ. Энэ нь таныг муухай харагдуулна шүү дээ.

Маргааныг алсаас асуу



Засгийн газрууд террорист үйл ажиллагаанд оролцох нь бий. Энэ тохиолдолд бид яах вэ? Та эх сурвалжаас дараах асуултыг асууж болно: “Засгийн газар ... талаар надад ярилцлага өгсөн эх сурвалжуудын үзэл бодол зөрчилдөөд байгаа л даа”, “Манай редактор танаас үүнийг асуухыг шаардсан юм”. Эх сурвалжаасаа асуултад хариулахыг шаардаад үз. Гэхдээ худлаа хэлэх, эсвэл бусад эх сурвалжаа илчлэх хэрэггүй. Жишээлбэл, “Өөр нэг эх сурвалж таныг тэгэхийг харсан гэснийг та мэдэх хэрэгтэй байх л даа”, эсвэл “Таны талаар ийм хов жив гарсан. Гэвч хов жив хэр үнэн бодитой байдгийг бид бүгд л мэднэ шүү дээ. Танд энэ тал дээр хэлэх тайлбар байна уу?”, “Үүнтэй холбоотой танд ямар нэгэн санаа оноо байна уу?” зэргээр асууж үзээрэй.

Нууцаар бичлэг хийх



Ихэнх хэвлэл мэдээллийн газар нууцаар бичлэг хийх тал дээр хатуу дүрэм баримталдаг бөгөөд зарим улсад энэ нь бүр хууль бус байдаг. Гэвч энэ нь заримдаа хэрэгтэй мэдээллээ олж авах цорын ганц арга байж болно. Бэлтгэл хамгийн чухал! Цээжиндээ нууц камер хийгээд, тааз, эсвэл шалны дүрс авчихсан байвал ямар хэрэг байх билээ. Мөн хураасан дуу нь чанарын шаардлага хангахгүй байвал та цаг зав, хүч хөдөлмөрөө дэмий үрсэн болно. Гэмт хэргийн цуврал кинон дээр гардаг шиг нууц бичлэг хийх нь тийм ч амар зүйл биш. Та эх сурвалжаа яриулж, хүссэн мэдээллээ авахын тулд ярилцлага хийх арга барилыг яг л техникийн мэргэжилтэн шиг эзэмшсэн байх ёстой. Энэ хэдийгээр хиймэл, хоосон сонсогдож байгаа ч нэг ёсны стратегээ боловсруулахад тусална.

Эх сурвалж чинь таныг нууцаар бичлэг хийж байгааг гадарлаад шууд тулгаж асуувал та өөрийгөө хамгаалахын тулд “Үгүй” гэж хариулах байх. Гэхдээ ингэвэл тухайн материалаа ашиглахад бэрх болно. Ярилцлагаа нууцаар бичиж байгаагаа үгүйсгэвэл нөгөө хүнээ цааш үргэлжлүүлэн яриулах боломжтой болно. Гэвч Английн хэвлэл мэдээллийн хуулийн дагуу олон нийтийн эрх ашгийг уландаа гишгэсэн зүйл тохиолдоогүй бол нууцаар бичсэн материалыг ашиглах боломжгүй байдаг. Үүнтэй ихэнх орны хуульчид санал нэгдэх болов уу.



Эсэргүүцэл, Айдсын Учрыг Хэрхэн Олох Вэ?

Эх сурвалжид чинь ярилцлага өгөхөөс татгалзах олон шалтгаан бий. Өмнө нь бид Пи Ар мэргэжилтнүүдтэй хэрхэн учраа олох талаар дурдсан. Гэвч хэвлэл мэдээллийнхэнд яриа өгөхөөс айх бодит шалтгаантай хүн үнэндээ олон байдаг. Шударга бус хэвлэл мэдээллийн хэрэгслүүд ихэнх улс оронд байдаг бөгөөд эх сурвалжтайгаа зохисгүй харьцах нь бий. Таны эх сурвалж сэтгэл зүйн гүн хямралд орсны улмаас өөрийгөө илэрхийлэхдээ дурамжхан байж болно. Эсвэл танд хувийн мэдээллээ дэлгэснээс болж эргэн тойрны хүмүүс нь түүний талаар мэдэхээс санаа зовж байж ч болно. Ямартай ч ярилцлага авахын тулд шантралгүй зүтгэх хэрэгтэй. Гэхдээ яриа өгөхийг хүсэхгүй байгаа эх сурвалжийг ятгахдаа та хоёрыг ойлголцолд хүргэх гуравдагч хүнээр дамжуулах нь үр дүнтэй байдаг.

Ярилцлага авахын тулд эхлээд эх сурвалж чинь юунаас айж байгааг тодруулж, аль болох сэтгэлийг нь тайвшруулж, итгэл төрүүлэхийг хичээгээрэй. Гэвч биелүүлж чадахааргүй амлалт өгч болохгүй. Тиймээс ярилцлага хийхээсээ өмнө эрхлэгчтэйгээ зөвлөлдөж, эх сурвалжаа хэрхэн хамгаалах боломжтойг урьдчилан тохиролцох хэрэгтэй.

Нийтлэх зөвшөөрөл авах

“Таны хэлснийг хэвлэн нийтэлж болох уу?” гэж асуухыг албан ёсоор зөвшөөрөл авахтай андууруузай. Эх сурвалж тань түүний яриа олон нийтэд хүрсний дараа гарч болох үр дагавар, эрсдлүүдийн талаар ойлгож мөн өөрийг нь хамгаалах, эсэх талаар тодорхой мэдсэний үндсэн дээр хэвлэн нийтлэх зөвшөөрөл өгөхийг хэлж байгаа юм. Хүмүүсийг айлгах хэрэггүй, нөгөө талаар үүсч болзошгүй нөхцөл байдлыг ч тэднээс нууцлах шаардлагагүй. Өөрийгөө нээж, мэдээллээ олон нийттэй хуваалцах эх сурвалж чинь олшрох тусам таны бүтээл илүү хүчтэй болно. Иймэрхүү ярилцлагууд таны эх сурвалжуудтайгаа харилцах холбоог баталгаажуулахаас гадна чин сэтгэлийн харилцан яриа өрнүүлэх боломж бүрдүүлнэ. Зарим эх сурвалж нэрээ нууцлахыг хүссэн ч энэ бүхэнд хувь нэмэр оруулж буй хэрэг шүү дээ.

Өрөвдөх биш ойлгох нь чухал

“Өө, ямар аймшигтай зүйл болоо вэ, хөөрхий дөө” гэх үг эх сурвалжийг чинь хүчгүйдүүлж, тэднийг сул дорой болгодог. Түүнд өөрийн түүхээ хуваалцах аюулгүй, найдвартай орчин бий болгож өг. Эх сурвалжаа чөлөөтэй сонсож, төвийг сахиж, түүнд ярих хангалттай цаг олго. Ингэснээр тэр бодлоо цэгцэлж, сэтгэл хөдлөлөө хянах боломжтой болно. Түүнд энгийн хэрнээ урам өгсөн хариулт хэлж бай. Толгой дохь, “Тийм ээ, тэгээд дараа нь яасан?”, “Энэ талаар илүү ихийг ярьж өгөөч” гэж хэл. Мөн танай соёлд нийцнэ гэж үзвэл эх сурвалжийнхаа гарыг зөөлөн атгах зэрэг нь муугүй санаа. Зөн совиндоо итгэх хэрэгтэй.

Бичихээ боль

Заримдаа тэмдэглэл хөтөлж байгаа чинь эх сурвалжид дарамттай санагдаж болно. Ялангуяа асуулт чинь эмзэг сэдэв рүү ороод эхэлчихсэн бол зүгээр л сонс. Дараа нь тэмдэглэж болно шүү дээ.

Хүндлэл үзүүл

Асуултуудаа тавих гэж бүү яар. Мөн эх сурвалжийнхаа хариултыг дуулиан шуугиан болгоход ашиглах хэрэггүй. Ямагт эх сурвалжийнхаа оронд өөрийгөө тавьж, асуулт чинь мэдрэмжгүй байгаа юм биш биз гэдгийг нягтлаарай.

Маш болгоомжтой байгаарай

Мэдрэмж шаардлагатай боловч та хүнд асуултуудаа асуух ёстойгоо сана. Хэн нэгэн өөрийгөө тамлуулсан гэж хэллээ гээд тэр бүхэн нь үнэн гэсэн үг биш. Сүржин хүмүүсээс болгоомжил. Тэдэнд тохиолдсон зүйлийн нарийн ширийнийг маш сайн мэдэж авахгүй л бол түүхийг нь мэдээлж чадахгүй гэдгээ сайн ойлгож ав. Тиймээс өөр төрлийн ярилцлагын үеэр тавих байсан шаардлагууд, мэдээллүүдээ бүгдийг нь олж авахаас битгий зайлсхийгээрэй.

Үгүйсгэл, няцаалтыг нь ажигла

Хүмүүс янз бүрийн шалтгаанаар, заримдаа муу талаараа биш ч худлаа хэлэх, эсвэл хагас худлаа хэлэх тохиолдол гардаг. Өөрсдийнхөө талаар үнэнийг гажуудуулан хэлж байх үед хүний нүүр лүү эгцэлж харах хэцүү байдаг. Хэлснээ үгүйсгэж, няцааж байгааг нь биеийн хэлэмжээс нь ажиглаж ч болно. Жишээлбэл, эх сурвалж чинь хүчиндүүлсэн, эсвэл хүчингийн хэргийн гэрч болсноо шууд хэлж чадахгүй шүү дээ.

Тэмдэглэл:

Оновчтой асуулт асууж чадах, эсэхээс таны бүтээл сайн болох, эсэх шууд хамаарна. Гэхдээ шаардлагатай бүхий л мэдээллийг цуглуулж байж л эрэн сурвалжлах сэдвийнхээ суурийг бий болгож өгдөг. Хамгийн гол нь тэр бүхнийг олон нийтэд ойлгомжтой хүргэхийн тулд сайтар найруулан бичих хэрэгтэй. Тиймээс дараагийн бүлэгт сайн бүтээл туурвихын тулд мэдээллийг хэрхэн цэгцэлж, сонгох талаар заах болно.



НАЙМДУГААР БҮЛЭГ

БҮТЭЭЛЭЭ БИЧИХ НЬ

Цэгцтэй бүтцийн дагуу сайн бичиж чадахгүй л бол хэчнээн сайн хийсэн эрэн сурвалжилга ч нуран унах нь бий. Бүтээл тань уншигчдын итгэлийг даах ёстой учраас бүх баримт нь шинэчлэгдсэн, цаг үеийнх байх хэрэгтэй. Нийгэмд танигдсан, сэдэвтэй чинь хамааралтай хүмүүсийн эшлэл эрэн сурвалжлах бүтээлийг тань илүү даацтай, найдвартай болгоно. Мөн эрэн сурвалжилгын илүү нарийн, түвэгтэй хэсгүүдийг уншигчдад ойлгомжтой болгох үүднээс хүснэгт, график, бүдүүвч ашиглах нь заримдаа тустай байдаг.

Бүтээлээ хэрхэн бичих вэ?

Эрэн сурвалжлах хүнд ажлын дараа та өөрийн хийх нээлтийг нийгэмд нөлөөлнө гэж бодох үедээ энэ асуултыг өөртөө тавиад үзээрэй: Надад үнэхээр өгүүлэх түүх бий гэж үү? Эрэн сурвалжилгын амин сүнс болох бүтээлээ хэрхэн хөгжүүлж, бичсэн бэ гэдгээс энэ асуулт урган гарч байгаа юм.

Уншигчдын анхаарлыг татаж, нөлөөлөхийн тулд та бүтээлийнхээ амин сүнсийн талаар бодож, хамгийн нөлөө бүхий дүр зургийг онцлох хэрэгтэй. “Лид нь дүрийг хувь хүн талаас нь гаргасан, үйл явдал болсон газрыг хүчтэй дүрсэлсэн байвал сайн. Гэхдээ эхлэхдээ зөвхөн чухал хэсгүүдийг л гаргах нь зүйтэй. Бусад нарийн ширийн зүйлийг дараа нь тодорхойлж болно” гэж Америкийн ахмад сэтгүүлч Стефен Френклин зөвлөжээ. Үүний зэрэгцээ, та олсон бүхнээ үнэнч шударгаар бичих ёстой. Эрэн сурвалжлах бүтээлтэй чинь авцалдахааргүй дүр бий болгох гэж хичээх хэрэггүй. Мөн болсон явдал, хэргийг хачирлан, сүржигнэхээс татгалзаарай. Үзэгч, уншигчдынхаа итгэлийг олно гэдэг хамгийн чухал. Худлаа, зохиосон мэт харагдах дүрслэлээр бүтээлээ эхлүүлж, тэр итгэлийг алдуузай.

Бүх мэдээллийг хүргэснийхээ дараа та олж мэдсэн бүхнээ баримт нотолгоотой нь хавсаргах замаар бүхнийг “базаж”, бүтээлээ төгсгөх хэрэгтэй. Эрэн сурвалжлах төгс бүтээл нь “дарь нь үнэртсэн буу”-ны адил хөдөлшгүй баримт, нотолгоотой байх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, буруутнууд таны олж илрүүлээд байгаа асуудалд гараа дүрчихжээ гэдгийг батлах учиртай. Харамсалтай нь тун боломжийн болсон эрэн сурвалжилгууд оновчгүй үг сонголт болон нотлох баримт, эсвэл баримтуудаа сайн холбож өгч чадаагүйгээс утга учиргүй болох тохиодол элбэг гардаг. Бүр муугаар бодоход иймэрхүү тааруухан оролдлого бусдын нэр хүндэд халдах гэсэн гүтгэлэг болж хувирдаг.

Нямбай бай

- **Тодорхойлолт ба жишээнүүд:** Ойлгомжгүй нэр томьёо, хэллэгийг уншигчдадаа тайлбарлаж өгөх, бүтээлийнхээ туршид түүнийгээ баримтлах нь зүйн хэрэг. Мөн ойлгомжгүй зүйлийг жишээ ашиглах замаар тодорхой болгох хэрэгтэй.

- **Батлагдаагүй ерөнхий ойлголт:** “Олонх”, “олон”, “зарим”, “цөөн” зэрэг хэллэгийн утгыг сайтар ойлгож, ялгааг нь анзаарч ашиглах хэрэгтэй. “Олонх” ба “олон”, тэр бүү хэл “бүгд”, “аль нь ч биш” гэдгийн хооронд ч эргэлзээ үүсэх тохиолдол гардаг. Аливаа нэг зүйл асуудлын цорын ганц шалтгаан байна уу, эсвэл шалтгаануудын нэг нь байна уу? “Үргэлж” үү, эсвэл “үе үе” үү? Ийм ерөнхий ойлголтыг жишээ, нэр бүхий хүний эшлэлийг оруулах байдлаар тодорхой болгох шаардлагатай.
- **Нэмэлт тайлбар:** Өгүүлсэн санаа болгоныг жишээгээр баяжуулаарай. Санааг нь шүүмжлэх гээд эзэн рүү нь дайрч болохгүй. Нотлох баримт, нотолгоог л тойрон хэлэлцэх учиртай юм. Уншигчдад мэдээ хүргэсний дараа үйлдэл хийх, эс үйлдэл хийхийг шийдэх боломжийг олгох нь зүйтэй. Заримдаа санаагаа яв цав ойлгуулахын тулд шууд хэлж, үзүүлэх шаардлагатай болно (мөн мэдээж гүтгэлэг гэж харагдахаас сэргийлэхийн тулд). Мэдээг багцалсан дүгнэлт өгүүлбэрээр дуусгана.
- **Албаны хүмүүсийн яриаг нотолгоо болгон эшлэх нь:** Энэ тохиолдолд эерэг болон сөрөг талуудыг жагсаан бичээд, сурвалжилганд тэнцвэртэй байдлыг баримтлан оруулах хэрэгтэй. Эрх баригчдын үйлдэл, шийдвэрийн цаад шалтгааныг олж харах нь чухал. Тэд яагаад ингэж мэдэгдэв? Нэг бус нэгжгээд эх сурвалжуудтай ярилцан, суурь судалгаа, эшлэлийг цуглуулаарай.
- **Урьдчилсан дүгнэлт, хэвшмэл ойлголт, сэтгэл хөдлөл:** Эерэг ч бай, сөрөг ч бай хэвшмэл ойлголтоос зайлсхийж, төвийг сахисан байр сууринаас сурвалжилга бэлтгэх хэрэгтэй бөгөөд талуудын байр сууринд ижилхэн эрүүл өнцгөөр хандах нь зөв. Өөрийн хэлж байгаа зүйлээ нотлох баримтаар баталгаажуул. Цорын ганц хөдөлшгүй баримт дээр түшиглэсэн мэдээнээс олон үндэслэл тайлбар бүхий мэдээ илүү үнэн бодит байх нь бий. Гэхдээ, олж чадвал үндэслэлээс илүү баримт нотолгоо чухал. Эс бөгөөд хоорондын уялдаа сайтай үндэслэлүүд ч тэр үүргийг орлож чадна. Үндэслэлийг цэгцтэй, ойлгомжтой гаргаж тавих, шаардлагатай бол эх сурвалжаар дахин тайлбарлуулахад гэмгүй. Мөн тухайн нөхцлийг нь сайтар бэлтгэж өгөх ёстой. Ингэснээр уншигч, үзэгчдэд болж байгаа үйл явдлын өрнөл, үүсэх нөхцөл байдал, үр дагаврыг ойлгуулна. Мөн түүнчлэн үйл явдалд хамаатай этгээдүүдийн тухайн үйлдлийг хийсэн шалтгаан, арга зам, гарц боломжийг нь харуулсан мэдээлэл өгнө.

Параграф буюу хэсэгчлэн бичих нь

Параграф буюу хэсэг болгоныг бичил өгүүлэл гэж ойлгож болно. Параграф гэдэг нь таны хийсэн бүтэн сурвалжилгыг нэг өнцгөөс нягтлаад, тухайн багц сэдвийг үзэгчдийн хүлээн авах чадварт нийцүүлэн жижиг хэсгүүдэд хуваасан бүтээгдэхүүнийг хэлнэ. Параграф нь үзэгчдэд юу хүргэхийг зорьж байгааг танилцуулсан эсвэл өмнө нь өгүүлсэн хэсэгтэй холбоотой сэдэв өгүүлбэрээр эхэлнэ. Параграф болгон дараах бүрэлдэхүүнтэй байх ёстой.

- (a) Үндэслэл (тоо баримт, эшлэл, нотолгоог)
- (b) Тодорхойлолт буюу тайлбар
- (c) Сэдвийн оршил агуулга, хүүрнэл, харьцуулалт буюу эсрэгцүүлэл
- (d) Шалтгаан, үр дагавар
- (e) Дэмжих, няцаах нотолгоо
- (f) Дүгнэлт, шинжилгээ, үр дагавар

Өдөр тутмын сонинд ажилладаг сэтгүүлчид хүүхэд байхдаа хийж байсан шиг бичихээсээ өмнө төлөвлөх, параграфын зохиомж, зохион байгуулалтыг хийх дасгалыг мартсан байх нь элбэг. Иймээс заримдаа өдөр тутмын сонины эрхлэгчид нийтлэлийн зай талбайн хэмжээнээс шалтгаалж үндсэн параграфыг өөрчилж, зайг шахах, нэмэх, хасах, догол мөрийг өөрчлөх зэргээр ихээхэн засвар хийхэд хүргэдэг. Гэхдээ үүнд санаа зоволтгүй. Ямар ч мэдээг өрөх тоосго нь параграф гэдгийг санахад л хангалттай. Өөрөөр хэлбэл мэдээг анхнаас нь бичихдээ параграфын зохион байгуулалтаар бич, эрхлэгчид дараа нь зай талбайн асуудлыг шийдэх болно.



Мэдээнд эшлэл ашиглах нь

Мэдээг дуусгах эсвэл шинэ мэдээлэл нэмэх гэж ишлэл ашиглах хэрэггүй. Харин, үндсэн санаагаа илэрхийлэхийн тулд ишлэл ашигла. Тоо баримттай, энгийн мэдээлэл хүргэхэд эшлэл ашиглахаас аль болох зайлсхий. Эх сурвалжтай ярилцсан гэдгийг илэрхийлэх зорилгоор ишлэл ашиглаж болно. Гэхдээ эх сурвалжийн хэлсэн үгэнд хийх дүгнэлтийг дан ганц ишлэлээр орлуулах нь хангалтгүй.

Эрэн сурвалжлах сэтгүүл зүйд доорх тохиолдлоос бусад үед тухайн эх сурвалжийн хэлсэн үгийг яг хэвээр нь ишлэл болгон ашиглах ёстой гэж үздэг. Үүнд:

- ▲ Хэлсэн үг нь ойлгомжгүй, яриа нь буруу ойлгогдохуйц, эсвэл бичиж авсан яриа нь “хуурай” ямар ч сонирхолгүй байвал.
- ▲ Хэвлэлд нийтлэхээс хориглосон доромж утгайтайхараалын үг зэргийг ашигласан бол.
- ▲ “Сонсож бай...”, “Мэдээжээр... “Миний бодлоор ...” гэх мэт тухайн ярианд хамааралгүй сул үгс байвал.

Бүх ишлэлийг холбож дурдана, өөрийн биеэр олж сонсоогүй ишлэл бол заавал эх сурвалжийг дурдана. Эрэн сурвалжлах мэдээнд ишлэл болон эх сурвалжийг хооронд нь холбох нэн чухал. Учир нь уншигчид үндэслэлийг эх сурвалжаар дүгнэнэ. Түүнчлэн мэдээнд шинээр “өгүүлэгч” орж ирж байгаа бол тун ойлгомжтой байдлаар харуулах хэрэгтэй. Хэрвээ эх сурвалжийг дурдах боломжгүй бол учир шалтгааныг тайлбарлана. Жишээлбэл сурвалжилсан этгээд маань “Та бүхэнд энэ мэдээллийг дэлгэсний төлөө компани намайг халах байх” гэж өгүүллээ гэх зэргээр илэрхийлж болох юм.

Ишлэлийг зөв сонгож, ашиглахад дараах зүйлсийг санаж яваарай. Үүнд:

- Ишлэлийн өмнөх өгүүлбэр нь тухайн ишлэлийг танилцуулж, уншигчдад ойлголт өгөх.
- Ишлэл нь танилцуулгын хамт нэг утга санааг уншигчдад өгөх зориулалттай.
- Ишлэл нь мэдээнд үнэ цэнэ нэмэхээс бус ямар нэг шинэ “амт, хачир” нэмэх ёсгүй. Хэлсэн үг байгаагаараа л бичигддэг бөгөөд утга давтсан ишлэлийг ашиглах ёсгүй.
- Ишлэлийг шууд “тэр хэлэхдээ, хэлсэн” зэргээр дурьдсан нь дээр. “Тэр мэдэгдэв, батлав, гэж мэтгэв” гэх зэргээр илэрхийлбэл уг санааг гажуудуулж, шаардлагагүй төөрөгдөлд оруулж мэднэ. Бат итгэлтэй байгаа үедээ л ийм хачрыг нэмж болно.
- Хэлсэн үгийг нь шууд ишлэхгүй, утга санааг нь найруулан илэрхийлэхээр бол уг хэлсэн ярианы өнгө, санаанаас нь бүү гажуудуулан засаарай. Жишээлбэл эх сурвалж “Бидэнд төсөв алга” гэж хэлснийг засан найруулахдаа “Тэрээр компани нь энэ төсөлд төсөв зарцуулах бэлтгэлгүй байна гэж өгүүлэв” гэсэн байдлаар хувиргавал санхүүгийн нөхцөл байдлыг илтгэх бус тэдний хандлагыг илэрхийлэх асуудал болчих магадлалтай.

Ноороглоод дахин бод

Энэ үе шатанд та хэдийнэ цуглуулсан бүх мэдээллээ хэд хэдэн хэсэгт хуваагаад, эх сурвалжийн хэлсэн ишлэл, судалгааны мэдээллийг ангилсан байх юм. Харин одоо ноороглож эхлэх цаг. Эхний нооргийг хүмүүс ихэвчлэн буруугаар ойлгох нь бий. Эхний ноорог бол эцсийн бүтээгдэхүүн огт биш бөгөөд ерөнхийдөө мэдээ байдлаар бичигдэхийг төлөвлөсөн, цаашид юу нэмж хийх шаардлагатайг ойлгож тодорхойлох зориулалттай хар зураг гэж үзэж болно. Энэ үед эхлэл хэсгээ хэрхэн бичих, сайн төгсгөл гаргах, уран яруу үг хэллэг хийх зэрэгт санаагаа чилээгээд хэрэггүй. Энэ үед засвар хийхэд биш мэдээгээ цаасан дээр буулгахад гол анхаарлаа хандуул. Та өмнөө тавьсан цаасан дээр бүх мэдээллээ нэгтгэн өрж байна гэж төсөөлөөрэй.



Мэдээний бүтэц ба хэв маяг

Эрэн сурвалжлах гэлтгүй аливаа мэдээнд үндсэн гурван бүтэц бий:

- (1) **Он дарааллын** – Үйл явдал цаг хугацааны эрхээр задардаг, үйл явдлын дараалал, үйлдлүүд нь эрэн сурвалжилгын баримт болдог
- (2) **Хүүрнэл өгүүллийн** – Нэг үйл явдлыг тодорхой хугацааны туршид дагадаг, үйл явдал ойлгомжтой болтол эрэн сурвалжилга хийдэг.
- (3) **Процесийн буюу үйл явцын** – Яг ямар үйл явдал гэдгээс шалтгаалж асуудал, баримт нотолгоог нь хөнддөг.

Олдсон мэдээллүүдээ гол асуудал, хамааралтай оролцогч этгээд, зөрчилдөөн, болон ололт, илрүүлэлт гэсэн хэсэгт хувааснаар бичих ажил эхэлнэ. Харьцангуй жижиг, богино хэмжээний эрэн сурвалжлах мэдээнд дээрх хэсгүүдийг эхлэл, төгсгөлтэй бичихэд хангалттай.

Эрэн сурвалжлах сэтгүүл зүйд чамин тансаг, уран зохиолоос илүү асуудал, баримт уншигчдад хэрэгтэй. Эрэн сурвалжлах мэдээг хэрхэн бичих тал дээр бичгийн мастеруудын зөвлөсөн олон янзын арга зам, жор байдаг. Эрэн сурвалжилга өөрөө мэдээллийн хувьд энгийн мэдээнээс илүү ярвигтай тул зохих бүтэц, эмх цэгцэд оруулснаар уншигчдад хүргэх нь тэдэнд эмх замбараагүй мэдээллийг зөв шүүн тунгаахад тус болно.

Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хамгийн түгээмэл гурван бүтэц:

(А) ‘Уолл Стрийт Журнал’-ын дүрэм:

1. Тухайн сэдэв болоод асуудлыг уялдуулахын тулд хэн нэг хүн эсвэл нөхцөл байдлаар эхлүүлэх,
2. Хувь хүний жишээнээс асуудлыг ургуулан өргөн цар хүрээгээр авч үзэх, ингэхдээ хувь хүн, сэдвийн хамаарлыг харуулсан ‘нат граф’ загварыг ашиглах,
3. Жишээ рүүгээ хүнд хүрэхээр өгүүлэмжтэйгээр шилжиж орох, тэсрэлттэй төгсгөл хийх.

(В) Америкийн бичгийн мэргэжилтэн, Кэрл Ричийн хөгжүүлсэн ‘High Fives’ дүрэм:

1. Мэдээ (Юу болсон эсвэл юу болоод байгаа вэ?)
2. Суурь агуулга (Нөхцөл байдал нь ямар байгаа вэ?)
3. Цар хүрээ (Энэ асуудал орон нутгийн шинжтэй юу эсвэл үндэсний хэмжээнийх үү?)
4. Хязгаар (Асуудал хаашаа чиглэж байна вэ?)
5. Нөлөө (Уншигчдад ямар хамаатай гэж?)

Энэ бүтцийг ашиглахад дээрх онцолсон таван хэсгийг хооронд нь уялдуулж, уусгаж өгөхийн тулд сайн бичих авьяас шаардагдана. Эс чадваас, таван тусдаа мэдээ шиг харагдах болно. Энэ бүтэц нь уншигчдад урт хэмжээний мэдээг зохимжтой хэлбэрээр ялган харуулах боломжтой тул цахим мэдээнд илүү тохиромжтой.

(С) Пирамид

Уламжлалт мэдээнд урвуу пирамидын дүрэм буюу гол санааг эхэнд нь, дэмжлэг, жишээнүүд дараа нь гэх зарчмыг баримталдаг бол эрэн сурвалжлах мэдээнд пирамидийг эргээд зөв хэлбэрээр нь ашиглаж байна. Өөрийн олж илрүүлсэн бүхнээ уншигчдад хүргэхдээ доорх зарчмыг баримтална:

1. Болсон үйл явдлын хураангуйгаар мэдээ эхэлнэ
2. Зарим хэлэх гэсэн санаагаа задална
3. Эрэн сурвалжилгыг алхам алхмаар ургашлуулна, энэ зуур хүлээлтийг бий болгосноор мэдээг хамгийн чухал нээлтийн зүг аажмаар чиглүүлнэ. Яг л нэг тайлагдашгүй уран зохиол, эсвэл шинжлэх ухааны нээлтийн талаар бичих гэж байгаа мэт байна.
4. Хамгийн ноцтой чухал нээлтийг хамгийн сүүлд өгүүлнэ.

Эдгээр зөвлөмжид уран зохиолын бичлэгээс авах санаа ч багтсан болно. Хэдийгээр та шууд уран зохиол бичээгүй ч гэсэн зохиол бичихэд шаарддаг арга барилыг ашиглаж байна гэсэн үг. Тэгээд ч бүх сэтгүүлч л ямар нэг үйл явдлыг өгүүлэгчид гэдэг утгаараа зохиол туурвигчид биш гэж үү? Өөрийгөө сайн бас жинхэнэ үйл явдлын өгүүлэгч гэж харах нь бидний хүүрнэн өгүүлэх сэтгүүл зүй гэж нэрлээд байгаа орчин цагийн мэдээний үндэс юм.

Зохиолч Сюзан Итоны өгүүлснээр,

Хүүрнэн бичигчид хийж байгаа ажлаа бүрэн өөрсдөө хариуцдаг. Үйл явдлын дарааллаа бодож, жижиг хэсгүүдийг нэгтгэн том зургийг бий болгоно. Асуудлыг хэд хэдэн өнцгөөс бодож үзсэн байдаг. Сэдэвтэйгээ уялдсан судалгааны ажил ч уншина. Энэ бүгдийг нийлүүлээд уншигчдад хүргэхэд бэлэн болгоно. Тийн хүргэхдээ утга учиртай байлгаж, дарааллыг

баримтална. Энэ бүгдийг хийж чадваас эргээд танд асуудлын аль нь сайн муу гэж шууд дүгнэх эрх биш ч гэсэн гол учгийг гаргаж харуулах эрх олддог. Гэхдээ энэ нь редакторын засвараас өөр асуудал. Та өөрийгөө учиг явдалд төөрөлдсөн олон хүнд гарцыг харуулж байгаа хөтөч гэж ойлгоход болно.

Дээрх 2 тодорхойлолт хоёулаа хүүрнэн өгүүлэх аргыг эрэн сурвалжлах сэтгүүл зүйд хамгийн тохиромжтой мэт харуулжээ. Гэхдээ анхаарах нэг зүйл бий. Америкийн эрэн сурвалжлах сэтгүүлч Денни Шехтер, Иракийн дайны тухай өгүүлсэн “Үй олноор хуурах зэвсэг” нэртэй кинондоо үйл явдлыг хүүрнэн өгүүлэх аргын сул талыг ийн өгүүлжээ. Нэг хүнд хэтэрхий төвлөрсөн үйл явдлыг өгүүлэх гэсээр байгаад Америкийн зарим хэвлэл мэдээллийнхэн асуудлын цаад том хүрээг нь олж хараагүй аж. Гэхдээ ингэлээ гээд хүүрнэн өгүүлэх арга муу гэсэн үг биш. Гагцхүү энэ аргыг хэрэглэх бол нөхцөл байдалдаа тохиромжтой эсэхийг нягталж, маш чадварлаг хийгээд мэдрэмжтэйгээр гүйцэлдүүлэхийг сануулж буй хэрэг юм.

Сэтгүүл зүйн дараах хүүрнэн өгүүлэх арга хэрэгсэл байна:

■ **Хөрөг ба дүр зургийг бий болгох:**

Хэрвээ та Уолл Стрийтийн аргыг сонгохоор байвал нийт эрэн сурвалжлах ажиллагааны туршид маш няхуур ажиллах хэрэгтэй болно. Юуны түрүүнд уншигчиддаа итгэл үнэмшил төрүүлэхүйц эх сурвалж, үзэгдэл сонгож авна. Гэхдээ энэ нь юм болгоныг дүрсжүүлж баримтжуулж аваад бай гэсэн үг биш, харин өгүүллийг чинь баяжуулах цөөн тооны чанартай гол зүйлсийн барьж ав гэсэн үг юм.

■ **Сэжүүр:**

Үйл явдлыг хүүрнэж байхдаа анхнаасаа уншигчдад энэ бүхэн хаа хүрэхийг ойлгуулсан гол сэжүүрүүдийг өгсөн байх нь зүйтэй. Ялангуяа мөнөөх пирамидын загварыг ашиглавал ийм шаардлага тун их. Төгсөх хүртлээ уншигчийг залхаахгүй, хүлээлттэй байлгах учир сэжүүрийг хэрэглэх ёстой юм.

■ **Хурд, бүтэц, үг:**

Бичих урлагт зохиолын өрнөлийн хурд чухал. Ямар үг бүтэц сонгосноос шалтгаалж зохиол хэр хурдан удаан хөврөх нь тодорхой болно. Товч өгүүлбэр, үгийн сонголт зохиолыг хурдан өрнүүлнэ. Урт бол арай удаашруулна. Нэг параграфад хэтэрхий их онолын мэдээлэл багтаавал өгүүлбэр нь богино байсан ч уншигчийн унших, ойлгох хурд саарна. Хэтэрхий нуршуу эхлүүлбэл, сурвалжилга дуусахаасаа өмнө уншигчийг залхаана. Энэ үгийг нэмлээ гээд мэдээнд үнэ цэнэ нэмэгдэж байна уу гэж өөрөөсөө ямагт асууж байгтун. Шаардлагагүй үгсийг үргэлж хасах нь зөв.

Бичсэн сурвалжилгаа өөрөө өөртөө уншиж өгвөл хурд, өрнөлийг өөрөө мэдэрч чадна. Мэдээ хаанаа хэцүү, ойлгоход төвөгтэй нуруу болж байгаа нь ч мэдрэгдэнэ. Өөрийн тань чих хамгийн мэргэн хянан засварлагч байх бөгөөд бичгийн үндсэн чадвараасаа гажсан, хэллэг тань ойлгомжгүй, урт, буруу байгаа тохиолдолд соргоогоор олоод мэдчихнэ. Мэдээгээ харилцан яриа мэт, тэр нь уншигч та хоёрын хоорондох ойлголцлын асуудал яриагаар болж байгаа мэт өнцгөөс харж бичихийг хичээгээрэй. Гэхдээ ярихад дуу хоолойны өнгө, биеийн хэл, нүдний харц, царайны хувирал гээд бичгээр илэрхийлэх боломжгүй олон хүчин зүйлс ордог болохоор бичих ажилд илүү зүтгэл орж байж л сая санааг илтгэнэ. Дүрмийн алдаагаа засаад, цэг таслалаа зөв ашиглаж, цаасан дээр үлдэх мэдээ төдий биш хэн нэгний амнаас гар, нүд, царайны булчинг ашиглан хэлэх үг гэж бодон давс хужрыг нь тааруулах нь зүйтэй



Дүрслэн сэтгэх нь

Хүүрнэн өгүүлж байхдаа дүрслэн сэтгэж, эцсийн мэдээ бий болоход шууд өөрийн тань хариуцсан ажил биш ч гэсэн загвар, зураг дүрслэл чимгийг нь бас бодох хэрэгтэй. Яг л урьдчилсан гарчиг бодож олох мэт, ингэж эртнээс сэтгэж чадвал бичиж байгаа мэдээнийхээ ерөнхий дүр зургаас гажилгүй ажиллаж чадахад нэмэр болно. Жишээ нь тодорхой тоо баримтуудад ямар хүснэгтийн загвар хэрэглэх вэ гэдгээ бодох нь шаардлагагүй тоо баримтыг эртнээс танахад хүргэнэ.

Дүрслэн сэтгэх нь аливаа бичвэрт дараах ач холбогдолтой:

- Ямар нэг хүснэгт, тоон дүрслэл, график хэрэгтэй бол түүнийгээ эртнээс мэдэж бэлдэх боломж олгоно.
- Мөн багийн хүмүүс хэн нь мэдээгээ өрөх, хэн нь дүрс график дээр ажиллах мэтээр ажлаа хуваана.
- Энэ ажлын хүрээнд фото зураг хариуцсан ажилтантай хамтарч тухайн мэдээнд ямар зургууд хамгийн тохиромжтой гэдгийг олж мэднэ.
- Гарчигны хэсэгт зураг оруулбал мэдээний агуулгатай тун нийцэж, хүч нэмэх ба өөрт тань үгээр дүрслэх боломж олгоно.
- Уншигчид тань текстээс илүү дүрс, хүснэгтээс мэдээлэл хавсарч авч байж илүү сайн ойлгодог. Тэгээд ч нэг зураг мянган үгнээс илүү гэлцэх нь бий.



Холбоос ба төгсгөл

Бүхий л мэдээ сайн эхлэхийн зэрэгцээ сайн төгсөх хэрэгтэй. Ямар ч бичвэрийн хамгийн чухал хэсэг нь дээрх хоёр болно. Сайн эхлүүлж чадвал уншигчдыг татаж, юуны тухай өгүүлэх гээд байгаа ойлголтыг төрүүлнэ. Судалгаанаас үзэхэд эхлэл сонирхолтой биш аваас уншигч сэдвээс үл хамааран гүйцэд уншдаггүй байна. Яг үүнтэй адилхнаар төгсгөл гэдэг ямагт уншигчийн сэтгэлд хоногшдог хэсэг нь байдаг.

Эхлэлийг хэрхэн бичих вэ?

Хөрөг эсвэл үзэгдлийг бичих

Бүх мэдээ биш ч гэсэн мэдээний ерөнхий агуулгыг харуулсан нэг өгүүлбэр байх

Үр дүн. Тэгээд тэндээсээ бичвэр өрнөж болно.

Ямар ч тохиолдолд тэр мэдээний сэдэв юу гэдгийг хэлэхгүйгээр уншигчийг хэтэрхий чилээгээд хэрэггүй. Эхлэл нийт мэдээ сурвалжилгын 10 хувь байхад хангалттай. Гэхдээ хэтэрхий гол сэдвийг хойшлуулахгүй. Гол сэдэв хаана байна эхлэх тэнд л эхэлнэ, тийм ч их тоо баримтаар нуршиж эхлээд хэрэггүй.

Төгсгөлийг бичихэд ч энэ бүхэн хамаатай:

Тасархай төгсөлүүдийг эмхлэх (Дүрүүдэд юу тохиолдсон, эсвэл цаашид юу болох)

Сэдвийг дахин нэг багцалж, яагаад бид энэ асуудлыг анхаарах ёстойг сануулах

Хүмүүсийг бодолд хөтлөх төгсгөл хийх

Нөхцөл байдлыг дахин тодотгох. Асуудлыг дахин сануулж, тулгарч буй итгэл найдвар, бэрхшээл, холбоотой өрнөлүүдийг сануулах

Анх уншигчидтай уулзсан хүмүүс рүүгээ эргэж очин, хаалтын үгс хэлүүлэх

Зүгээр л төгсгөхийн тулд төгсгөл битгий бичээрэй. Цаг хугацаа харуулна гэж үзэгчдэд хэлэхээс зайлсхий. Та өөрөө эрэн сурвалжлагч атлаа ямар ч шийдэлгүйгээр орхих нь уншигчийн итгэлийг хөсөрдүүлсэн хэрэг.

Мэдээг хэлэхтэй дүйцэхүйц чухал нэг зүйл бол параграфаас параграфийн хооронд эсвэл хэсгээс хэсгийн хоорондох мэдээний шилжилт юм.

Энэ бүхнийг нэгтгэхэд доорх зүйлсийн анхаарууштай:


Сэдвээ тогтмол дурд

Санаануудаа хооронд нь уялдуулах, ойлгомжтой болгохын тулд зүйрлэл ашигла. Жишээ нь байгаль орчныг эрхтэн тогтолцооны систем болж ажилладаг хүний биетэй зүйрлэж болно.

Мэдээнд нэмэр болохуйц дүрс, биет, зүйр үг, эсвэл аливаа нэг наалдацтай зүйлийг мөн ашигла.

Ярвигтай нотолгоог ойлгуулах гэж зүдрэх үед энгийн үгсийг ашиглах нь уншигчдын ойлголтонд дөхөмтэй. Ижил санааг үргэлжлүүлж байгаа бол ТҮҮНЧЛЭН, утгын чиглэл өөрчлөгдөж байгаа бол ГЭВЧ, үйл явдал дарааллаж байгаа бол ТИЙМ УЧРААС, ТҮҮНИЙ ДАРАА гэх мэтчилэн чиглүүлэгч үгсийг зөв хэрэглээрэй.

Анхны нооргоо бичсэний дараа, мэдээ сурвалжилгыг бэлдэх явцад цуглуулсан арвин их мэдээллийн зарим нэг нь хоцрогдсон, шинэчлэгдсэн байх магадлалтай тул дахин нягтлах нь зөв. Мөн энэ хооронд холбоотой шинэ ололт нээлт, баримт гарч ирсэн байх ч боломжтой. Тиймээс дахин нэг цахим хайлт хийгээд үзэхэд гэмгүй. Гэхдээ хэвлэмэл мэдээг нийтлэхдээ тэр чигээр нь 2 баганад хуваагаад нийтлэх нь уншигдахад хэцүү. Тиймээс чиглүүлэгч үгнүүдийг догол мөрөөс урагш гарган байрлуулсан ч болно. Сайн сурвалжилга, сайн мэдээнүүдийг нэгээс илүү удаа засаж бичсэн байдаг. Бичвэртээ засвар хийнэ, хянана гэдэг нь “тансаглал” нэмэлт ажиллагаа биш ээ. Харин ч боломж таарвал заавал гүйцэлдүүлэх ажлын нэг хэсэг юм. Хэрвээ бичсэнээ өөрөө хянана гэдэг хэцүү санагдаж эхэлвэл, тэр ажилдаа туслах багийн гишүүн, хамтран зүтгэгч олоорой. Багаараа хийсэн ажил хамгийн сайн нь байдаг.



Телевизийн мэдээг хэрхэн бичих вэ?

Анхааруулга: Энэхүү зөвлөмж нь телевизийн мэдээг бичих цогц гарын авлага биш боловч телевизийн мэдээг зөв хэллэг, бүтэцтэйгээр өгүүлэн хүргэхэд тустай санаануудыг агуулсан болно.

Бүхий л телевизийн мэдээнүүд дүрс болон дуу бичлэг гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ. Гэхдээ яг ижил дүрс дуу нь нөхцөл байдлаасаа шалтгаалаад тэс ондоо утгыг илэрхийлэх боломжтой. Үзэгчийг мэдээг бүрэн ойлгож байгааг бататгахын тулд нэмэлт тайлбарыг ашигладаг. Туйлын ухаалаг бичигдсэн текст л гэхэд ердийн нэг дүрс зургийг тун шинэ өнцгөөс харах боломжийг үзэгчдэд олгоно. Радиод бол бичигдсэн мэдээн дээр нэмэлтээр өгүүлэх текст тухайн нөхцөлд хүч нэмж өгдөг. Харин телевизэд дүрс дангаараа мэдээний 85%-ийн нөлөөллийг үүрдэг. Уйтгартай тааруухан зургийг сайн бичсэн текст авч гарна гэж телевизийн мэдээнд байхгүй. Тиймээс дүрс, дуу хоёулаа телевизийн мэдээнд чухал үүрэгтэй. Үүнийг өөрөөр чихэнд зориулж бичих, зургаар бичих, дуугаар бичих гэж нэрлэх нь бий.

Эхлээд камерт үлдсэн дүрсээр мэдээгээ бэлд. Дараа нь нухацтай сонгосон үгсийг ашиглан текстээ бэлдээрэй:

- (a) Мэдээний хамгийн гол өнцгүүдийг цохон тэмдэглэ
- (b) Зөвхөн тодорхой нэг өнцөг харуулж байгаа дүрс, яриаг зөв хуваарилалттайгаар оруул
- (c) Үзэгчдийн анхаарлыг татах хэсгүүдэд онцгой ач холбогдол өг
- (d) Өөр өөр дүрс, яриаг хооронд нь уялдуулж, ямар дарааллаар өрнөж байгааг харуул
- (e) Дүрс яриаг нөхцөл байдалтай холбо
- (f) Ашигласан дүрс, яриаг өөр тайлбар, санаатайгаар дахин ашиглан харуулж болно. (гэхдээ сэдвээсээ хазайж, хэлтийж болохгүй)

Хөтлөгч сурвалжлагчид мэдээнийхээ ач холбогдлын дарааллыг мэдэж байх учиртай. Гэхдээ тэглээ гээд тэд бас үзэгчид, мэдээ хоёрын дунд байнгын тээг, саатуулагч мэт ажиллах ёсгүй. Мэдээнд тань үйл явдалд нэн чухал хамааралтай хүн байвал түүний яриаг мэдээний эхэнд оруулан багтааж болно.

Телевизийн нэвтрүүлэг, хэвлэмэл мэдээ хоёрын ялгаа:

- ▶ Уншигчид хэвлэмэл мэдээг дараа нь завтай үедээ эсвэл ойлгоогүй үедээ дахин дахин унших боломжтой. Телевизийн нэвтрүүлгийг тухайн агшиндаа амжаагүй бол ахиж үзэж завдахгүй байх нь бий.
- ▶ Хэвлэмэл мэдээний алдааг уншигчид олж харах магадлал өндөр. Нэвтрүүлгээр гарах бага сага алдааг харин анзааралгүй өнгөрөөх нь бий.
- ▶ Хэвлэмэл мэдээг уншиж байхдаа уншигч аль хэсэгт нь явж байгаагаа хараад л мэддэг бол телевизийн нэвтрүүлгийг шууд олж хармагцаа хаана нь явж байгааг таамаглахад хэцүү.
- ▶ Хэвлэмэл мэдээг уншиж байгаад завсарласан ч эргээд хаанаас ч төвөггүй эхэлж болно. Харин телевизийн мэдээг ухрааж үзэх эсвэл интернэтээс л хайх боломжтой.
- ▶ Телевизийн нэвтрүүлэг нь хөгжим, дуу, зураг ашигладгаараа үзэгчдэд итгэл төрүүлэх нь илүү (Энэ үнэн, би бүр зурагтаар харсан). Энэ утгаараа үнэн гэдэг ойлголтыг илүү хүчтэйгээр төрүүлж байдаг.
- ▶ Телевизийн нэвтрүүлэг гэдэг зөвхөн тухайн мөчдөө оршино. Подкастийг эс тооцвол телевизийн нэвтрүүлэг сонин шиг бариад суух бодит биегүй бүтээл билээ.
- ▶ Үзэгчийн урдуур жирэлзээд өнгөрдөг гэдгээрээ телевизийн мэдээнд төвлөрөх хэцүү. Энэ зуур үзэгчдийн тархинд урт хугацааны санамж үлдэхээс илүү тухайн үеийн сэтгэгдэл давамгайлдаг.
- ▶ Телевизийн мэдээнд өндөр түвшний мэдлэг шаардлагагүй гэхдээ олон талт ерөнхий мэдлэг хэрэгтэй.
- ▶ Телевизийн мэдээ үзэмжийн хувьд сонингийн саарал өнгөнөөс мэдээж хавьгүй дээр. Гэвч уншихад их цаг зарцуулах ч хэвлэмэл мэдээнээс илүү нарийн мэдээлэл авдаг.

Эдгээр шалтгаан, телевизийн нэвтрүүлэг, үзэгчдийнх нь шинж чанараас болоод телевизийн мэдээний хэллэг хандлага хэвлэмэл мэдээнээс өөр байдаг. Гэвч нөгөө талаар та маш их мэдээлэл, тоо баримтыг хязгаарлагдмал цаг хугацаа орон зайд хүнд хүргэх гэж байна. Тэр дундаас “од” баримт буюу хамгийн анхаарал татууштай баримтыг нь шүүрч аваад эрэн сурвалжлах ажлаа эхлүүлэх нь зүйтэй.

бидний тухай

“Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн гарын авлага” буюу (IJM) нь Конрад-Аденауэр сан (КАС)-ийн “Глобал Медиа” хөтөлбөрийн нэг төсөл нь бөгөөд Саб-Сахарын Африкийн Иохансбург, Азийн Сингапур болон Зүүн өмнөд Европын Софиа дах Медиа хөтөлбөрүүдийг оролцуулсан болно.

Энэхүү IJM гарын авлагыг эрэн сурвалжлах сэтгүүлчдийн мэргэжлийн болон бичлэгийн ур чадварыг дээшлүүлэхэд зориулан боловсруулсан бөгөөд хүнд нөхцөлд “хоточ нохойн” үүрэг гүйцэтгэх сэтгүүл зүйн төрлийг дэмжих зорилготой. Гол хүрэх үр дүн бол хөгжиж буй ардчилалын бүтэц, чадавх бэхжиж, ардчиллыг дэмжигчдийн цар хүрээ нэмэгдэхэд чухал нөлөө үзүүлэх учиртай. Энэхүү гарын авлагыг долоон жилийн өмнө Африк дах КАС “Медиа хөтөлбөр”-өөс гаргасан зааврын дагуу шинэчлэн сайжруулсан бөгөөд уг хөтөлбөр нь жилд дунджаар 30 орчим мянган хүнд үйлчилдэг байна. Гарын авлагын анхны хувилбар маш амжилттай, үр дүнтэй хэрэгжсэн нь КАС “Глобал Медиа” хөтөлбөрөөс дахин сайжруулж, хэвлүүлэх болсон гол шалгаан нь бөгөөд гарын авлагын агуулгыг олон улсын туршлага, арга зүйгээр баяжуулсан болно.

Африк, Азийн эрэн сурвалах сэтгүүлчид зарим үед ихээхэн хүнд хэцүү нөхцөл байдалтай тулгардаг бөгөөд гарын авлага ийм тохиолдолд хэрхэн ажиллахад чиглэсэн заавар, зөвлөгөөг онцгойлон оруулсан. Гарын авлагад хэвлэлийн эрх чөлөөг хаасан хууль эрх зүйн орчинтой, терроризмын эсрэг гэж нэрлэсэн бодлого, зохицуулалтын үед болон шударга бус уламжлалт тогтолцоотой, хязгаарлагдмал эх сурвалжтай үед сэтгүүлч хэрхэн ажиллахад чиглүүлэх, туслах дэмжих санааг тусгасан. “IJM” гарын авлага нь сургалтын нэг төрлийн модуль бөгөөд уншигчид өөрсдийн олж авсан мэдлэгээ бүлэг болгоны төгсгөлд байгаа асуултаар шалгаж, бататгах боломжтой. Түүнчлэн, уялдаа холбоо бүхий жишээ баримтыг оруулж өгсөн бөгөөд эдгээр нь үргэлж шинэчлэгдэж байгааг татан авч хэрэглэх боломжтой.

....

Конрад-Аденауэр сан (КАС) бол Германы улс төрийн сан юм. Энэ нь олон улсад ардчилал, шударга хуулийн тогтолцоо болон хүний эрхийг дээдлэх чиглэлээр мэдлэгийг түгээх, олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг. Тиймээс КАС нь чөлөөт, хараат бус хэвлэл мэдээллийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулан ажилладаг бөгөөд ингэхдээ улс төрийн намууд, парламент болон нийгмийн бүлэг, байгууллагуудаар дамжуулан сургалт, боловсролын үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Аливаа нийгмийн амжилт нь тогтвортой байдал, үр өгөөж болон элит давхаргын нээлттэй байдлаас шалтгаалдаг гэдэгт бид итгэдэг. КАС хариуцлагатай, ухамсартай ирээдүйн элитүүдийг үндэсний болон олон улсын хэмжээнд дэмжин ажилладаг.

....

ЦААШИД:

- ▲ Шинэчлэгдсэн мэдээлэл болон холбоосыг авах
- ▲ Ази, Африк, Зүүн өмнөд Европын туршлага
- ▲ Дасгалууд
- ▲ Нэмэлт унших судалгааг бидний цахим хуудаснаас хүлээн авна уу

www.investigative-manual.org

Анхны хэвлэл 2010 он

КАС Медиа хөтөлбөр, Саб-Сахарын Африк

60 Хиюм роуд, Данкелд 2196, Иоханнесбург, Өмнөд Африкийн Бүгд
Найрамдах Улс

© 2016 Конрад Аденауэр Штифтун, Media Programme Asia

34 Букит Пасо Роуд, Сингапур 089848 Сингапур

Утас: +65 6603 6181/ И-мэйл: media.singapore@kas.de

www.kas.de/medien-asien/en | facebook.com/media.programme.asia



Оюуны өмчийн хуулиар хамгаалагдсан. Энэхүү хэвлэлийг хуулбарлах болон бусад асуудлаар хэвлэлийн компани руу хандана уу. Энэ хэвлэлд нийтэлсэн баримт, хувь хүний үзэл бодол, гадны эх сурвалжаас ашигласан материал зэргийн хариуцлагыг гагцхүү тухайн бүтээлд хувь нэмэр оруулсан этгээдүүд хариуцах бөгөөд үүнд Конрад Аденауэр Штифтун сангийн журам, баримтлах үзэл санаа тусгагдаагүй байж болно.

www.investigative-manual.org

Саеид Назагат, Азийн КАС Медиа хөтөлбөр хянан тохиолдуулав.

Монгол телевизийн хамт олон орчуулж, Хэвлэлийн Хүрээлэнгийн багш нар хянав.

Дизайн, эх бэлтгэл: © Жулиане Свитала

